

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 8 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 10
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	11 - 88

- “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/*

12 - 70
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/*

70 - 87
- Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/*

87 - 88

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
8 дугаар сарын 20-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 18 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: З.Мэндсайхан, Н.Наранбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг;

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Цэвэгдорж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дарга З.Батбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Гантулга, Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Гантогтох, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Идэрцогт, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Х.Гэрэлмаа, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро

эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Ц.Эрдэнэбат, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх П.Мөнхбат, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ерөнхий санхүүч Ц.Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Нандингэрэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, С.Ганбаатар, Ж.Бат-Эрдэнэ, Б.Уянга, Ц.Мөнхбат, Ж.Батжаргал, Ц.Идэрбат, Л.Мөнхбаясгалан, П.Батчимэг, У.Отгонбаяр, М.Мандхай нарын тавьсан асуулгад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Бейсен: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн зорилгод доор дурдсан агуулгатай 3.3.4.2 дахь заалт нэмэх:

“3.3.4.2.Хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгохтой холбогдуулан зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлж хоршооны гишүүн малчинд олгосон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг төрөөс хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	7
Бүгд:	17

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөрт” 3.3.4.3 дахь заалт нэмэх:

3.3.4.3.Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хоршооны загвар төслүүдийг бэлтгэх, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.1.1 дэх заалтын “байгалийн төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөн, хамгаалалтын менежментийг сайжруулна” гэснийг “байгалийн төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулна” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, У.Отгонбаяр нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.3.7 дахь заалтын “үйл ажиллагааг дэмжин” гэсний дараа “, Үндэсний ногоон барилгын үнэлгээний систем нэвтрүүлж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Т.Аубакир, М.Мандхай, Ж.Бат-Эрдэнэ нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 88.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5. Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.4.2.Уур амьсгалын өөрчлөлт” зорилтод доор дурдсан агуулгатай 3.4.2.9 дэх заалт нэмэх:

“3.4.2.9.Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хот, суурин газруудад яндангүй бүс байгуулж эрчим хүч, усны ухаалаг хэрэглээтэй амины орон сууцны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 4

Бүгд: 17

76.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ж.Бат-Эрдэнэ нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 88.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6. Улсын Их Хурлын гишүүн А.Ундраагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.29 дэх заалт нэмэх:

“3.3.4.29.Малчдад эрчим хүчний хэмнэлттэй өвлийн жишиг сууцны загвар түгээж, мэдлэг олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, М.Ганхүлэг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “1.3.5.Төвийн бүс- “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”” гэсэн зорилтын гарчгийг “1.3.5.Төвийн бүс-“Эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэржилт, эрчим хүчний дэд бүс”” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.32 дахь заалт нэмэх:

“3.3.4.32.Сорт, сорилын төв, үрийн аж ахуйг дэмжиж, үрийн шинэчлэл хамгаалалтыг сайжруулан, гол нэр төрлийн тариалангийн үр үйлдвэрлэлд урамшуулал олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, М.Ганхүлэг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.31 дэх заалт нэмэх:

“3.3.4.31.Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчин, залуу малчид, тариаланчдыг бэлтгэх зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.33 заалт нэмэх:

“3.3.4.33.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн нөөц бүрдүүлэх хүрээнд жил бүр 100.0 мян.тн хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5

Бүгд: 17

70.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, Г.Ганбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын аудитын удирдлагын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн

газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дарга З.Батбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гантогтох, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Идэрцогт, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсувд, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Х.Гэрэлмаа, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын зөвлөх Б.Батхуяг, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн ахлах хянан шалгагч Б.Анар, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Ө.Ариунболор, мөн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Б.Энхжин, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах шинжээч Э.Цолмон, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Дэнсмаа, Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Г.Мөнхзул, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч Л.Хосбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч Т.Отгонжаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Д.Дэчин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ш.Батцэнгэл нар байлцав.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загжав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Ж.Батжаргал, Ц.Идэрбат, М.Мандхай, Байнгын хорооны дарга Б.Бейсен нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад нэмэлтээр тусгасан Малчин хоршооны зээл, Цагаан алт хөтөлбөрийн зээлийн хүүгийн дэмжлэгийг 10 тэрбумаар нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 11
Бүгд: 18
38.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Усны газрын дарга З.Батбаяр, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Н.Мандуул, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мөн яамны Төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Д.Дэнчин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 56 минут үргэлжилж, 21 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 85.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 14 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 8 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
11 цаг 18 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц 52.4 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Гишүүдийн ирцийг танилцуулъя.

Буланы Бейсен 3 дугаар тойрог ирсэн, Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог ирсэн. Ирсэнд орчихсон байна. Мөнгөнцогийн Ганхүлэг 6 дугаар тойрог ирсэн, Сонгобайн Замира жагсаалт ирсэн, Цагаанхүүгийн Идэрбат 6 дугаар тойрог ирсэн, Мэндбаярын Мандхай жагсаалт ирсэн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан 7 дугаар тойрог ирсэн, Ухнаагийн Отгонбаяр 6 дугаар тойрог ирсэн, Ренчинбямбаагийн Сэддорж ирээгүй байна, Агваанлуvsангийн Ундраа жагсаалт ирсэн, Болдын Уянгаа жагсаалт ирсэн. Ийм ирцтэй байна.

Хэлэлцэх асуудал танилцуулъя. Гурван асуудлыг хэлэлцэнэ. Өнөөдрийн хурлаар.

Нэгдүгээрт, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хоёрдугаарт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл.

Гуравдугаарт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл зэрэг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу?

М.Мандхай гишүүн саналаа хэлье. Саналтай гишүүн байхгүй байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалд орёе. С.Ганбаатар гишүүн ирсэн байна.

**Нэг. “Монгол Улсын Засгийн газрын
2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

/Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг,
санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэх асуудал танилцуулья.
Ажлын хэсэг ажлын хэсэг ирж байна уу?

Өнөөдөр энэ Байнгын хорооны
хуралд хоёр сайд оролцох ёстой.

Хөдөө аж ахуйн сайд ирчихлээ.
Байгаль орчны сайд Ерөнхийлөгчийн
уулзалттай. Нөгөө гадаадын улсууд
ирсэнтэй холбогдоод ирээгүй байгаа юм
байна.

“Монгол Улсын Засгийн газрын
2024-2028 оны үйл ажиллагааны
хөтөлбөр батлах тухай” Улсын Их
Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай
холбогдуулан хуралдаан зөрчиж байгаа
албан тушаалтнуудыг танилцуулья.

Монгол Улсын Засгийн газрын
хөтөлбөртэй холбоотой өнөөдрийн
хуралдаанд ирж байгаа албан
тушаалтнуудад танилцуулья.

Салдангийн Одонтуяа Байгаль
орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд,
Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн сайд, Х.Нямбаатар
Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын захирагч, Э.Баттулга
Байгаль орчин, уур амьсгалын
өөрчлөлтийн яамны Төрийн нарийн
бичгийн дарга, Д.Ганхуяг Батлан

хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн
дарга. Байна уу? Ирээгүй байна уу?
Хуралдаан давхцаж байгаа юм байна. Бас
танилцуулж л байя.

С.Төмөрхүү Хот байгуулалт,
барилга, орон сууцжуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч,
Х.Батжаргал Боловсролын яамны Төрийн
нарийн бичгийн дарга, Л.Мөнхтүшиг
Гадаад харилцааны яамны Төрийн
нарийн бичгийн дарга, Ч.Цэвэгдорж
Соёл, спорт, аялал жуулчлал,
залуучуудын яамны Төрийн нарийн
бичгийн дарга, С.Магнайсүрэн Аж
үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн
нарийн бичгийн дарга, Н.Тавинбэх
Эрчим хүчний яамны Төрийн нарийн
бичгийн дарга, Л.Энх-Амгалан Эдийн
засаг, хөгжлийн яамны Макро эдийн
засгийн бодлогын газрын дарга,
Д.Эрдэнэбаяр Эдийн засаг, хөгжлийн
яамны Бүс, орон нутгийн хөгжлийн
бодлогын газрын дарга, Б.Анар Эдийн
засаг, хөгжлийн яамны Хөрөнгө
оруулалтын бодлогын газрын дарга,
З.Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын
өөрчлөлтийн яамны Засгийн газрын
хэрэгжүүлэгч агентлаг, Усны газрын
дарга, Д.Гантулга Хот байгуулалт,
барилга, орон сууцжуулалтын яамны
Барилга, барилгын материалын бодлого
зохицуулалтын газрын дарга, Б.Болор-
Эрдэнэ Зам тээврийн яамны Төрийн

захиргааны удирдлагын газрын дарга, М.Мэндбаяр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Д.Гантогтох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга, Л.Идэрцогт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Г.Наранчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Н.Оюунсувд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга, Х.Гэрэлмаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, А.Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Б.Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга, Б.Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, О.Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Д.Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Ц.Эрдэнэбат Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх, П.Мөнхбат Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ц.Амгалан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ерөнхий санхүүч зэрэг улсууд оролцож.

Зарим улсууд хараахан ирж амжаагүй байна. Хурал давхцаж байгаа юм байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай тогтоолын төсөл 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байна уу? Нэрс өгөөрэй.

Эхлээд мөрийн хөтөлбөр шүү дээ. Ж.Батжаргал гишүүн байгаа юм байна. Тийм ээ. Ц.Идэрбат гишүүн, Л.Мөнхбаясгалан гишүүнээр тасалъя. У.Отгонбаяр гишүүнийг нэмж оруулчхаарай.

Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдээс ийм санал ирсэн. Асуулт асуух гишүүд. М.Ганхүлэг гишүүнээс эхэлье.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Мөрийн хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбогдолтой асуулт гэж ойлгосон.

Мөрийн хөтөлбөр дээр хөдөө аж ахуйтай холбогдолтой гол гол асуудлуудаас дийлэнх нь орсон байна лээ. Ялангуяа Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилгаар хэрэгжиж байгаа хоёр том хөтөлбөр.

Мөн дээрээс нь Засгийн газрын өнгөрсөн 4 сард санаачилгаар батлагдсан “Шинэ хоршоо” хөдөлгөөнүүд мөрийн хөтөлбөрт нэлээн тодорхой тусгагдсан байна лээ.

Өнгөрсөн хугацааны Засгийн газрын үед Хүнс, хөдөө аж ахуйн яаман дээр хийгдэж байсан хэд хэдэн давуу

талтай, илүү сайжруулж үргэлжлүүлэн ажиллах шаардлагатай хэд хэдэн ажлууд байгаа юм.

Үүний нэг нь хамгаалагдсан аж ахуйтай холбогдолтой. Мал эмнэлгийн хорио цээрийн эрүүл бүсүүдийг байгуулахтай холбогдолтой асуудлууд бас байгаа.

Энэ эрүүл бүс болон хамгийн сүүлд батлагдсан хамгаалагдсан аж ахуйтай холбогдолтой энэ асуудлуудыг нэлээн тодорхой тусгасан байдал нь яг ямар байгаа вэ?

Дээрээс нь мал эмнэлгийн талын үйл ажиллагааг цаашдаа нэлээн анхаарах шаардлагууд байгаа.

Тэр агуулгаараа мал эмнэлгийн агуулгууд нэлээн бага байна уу даа гэсэн ийм зүйлийг ажигласан.

Тэгэхээр цаашдаа ер нь бид экспортлогч улс үндэстэн больё, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг экспортольё гэвэл тодорхой хэмжээнд стандартуудаа бид бүхэн барих шаардлагатай.

Стандартуудаа барихдаа бид хоёроос гурван шатны стратегийг баримтлан ажиллая гэдэг ийм зорилттой ажиллаж байсан.

Хамгийн нэгдүгээрт улсаараа Дэлхийн мал эмнэлгийн байгууллагын “Эрүүл бүс” больё гэдэг энэ зорилтыг тавьж гоц салбарт томоохон өвчлөлүүдийг бид бүхэн улсаас тодорхой хэмжээнд вакцинжуулах ажлыг зохион байгуулж байгаа.

Энэ ажлын үргэлжлэх байдал, тодорхой зорилтын үр дүн, хүрэх байдал нь ямар байгаа вэ?

Хоёрт нь, бид Засгийн газрын хуралдаанаар Монгол Улсын хэмжээнд 5 бүс нутгийг, ялангуяа одоо хил дамнасан орчмын бүс нутгийг мал эмнэлгийн “эрүүл бүс” болгох тогтоолыг баталсан байгаа.

Энэ ажил цаашдаа үргэлжлэх үү? Ялангуяа энэ бүсүүд дээр бид бүхэн бүсчилсэн хэлбэрээр дэлхийн стандартад нийцсэн мал аж ахуйг хөгжүүлбэ гэдэг зорилт байгаа.

Хамгийн сүүлд батлагдсан журмаар аж ахуйнууд байж болох юм. Аж ахуйн нэгжүүд өөрсдөө мал эмнэлгийн хорио цээрийн эрүүл ийм аж ахуй гэдгээ баталгаажуулаад экспортлогч болох боломжуудыг олгоё гэдэг талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тодорхой журам гарсан байгаа.

Тэгэхээр эдгээр 3 үе шаттай экспортод чиглэсэн мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг эрүүл гэдгийг нотлох ажлууд энэ хөтөлбөрт зайлшгүй тусах шаардлагатай.

Тэгээд аль түвшинд туссан, ямар байдлаар ажиллахаар тооцож байгаа вэ гэдэг асуултыг асууя.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулах юм байна.

Ж.Энхбаяр: Гишүүдийнхээ амрыг айлтгая. М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

Бидний гол салбарын өмнөө тавьж байгаа томоохон зорилт бол **“Монгол**

мах” брэнд-ийг хөгжүүлэх, монгол махыг дэлхийн зах зээлд гаргах.

Үүний тулд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг хөтөлбөрт нэлээн суурьтай, углуургатай нь туссан.

Хамгийн түрүүнд мал эмнэлгээсээ асуудлаа эхэлнэ. Мал эмнэлгийн чанар, үйлчилгээг сайжруулах. Түрүүний бэлдсэн энэ 5 бүсийг **“мал эмнэлгийн эрүүл бүс”** болгох, улмаар бусад бүс нутгаас бэлтгэгдсэн мал энэ хамгаалагдсан бүс, хамгаалагдсан аж ахуйн нэгжээр дамжин эрүүл ахуй, мал эмнэлгийнхээ бүх шаардлага, үйлчилгээг хангаад, улмаар экспортод гаргах маягаар зохион байгуулалтыг хийнэ.

Бид яаралтай Био комбинатаа цоо шинээр шинэчлэх зайлшгүй шаардлага үүсэж байгаа.

Малын эм бэлдмэл, вакцины үйлдвэрлэлийг дотооддоо бүрэн хийх зорилт тавигдсан байгаа. Хөтөлбөрт.

Улмаар мал мах экспортлохын тулд бид нарт тэжээлийн баазыг улс орны хэмжээнд өргөтгөх шаардлага байгаа. Бүсчилсэн тэжээлийн аж ахуйнуудыг, тэжээлийн баазуудыг бий болгох. Тэгээд газар тариалангийн бүс нутаг дахь таримлын сэлгээнд тэжээлийн ургамлуудын нэр төрлийг олшруулж тарих ийм асуудал.

Мөн үйлдвэрүүдийг итгэмжлэх асуудлыг нэлээн эрчимтэй хийгдэж байна.

Сая хамгийн сүүлд Монгол Улсын махны нядалгааны гол гол үйлдвэрүүдийг **“халал стандарт”**-ыг үндсэнд нь нэвтрүүлээд Арабын орнууд, Төв Азийн

орнуудад гаргах зах зээлийг нэлээн боломжийн болгож байна.

Ингээд Монгол Улсын үйлдвэрүүд өөрөө **“халал стандарт”**-д хүлээж аваад нэгдээд ирэхээр тэр зах зээл нэлээн хөнгөлөлттэй буюу хязгааргүй гарах бололцоо үүсэж байна.

Мөн бүс бүсчилсэн лабораториудыг зайлшгүй сайжруулах хэрэгтэй болж байгаа. Лабораториудын чадавхыг Био комбинатын бодлоготой хамт бүсийн лабораториудын чадавхыг эрс нэмэгдүүлж байж манай экспорт нэлээн амжилттай явна.

Ер нь махны экспорт нэлээн боломжийн их эвтэйхэн байгаа. Анх удаа түүхэндээ бид ноднин **2023 онд 380-аад сая долларын мах экспортолсон.**

Нийт хөдөө аж ахуйн **манай салбарын ноос, ноолуур, арьс шир, мах** ороод **960 сая долларын** экспорт яваад байгаа юм.

Бидний зорилго энэ **экспортыг 2 тэрбум доллар, 3 тэрбум доллар болгох.**

Ингэхийн тулд яах вэ гэвэл эхлээд малын эрүүл мэндийн асуудал, лабораториудын чадавх, мал эмнэлгийн чадавх, Биокомбинатын чадавх. Ингээд хамгаалагдсан бүс нутгийг бодлогоор бий болгох, хамгаалагдсан аж ахуйн нэгжүүдийг бий болгох.../минут дуусав/

Б.Бейсен: Сайд нэмж хариулья.

Ж.Энхбаяр: Тэгэхээр хөдөө аж ахуйн экспортоо бид 2-оос 3 тэрбум долларт хүрэхийн тулд манай гол урдаа барьж байгаа зүйл бол махны салбар байгаа.

Ингэхийн тулд анхан шатнаас нь авхуулаад л эцсийн экспорт хүртэлх бодлогыг энэ хөтөлбөрт нэлээн сайн суучихсан. Тэгээд нэлээн шаардлагатай хөрөнгө оруулалт, бодлогууд бас төсөв болон тодотголуудаар нэлээн суучихсан.

Та бүхэн анзаарч байгаа хөдөө аж ахуй “**Шинэ хоршоо**” хөдөлгөөн гэдэг яг энэ махны салбарыг дэмжих бодлогын хүрээнд давхар хийгдэж байгаа ажил. Малчдаа хоршоолуулаад, анхан шатаас мал мах, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэлийг үйлдвэрлэлтэй нь хэрхэн холбох, дунд нь хөдөө аж ахуйн биржийг холбох ажлууд хийгдэхээр бэлтгэгдэж байна.

Б.Бейсен: М.Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Хамгаалагдсан аж ахуйтай холбогдолтой асуудлууд туссан байгаа. Үргэлжилнэ гэж ойлголоо.

Үндсэндээ зүүн бүс нутаг дээр хуучин нэлээн олон аж ахуйнууд байсан. Нийт мал сүргийн 20 гаруй хувь байгаа.

Бүсчилсэн хөгжлийн зорилтын хүрээнд эрчимжсэн хөдөө аж ахуйн чиглэлийн дэд зорилтыг зүүн бүс нутаг дээр оруулж ирж байгаа. Тэгээд тэр утгаараа бүс нутагтай холбогдолтой асуудал дээр би нэмэлт ямар асуудлууд орж байна?

Ялангуяа хамгийн их боомттой, тэгээд хаа байсан Дорнодын Халх голоос хэдэн мянган километр газар туулаад заавал наашаа ирэхгүйгээр цаашаа экспортод гаргах боломжуудыг олох чиглэл дээр цаашдаа яаж ажиллаж болох вэ гэдэг чиглэлийн юмнуудыг асуух нь зөв өө гэж бодож байна.

Ялангуяа энэ Халх голын бүс нутагт бүтээн байгуулалтын ажлууд хийнэ гэдэг төлөвлөлтүүд манайхан дээр байгаа. Энэ ажил үргэлжлэх үү, ямар түвшинд явах вэ гэдэг талаар тодруулъя гэж бодож байна.

Мөн Байнгын хорооны хурал дээр нэг тодорхой мэдээллийг гишүүдэд өгчихсөн нь дээр байх.

Энэ жилийн өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбогдолтой ямар ажлууд эхэлж байгаа вэ?

Мөн дээрээс нь өмнөх өмнөх жилүүдтэй харьцуулахад ямар өвөл болох нь вэ? Яаж ажиллах вэ? Үүний хариу арга хэмжээ болсон “Шинэ хоршоо” хөдөлгөөнтэй холбогдолтой тодотгол дээр би тодорхой саналууд хэлье гэж бодож байна.

Тэгэхээр зүүн бүс нутгийн өмнө нь төлөвлөсөн Халх голын бүтээн байгуулалтын ажлууд, хөдөө аж ахуйн чиглэлийн энэ ажлууд цаашаа үргэлжлэх үү?

Хил дамнасан хил орчмын малчдыг илүү экспортод гаргах энэ боломжуудыг олгох чиглээр хэдүүлээ яаж ажиллаж болох вэ гэдэг энэ тодорхой асуултуудыг асууя. Тийм. Нэмж.

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд хариулъя. 3 номер.

Ж.Энхбаяр: “Шинэ хоршоо” хөдөлгөөн улс орны хэмжээнд маш идэвхтэй өрнөж байна.

Энэ жил 500.0 тэрбум төгрөгийн эх үүсвэр тавигдсан. Үндсэндээ энэ эх үүсвэрүүд бараг бүрэн хоршоодод очсон.

Мөн дахин их хэмжээний хүсэлт, олон зуугаараа зохион байгуулагдаж байгаа хоршоологчид дахин эх үүсвэрийг хүсэж байгаа.

Тэгэхээр энэ асуудлаар Монголбанк, Сангийн яам хоёрт хүсэлт тавьсан. Шаардлагатай эх үүсвэрийг нэмэгдүүлэх нь зүйтэй.

Нэгэнт ингээд өрнөж байгаа энэ малчдынхаа ид хоршиж байгаа идэвхийг тэр чигт нь өрнүүлээд малчдаа нэг жалгын нэг тарсан биш хоршсон ийм аж ахуйн нэгжийн хэлбэрт зохион байгуулалтыг нь хангаад өгвөл тэр зохион байгуулалт дээр бид бусад түүхий эдийн бэлтгэл, энэ хөрөнгийн биржтэй нь, хөдөө аж ахуйн биржтэй нь холбох, үйлдвэрлэлтэй нь холбох, мал сүргийг эрүүлжүүлэх, бэлчээр хадлангаа хийх олон ийм үе шаттай ажлыг дараа нь эрчимжүүлээд явчих бололцоотой байгаа.

Хилийн боомттой холбоотой зөвхөн өнөөдрийн байдлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Замын-Үүд боомтоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, амьд малын экспорт яваа.

Бид энэ чиглэлээр баруун талдаа нэг гарц, зүүн талдаа нэг гарц гарах нь зүйтэй.

Мөн 12 сарын 01 гээд Оросын Холбооны Улс, хуучин нөгөө Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагатай Монгол Улс хоёр талын гэрээ хийх асуудал үндсэндээ шийдэгдсэн.

Ингэснээр бид Төв Ази болон Оросын Холбооны Улсын зах зээлд Монгол Улсын хөдөө аж ахуйн гаралтай 345 нэр төрлийн бараа татваргүй, бага

гаалийн татвартай, тарифын хязгаарлалтгүйгээр нэвтрэх гэрээ хийгдэхээр бэлтгэгдэж байгаа.

Хэрвээ энэ амжилттай болсон нөхцөлд Монгол Улсын манай хөдөө аж ахуйн салбарт их томоохон боломж, орон зай гарна.

Б.Бейсен: Сайдад 2 минут дахиад өгчихье. Хариулахаар.

Ж.Энхбаяр: Халх голын бүс нутагт 500 мянган га талбай улсын тусгай хэрэгцээнд байгаа.

Энэ манай Монгол Улсын хөдөө аж ахуйн гол нөөц нутаг. Яг өнөөдрийн байдлаар энд хэрхэн Халх голын бүс нутгийг хөгжүүлэх вэ гэдэг асуудал эцэслэн шийдэгдээгүй байгаа. Нэлээн маргаантай байгаа.

Үүнийг тайлбарлавал нэлээн цаг хугацаа орно.

Ер нь ойрын үед Байнгын хороондоо Хөдөө аж ахуйн яам иж бүрэн танилцуулгыг хийхээр бэлдэж байна.

Тэгэхээр ээлжит бус чуулганы төгсгөл рүү бид орж ирээд нэг сайхан танилцуулга, мөрийн хөтөлбөртэй холбоотойгоор танилцуулаад хийж байгаа ажил, бодлого, боломж, хөрөнгө оруулалт, төсөв гээд танилцуулна.

Ер нь салбарын бодлогууд 3 багцад гарчихсан.

Малчид нэг том зохион байгуулалтад орсон. “Шинэ хоршоо”.

Тариаланчид, ногоочдоо зориулсан “Атрын-IV” аян.

Үйлдвэрлэгчдээ дэмжих зорилгоор “Цагаан алт” гэсэн 3 том багц хөтөлбөр гарчихсан.

Энэ хөтөлбөрийн хүрээнд манай бүх асуудлууд үндсэндээ задраад ороод ирнэ.

Ер нь бодлого их тодорхой болсон. Хийх ажил нэлээн бодитой. Холбогдох хуулиуд нь нэлээн сайн дагалдаад гарчихсан. Эх үүсвэрүүд нь нэлээн сайн явагдчихсан.

Ер нь ирэх жилүүдэд хөдөө аж ахуйн салбарт нэлээн өрнүүн бүтээлтэй ийм байхаар байгаа.

Өвөлжилтийн байдал, өвөлжилтийн бэлтгэлийг хангах Засгийн газарт асуудлаа хэлэлцүүлсэн. Засгийн газраас тогтоол гаргаад аймаг, орон нутаг, бүх яам, Тамгын газар үүрэг даалгаврууд өгчихсөн. Бэлтгэлээ уламжлалт байдлаараа хангаж байна.

Энэ жилийн нэг онцлог нь үр тарианы болц 2 долоо хоногийн өмнө эрт болж байна.

Тэгэхээрээ ер нь цаг агаар эрт сэрүүн өсөх ийм хандлага байна. Цаг уурын мэдээгээр хур тунадасны хэмжээ өвөл нэлээн өндөр орно.

Хангайн бүс нутагт нэлээн гангийн байдал өндөр байсан. Мал сүрэг авах ёстой тарга тэвээргээ авч чадаагүй байгаа.

Иймд нөөцийг бүрдүүлэх, тэжээлийг эртхэн шиг бэлтгэх, хангах асуудлыг зохион байгуулах нь ахиад л том зорилт.../минут дуусав/

Б.Бейсен: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.12 дахь хэсэгт гишүүний асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй. Нэмэлт асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 2 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж тайлбар авч болно гэсэн заалт байгаа. Үүнийг сануулчихъя.

Хариулах хугацаа 39.13 дахь хэсэгт гишүүний асуух хугацааг 3 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа тус бүр 2 минутаас илүүгүй байна гэж заасан байна Үүнийг анхааруулчихъя.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Хүнс, хөдөө аж ахуйн яам, үе үеийн яамд хичээж чармайж л ажилласан байх.

Тэгэхдээ л уламжлалт мал аж ахуйн салбар тэр чигээрээ элгээрээ хэвтчихлээ шүү дээ. Үүний үр дүнд. Бүгдээрээ хичээсэн байх.

Тэгэхдээ л мал аж ахуйн түүхий эдүүд өнөөдөр ямар ч үнэ цэнгүй болсон. Малчин хүний хөдөлмөр үнэгүй болсон. Энэ дээр ямар дүгнэлт хийж байгаа вэ? Ер нь юун дээр алдчихав. Бид юу өөрчлөх ёстой вэ? Арьс, шир энэ Хөдөө аж ахуйн яамны бодлогоос болоод уначихсан.

Өмнөх улсууд хичээсэн байх. Өнөөдөр Ж.Энхбаяр сайдад би итгэж байна. Төрийн туршлагатай нийгмийн зүтгэлтэй очсон учраас эндээс үр дүн гарна гэж итгэж байгаа учраас би ингэж итгэж байгаа хүн л ярина шүү дээ.

Хоёрт нь, Хөдөө аж ахуйн яам том том тариаланчдын компаниудыг дэмжилгүй л яах вэ? Тэрийг ч гэсэн би дэмжиж байна. Тэгэхдээ 200 гаруй мянган өрх, аж ахуй Монголын эдийн засгийг авч яваа уламжлалт мал аж ахуйгаа ерөөсөө додомдохгүй байна. Энэ дээр би тодруулж асууя.

Одоо жишээ нь, 5 бүтээгдэхүүн байгаа. Дайвар бүтээгдэхүүн. Яагаад жалгаар нэг хаягдаж байгаа юм. Яагаад. Энэ дээр ямар алдаа хийсэн юм? Ямар алдаа гаргав? Тэгээд яах гэж байгаа юм?

Энэ дээр “нөөцийн мах” гээд мафидаа баригдчихсан. Нөөцийн маханд ордог улсууд улс төрчдөд танил хүмүүс л ордог гэж би ойлгодог.

Яг жирийн малчин хүн дээр тэр эрх ашиг нь очиж байна уу? Жишээ нь, тэр Хятад руу мах гаргана гээд л нэг баахан сертификат л зараад байдаг. Одоо бүр зүгээр тамга зардаг болсон. Ерөөсөө ил ярьж байна шүү дээ.

Энэ асуудлыг таслан зогсоогоод ямар арга хэмжээ авах гэж байгаа вэ? Нэгдүгээрт. Хоёр асуулт юм даа.

Дараачийн асуулт. Би өөрийн тойрогтой холбогдуулаад асууя.

Хангайн бүсийг уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн дэд бүс болгоно гээд заачихсан байгаа юм. 1.3 дээр. Одоо энэ үйл ажиллагааны хөтөлбөрт.

Тэгсэн тэгээд л **“Шинэ Хархорум”** гээд л баахан Хархорум л ярьсан. Орхон гол дээр ийм гоё кластер барина. “Шинэ Хархорум” гэсээр байгаад л дуусчихсан.

Уламжлалт мал аж ахуйн заалт энэ 5 заалт дотор хамгийн сүүлчийнх нь байгаа юм.

Байдрагийн усан цахилгаан станц байна шүү дээ. Бас дэд бүтэц.

Уламжлалт мал аж ахуйн талаар яг энэ дээр юу хийх вэ? Жишээ нь, “Нутгийн хөгжлийн төвүүдийг барина” гээд энд заачихсан байгаа. 1.3.1.4. Яг хаана хаана юм? Та нар ТЭЗҮ, тооцоо судалгаа чинь байгаа юу? Би 3 дахь асуултаа асууж байна.

Тэгэхээр уламжлалт мал аж ахуй буюу малын гаралтай түүхий эд, дайвар бүтээгдэхүүн, малын гаралтай сүү сааль, мах.

Өнөөдөр 150-иас 200 мянга хонь байна. Эрээн дээр л 800 гэж байна шүү дээ.

Яагаад ийм байгаа юм. Танай бодлого зөв яваад байгаа юм уу? Энэ дээр ямар арга хэмжээ авах вэ?

Дараагийн зүйл гэвэл 3.3.4.20 гэж байна. Бэлчээрийг нөхөн сэргээх, сэлгэх, тарималжуулах, хамгаалахдаа усжуулах, ургамал хамгаалал гээд нэг баахан юм бичсэн байна.../минут дуусав/

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Мал аж ахуйн салбарт Монгол Улс ямар бодлогын алдаа хийчхэв гэж.

Үнэхээр бодлогын томоохон алдаа гарчихсан. Хэд хэдэн зүйлээр их ноцтой илэрч байгаа.

1990 онтой харьцуулахад бодын үхэр дээр ирж байгаа юм. Амьдын жин 30-аас 40 килограм, бог 6-аас 8 килограммаар давжаарсан. Энэ нийт Монгол Улсын мал сүргийн хэмжээнд.

30 жил Монгол Улс системтэйгээр малын үржил селекцийг сайжруулах ажил хийгдээгүй. Үндсэндээ мал, хувийн өмч, малчны хөрөнгө гэж үзсэн.

Ингээд тэр үржил селекцийн ажлыг малчид өөрсдөө хийнэ гэж орхисон. Үүний үр дагаварт малын тэр омог угсаа, шинэ үүлдрийг гаргах ажил үндсэндээ зогссон.

Үүнтэй холбоотой мал аж ахуйгаас гарч байгаа түүхий эдийн бүтээгдэхүүний гарц, чанарт маш томоохон өөрчлөлт гарсан.

Гарч байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэйгээ холбогдоогүй. Үйлдвэрлэлийн технологи, шаардлагатай тэр түүхий эдийг бэлтгэх, нийлүүлэх энэ хоёр бодлого хоорондоо зөрсөн.

Ингээд үйлдвэрлэлгүй мал аж ахуй, түүхий эдгүй үйлдвэрлэл болсон.

Улмаар хөдөө аж ахуйн гаралтай гол бүтээгдэхүүн боловсруулдаг үйлдвэрүүдийн 90 гаруй хувь нь үндсэндээ ингээд дампуурцгаасан.

Мал өөрийн зөнгөөр тоо толгой нэлээн өссөн. Нэгэнт нэг малаас авах ашиг шим багасаад ирэхээр тоогоороо явсан. Тоо нэмээд ирэхээр бэлчээрийн даац эрс нэмэгдсэн.

Бэлчээрийн даац нэмэгдээд бэлчээрээ талхлаад ирэхээр идэвх сайтай ургамлын тоо хэмжээ багасаад, одоо 1 метр квадрат талбайд 30-аад төрлийн

ургамал ургадаг байсан. 1990 онд. Одоо 5-аас 6 төрөл болсон.

Ингээд мал зуныхаа тэр бэлчээрийн үед авах ёстой шим тэжээлээ авч чадахаа больсон.

Ингээд ирэхээр мал давжаарч эхэлж байгаа, биеэ хурааж эхэлж байгаа юм.

Шим тэжээл, тарга хүчээ авч чадахаа болиод ирэхээр эмзэг болж байгаа юм.

Зөвхөн өнгөрсөн өвлийн том ноцтой сануулга **8.1 сая мал хорогдсон.** Зах зээлийн үнэлгээгээр тооцоход **тэрбум гаруй долларын хохирлыг мал аж ахуйн салбар амсаж байгаа** юм.

Тэгэхээр энэ мал аж ахуйн салбарыг сууриар нь бид эргэж харах цаг болсон.

Мал эмнэлгийн асуудлыг нэлээн олон жил дутуу хийсэн. Шаардлагатай мал эрүүлжүүлэх, вакцинжуулах ажлыг төсвийн бодлогоор хязгаарлаж эхэлсэн.

Үндсэндээ 100 хувийн шаардлагатай вакцинжуулалтын 10-аас 20 хувьд нь хүрч байсан.

Ингээд мал маань өөрөө эрүүл бус болоод ирэхээр нөгөө экспортын асуудал, үйлдвэрийн чанар стандартын асуудал дагаад уначхаж байгаа юм.

Одоо малчид дээр хэт тоо толгой нь хэтэрсэн, сүргийн бүтэц нь эвдэрсэн ийм л мал сүрэг байна.

Манай хамгийн сайн сүүний аж ахуй эрхэлж байгаа Төв, Сэлэнгэ аймгийн аж ахуйнуудаар явж байгаа. Нэг үнээнээс

авч байгаа жилийн дундаж.../минут дуусав/

Б.Бейсен: Ж.Энхбаяр гишүүний микрофоныг сунгая.

Ж.Энхбаяр: Нэг үнээнээс авч байгаа саалийн норм 1260 литрээр дунджаар тогтож байна.

Дэлхийн дундаж 8-аас 10 мянга болчихсон.

Энэ мэтээр бүтээмж их муу. Бүтээмж муу болохоор орлого муу. Орлого муу болохоор энэ салбарт ажиллах хүн хүчний хувьд хүндрэлд орчихсон.

Хамгийн ноцтой яаралтай гишүүддээ анхаарал өгөх юм бол энэ салбарын бүтэц, зохион байгуулалт бүр эсрэгээрээ.

1997 онд Засгийн газрын тогтоолоор хийгдсэн задлах бодлого явсан.

Өнөөдөр Хөдөө аж ахуйн яаманд салбарын эрдэмтэн, докторыг ажилд авах бололцоо байхгүй.

Харин өөр. Одоо жишээлбэл энэ Байгаль орчны яамны Усны газраас нэг мэргэжилтэн авахад бололцоотой. Яагаад гэвэл төрийн албаны шалгуураар болчхож байгаа юм.

Мэргэжлийн тэр судлаач, эрдэмтдийг салбарт ажиллуулах хязгаарлагдсан.

Яам зөвхөн бодлого гээд салбараасаа хөндийрчихсэн. Шинжлэх ухааных нь 6 хүрээлэн байгаа юм. Мал эмнэлгийн, ургамал газар тариалангийн,

энэ хүнсний, энэ хөнгөн үйлдвэрийг. Энэ аж ахуйн чиглэлийн зориулалтаар байгуулагдсан хүрээлэнгүүд нь Боловсролын яамны харьяа.

Салбарт ажиллаж байгаа дээд боловсролтой, дунд боловсролтой ажилчин бэлдэж байгаа салбар сургуулиуд нь Хөдөлмөр, нийгэм хамгааллын харианд.

Ингээд салбар өөрөө шинжлэх ухаангүй болчихоод, шинжлэх ухаан нь үйлдвэрлэлгүй болчихоод нэг ийм тарамдсан байдалтай.

Тэгэхээр үүнийг яаралтай нэг зохион байгуулалтад төр бодлого нь, шинжлэх ухаан нь, үйлдвэрлэл нь цогц байж байж нэг үр дүн гарах ёстой.

Үндсэндээ 1990 оноос өмнөх тэр бүтэц маш зөв зохион байгуулалттай явагдаж байсан.

Тэгээд тэрийг дахин яаралтай сэргээх нь манай их том зорилт байх болов уу.

Тэгэхээр С.Ганбаатар гишүүнд хэлэхэд бид бодлогын том алдаа бол бүтцийг буруу хийж, салбарыг нэлээн хүчийг тарамдуулж байна.

Дээрээс нь мал аж ахуй, газар тариалан, бүх салбарт шинжлэх ухаанаасаа холдчихсон.

Аж ахуйн нэгжүүд одоо их санаа зовж байгаа зүйл малчид, аж ахуйн нэгжүүд хэт.../минут дуусав/

Б.Бейсен: С.Ганбаатар гишүүн тодруулья.

4 номер. Байгаль орчны яаманд Төрийн нарийн бичгийн дарга ирчихсэн байгаа.

С.Ганбаатар: Ер нь Хүнс, хөдөө аж ахуйн яаман дээр дахиж ярих юмнууд зөндөө байгаа.

Зүгээр нарийн ярих юм бол технологи гэхээр л манайх чинь MP3, iPad гээд л бодоод явчихдаг. Израиль технологийг хөдөө аж ахуй, мал аж ахуйд л оруулсан орон шүү дээ. Тэгж байж л дэлхийд гарч ирсэн.

Яг түрүүний ярьсан. Технологиос бид хоцорсон, менежментээс хоцорсон.

Дараа нь тухтай яамныхантай уулзах учраас би Байгаль орчны яамныхантай нэг хэдэн юм асуугаадахъя даа.

Энэ говийн ус бүр маш хүнд байдалд орлоо. Байгаль орчны яамныхан энэ дээр дүгнэлт хийж байгаа юу?

Оюу Толгой зэс, алт цэвэршүүлэх үйлдвэр барина гэж байгаа. Бүр 10 дахин ус хэрэглэнэ гэсэн үг. Энэ хангалттай юу? Говийн ус хүрч байгаа юу? Дүгнэлт хийсэн үү?

“Хэрлэн-Тооно” төслийг байнга шахуургаар Оюу Толгой хүртэл зөөнө. Тооцоо судалгаа, ТЭЗҮ-гээ гаргасан уу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Тэр “Ногоон санхүүжилт” гээд бараг миний мэдэхийн 6, 7 жил болж байна. Яагаад гацаад байгаа юм бол. Авлигалаа өгөхгүй байгаа учраас гацаад байгаа юм уу гэж зарим нь ярих юм. Яагаад гацаад байгаа юм?

Ногоон санхүүжилт олон улсын байгууллагаас өгье гэж байгаа шүү дээ. Одоо үнийн дүнг нь яриад яах вэ. Энэ жил энэ удаад бүтэх үү?

Гуравдугаар асуулт. Манай тойргийн л юм ярьчихъя даа. Манай Монгол орон даяар л байх даа, бодвол.

Энэ ой бол сүйрч байна. Ой эрвээхэйд идүүлээд зүрх зүсмээр юм болж байна.

Бэлчээр цөлжилт болоод бүр цөлжилтөд ороод 70 хувь нь гээд байгаа шүү дээ. Бүр. Цөлжилт доройтолд орчихсон.

Энэ бэлчээрийн доройтолд орчихсон байгаа асуудал дээр Байгаль орчны яам, Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан энэ дээр ямар нэгдсэн бодлого барьж байгаа вэ?

Би ийм асуултууддаа тодорхой хариулт авъя.

Б.Бейсен: 4 номерын микрофон хариулъя. Байгаль орчны яам Төрийн нарийн хариулъя.

Э.Баттулга: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга байна.

С.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Эхлээд хөв цөөрмийн асуудал ярьсан.

Хөв цөөрмийн хувьд бид үнэхээр гадаргын усыг хуримтлуулах, цас

борооны болон үерийн усыг хуримтлуулж ашиглах талаар маш их эрчимтэй ажиллах ёстой.

Энэ асуудал маань өөрөө Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.4.3 дээр “усан хангамжийн дутагдалтай бүс нутгийн ус хангамж нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх” гэсэн энэ заалтын доор орсон байгаа.

Ер нь хөв цөөрмийг барьж байгуулах, энэ тоог нь нэмэгдүүлэх асуудлаар ямар ажлыг хийж байна вэ гэх юм бол бид энэ жилийн улсын төсөв дээр нэг хэв загварын зургуудыг гаргаж байгаа. Хөв цөөрмүүдийг байгуулах.

Хангайн бүсэд ямар байх юм, говь хээрийн бүсэд ямар байх юм, уулархаг бүс нутагт хөв цөөрмийг ямар зургаар хийх юм гээд нэг загварын зургуудыг нь гаргасан.

Энэ дээрээ яах вэ гэхээр Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар жилдээ 45-аас 46 тэрбум төгрөг орон нутгийн төсөвт орж байгаа юм.

Эндээсээ буцаад 35-аас багагүй хувийг нь усны төслүүдэд усны нөөцийг нэмэгдүүлэхэд зарцуулах ёстой.

Тэгэхээр орон нутагт өөрт нь хуулиар хүлээсэн үүрэг нь байдаг.

Тийм учраас орж байгаа орлогынхоо хэмжээгээр буцаагаад загварынх нь зургууд байгаа учраас, байршлийг нь тогтоочихсон учраас хөв цөөрмүүдийнхээ төсвийг тавиад ажлыг хийгээч ээ гэдэг ийм чиглэлүүдийг өгөөд явж байгаа.

Дараагийн нэг дэмжлэг бол Газрын тухай хууль, Байгаль орчны тухай хуулиуд дээр гадаргын усыг хуримтлуулсан иргэн, аж ахуйн нэгжид тухайн газрыг нь давуу эрхтэйгээр эзэмшүүлэх ийм заалт байдаг.

Тэгэхдээ энэ өнөөдрийг хүртэл бодит амьдрал дээр хэрэгжихгүй байгаа.

Тийм учраас үүнийг хэрэгжүүлэх. Дээрээс нь орж байгаа төлбөрийг буцаан зарцуулах энэ хоёр чиглэлд түлхүү ажиллах юм бол хөв цөөрмийн асуудлуудыг бид нэгдсэн байдлаар шийдэж чадна гэж харж байна.

Хоёрдугаарх нь, говийн бүсийн ус хангамжтай холбоотой. Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөн дээр тэргүүлэх ач холбогдолтой төслүүд гэж байгаа. Энэ төслүүдийн 3 нь усны төсөл байгаа.

Тэр дундаа та **“Орхон-Онги”**, **“Хэрлэн-Тооно”** төслүүдийг ярилаа.

Олон жил яригдсан энэ төслүүдийн хөрөнгө оруулалтын асуудлыг зоригтой шийдье гэж Засгийн газар оруулж ирсэн.

Эхний ээлжийн энэ “Хэрлэн-Тооно” гэж төслийн тухайд гэвэл Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Тооно уулын орчмоос Сайншанд хүртэл 235 километр ус дамжуулах шугам барьж байгуулах төсөл.

Одоо бидэнд байгаа мэдээллээр “Оюу Толгой” компанийн санхүүжилтээр “Эрдэнэс Оюу Толгой” компани тендер зарлаад ТЭЗҮ-гийн ажлыг хийж байгаа.

Тэр 10 тэрбум. Тийм. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь 7

тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа.

Дараагийн төсөл бол энэ “Орхон-Онги” гэж байгаа. Өвөрхангай, Дундговь.../минут дуусав/

Б.Бейсен: Нэмж хариулах уу? Төрийн нарийн. 4 номерын микрофон. Нэмж хариулья.

Э.Баттулга: Би богинохон яг үлдсэн хоёр асуултад нь хариулаадахъя.

Ногоон санхүүжилтийн тухайд гэвэл энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт томоохон зорилт орсон. Олон улсын ногоон санхүүжилтийн механизмыг татаж, үүнтэй холбоотой зохицуулалтуудыг бий болгоно гээд.

Бид Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг өргөн барина. Анхдагч хууль байгаа.

Энэ хуулиа дагаад одоо бид гадна талдаа жишээлбэл **GFP** [Green Finance Platform] гээд “Ногоон санхүүжилтийн сан”-гаас 19 төсөл дэмжүүлчихсэн. Нийт төсөвт өртөг нь 468.0 сая ам.доллар байгаа.

Энэ нь юунаас болоод гацаад байна вэ гэхээр бид дотооддоо энэ уур амьсгалын төслүүдийг хэрэгжүүлэх тогтолцоогоо бий болгох, хууль эрх зүйн орчноо бий болгох, нөгөө хүлэмжийн хийн ялгаралт, шингээлтийг тооцох аргачлалаа батлах гэх мэт өөрсдөөс хамаарсан ажлууд байгаа.

Үүнийгээ энэ Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд амжуулна.

Тэр ойтой холбоотой асуудал байгаа. Ерөөсөө энэ уур амьсгалын

өөрчлөлтийн нөлөөллийн сөрөг нөлөөллийн нэг хэлбэр нь энэ хортон шавжийн идэвхжил байгаа юм.

Энэ хортон шавжийн идэвхжил, бусад температурын өсөлттэй холбоотой ойн нөөцийн доройтол дээр бид хамтын менежментийг л ерөөсөө ашиглах гол шийдэл гэж харж байгаа.

Ойг эзэмшүүлэх ёстой. Ойн нөхөрлөлүүдийг идэвхжүүлэх ёстой. Ойн дагалдах баялгийг ашигласнаар гарах үр дүнг нь орон нутгийн иргэд нь өөрсдөө эзэмшээд, тэндээсээ хариуцан хамгаалах үйл ажиллагаагаа санхүүжүүлэх ёстой гэж байгаа.

Ер нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам руу чиглүүлж энэ асуудлыг яриад байдгаас биш л бас мөн Ойн тухай хуулиараа ойн нөөцийг ашигласны орлогоо буцаагаад ойн хамгаалахад зарцуулах ёстой орон нутгийн хариуцлагын асуудал байгаа гэдгийг давхар хэлбэ.

Б.Бейсен: Манай ажлын хэсгийн асуусан асуулт дээр нь товчхон тодорхой хариулах шаардлагатай байна.

Ж.Энхбаяр гишүүн хариулах юм байна. 3 дугаар микрофон.

Ж.Энхбаяр: Бид хөдөө аж ахуйн салбарын усжуулалтыг Байгаль орчныхоо яамтай хамтран хийх, ялангуяа газар тариалангийнхаа болон ногооны талбайг ойн зурвасжуулах ажлыг Байгаль орчны яамтайгаа хамтран хийх ийм саналыг тавьчихсан байгаа.

Гишүүдийг 9 сар гаргаад газар тариалангийн бүс нутагт танилцах айлчлалыг зохион байгуулна.

Тэр хүрээнд манай яамны хэрэгжүүлсэн хэд хэдэн томоохон усалгааны системүүдийг нуур, хөв, цөөрөм байгуулж байгаа байдалтай газар дээр нь танилцуулъя.

Ер нь Байгаль орчны яамтай бид маш их ажлаа уялдуулж, хөрөнгө төсвөө хамтран хоёр талаас нь дэмжиж хийвэл нэлээн их том бололцоо байгаа юм байна.

Энэ дээр гишүүд бас бодлогын чиглэл гаргаж хамтран ажилла гэдэг үүрэг даалгавар өгвөл бид нарт хэрэгтэй байна.

Тэгээд бүсчилсэн хөгжлийн асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яам бүсчилсэн бодлого хариуцаж байгаа. Хөгжлийн яам хариулна.

Б.Бейсен: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүнд асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Нөгөөдхөө ярьж байна л гэдэг нэг онигоо байдаг байх аа. Түүн шиг нөгөөдхөө л яриад л байна даа. Ж.Энхбаяр сайд аа.

Ерөнхийдөө таны олон жил энэ улс төрд ажилласны хувьд энэ зэргийн юм ярих нь ойлгомжтой.

Үүнийг та ч битгий хэл урьдын сайдууд ч зөндөө ярьсан юм байгаа. Ганцхан хэрэгждэггүй шүү дээ. Хэрэгжихгүй яг амьдрал дээр болохоор буруу тийшээ явчхаад байгаа байхгүй юу.

Одоо өнөөдөр мал аж ахуйгаа сайжруулна гээд бид зөндөө ярилаа, баахан онол ярилаа. Үүнийг чинь малчид хүртэл мэдэж байгаа.

Яг малын хотонд очихоор тэр мал бүхий айл яаж амьдарч байгаа гэдгийг

бид мэдэж байгаа юу. Чадан ядан амьдарч байгаа шүү дээ.

Гаднаа нэг мотоцикл, нэг портер, нэг жижиг тэрэг аваачаад тавьчихаар л өө эднийх баян айл гээд л. Тэгээд л энгэрт нь төмөр хадаж өгөөд л шавар малгай өмсгөөд л бид хөөргөөд л ингээд л өнөөдрийг хүртэл амьдарч байгаа шүү дээ, үндсэндээ.

Эд нарыг яаж хөл дээр нь босгох юм. Яаж тэр гуу жалгаар хаягдаад байгаа арьс шир, нэхий нь зарагддаг болох юм. Энэ нэгдүгээр асуулт шүү.

Яаж энэ арьс шир зарагддаг болох юм бэ? Энэ арьс шир зарагдахын тулд өнөөдөр ядаж түүхийгээр нь гаргах бололцоо байхгүй юу?

Тэр үйлдвэрээ барьтлаа зүнийг гаргаж байж болохгүй юу? Жалган дээрээ хэвтэж байх юм уу? Үйлдвэр барьтлаа жалган дээрээ хэвтэж бай гэж байгаа юм уу?

Хоёрдугаарт, тэр мах мал нь зарагддаг болох боломж бололцоог яаж нээх юм?

Үүнийг нээхийн тулд юу вэ гэхээр явсаар байгаад малын эрүүл мэнд. Малын эрүүл мэнд.

Би дахин дахин ярьж байгаа. Энэ малын эрүүл мэнддээ хувьсгал хий гээд байгаа шүү дээ. Хувьсгал хий. Зүгээр битгий яриад бай. Хувьсгал хий.

Улсын хэмжээнд болгож байгаад энэ малын эрүүл мэндтэй тэмцэх ёстой.

Үүний тулд бид Байнгын хорооноос нэг асуудал гаргасан. Жилдээ 2 удаа вакцинжуулъя. Вакцинжуулахдаа

мэдрэмтгий бүх малдаа хийе гэсэн. Бүх малдаа. Тэгээд 5 жилийн хугацаанд энэ том вакцинжуулалтыг хийж байгаад нэг мөр энэ өвчнөөсөө салъя. Тэгж байж энэ мал мах чинь урагшаа хойшоо гардаг болно.

Одоо бүгдээрээ хаалттай байгаа шүү дээ. Олон улсын хэмжээнд улаан гэрэл асаад ингээд анивчаад байгаа. Монголоос битгий мал ав. Монголын мал өвчтэй гэдэг гэрэл чинь анивчаад байгаа шүү дээ. Тэнд.

Үүнээсээ яаж салах юм? Олон жил ярилаа шүү дээ.

Тэгээд малчид дээр очихоор сайхан болгоно, энэ тэрээ гээд л сайхан, маргааш гэхэд гаргачихна гээд. Үгүй шүү дээ. Энэ мал махыг чинь ав авдаг газар олдохгүй болчихсон.

Тэгэхээр малын өвчинтэйгөө яаж тэмцэх юм бэ? Тэр жилдээ 2 удаа вакцинжуулах асуудлаа хийх юм уу, үгүй үгүй юм уу? Хоёр дахь асуудал.

Гуравдугаарт, хамгаалагдсан бүс гээд байгаа энэ асуудлуудыг яримаар байна шүү дээ. Түрүүний чинь сайд хамгаалагдсан бүсийг нэлээн том гаргаж ирнэ лээ. Ашгүй баярлаад алга ташаад байсан чинь Дорнодын тал дээр хамгаалагдсан бүс хийнэ гээд ярьж байгаа байхгүй юу.

Хаа сайгүй машин тэрэг давхилдаад байдаг, цөм цөм давхиад ороод байдаг тэр Дорнодын том бүс дээр хамгаалагдсан бүс гэж мэдэхгүй. Би лав толгойд багтахгүй.

Тэгж байсанд орвол тэр манай нутагт аваачаад хийчхийг би зөндөө

урьсан. Уултай устай, голтой горхитой.../минут дуусав/

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ж.Бат-Эрдэнэ гишүүнтэй санал 100 хувь нийлж байна.

Үнэхээр малынхаа эрүүл мэндээс л ажил эхэлнэ. Вакцинжуулалт.

Би түрүүн хэлсэн. Нийт шаардлагатай объёмын 10-аас 20 хувьд л хүрч чадаж байна. Ийм маягаар цаашаа явж болохгүй.

Хөдөө аж ахуйн салбараас гарч байгаа энэ түүхий эд, мал, мах, арьс шир, ноос ноолуурын экспорт, ер нь зах зээл боломжийн байна. Хамгийн гол асуудал мал эмнэлэг, вакцинжуулалт дээр л унаад байгаа юм.

Тэгэхээр эрхэм гишүүд маань үүнийг л энэ Их Хурлын гишүүддээ л сайн ойлгуулах.

Ер нь уурхайгаас ангид эдийн засгийг босгоё гэвэл ерөөсөө л хөдөө аж ахуйн салбараа л босгож байж энэ маань оршин тогтнох гол суурь болно.

Тэгэхээр тэрний гол суурь нь хоёр том чиглэл байна. Мал аж ахуй, ургамал тариалан. Аль аль дээр нь эрүүл мэндийн асуудал.

Ерөөсөө л малын эрүүл мэнд. Вакцинжуулалтаа янзлахын тулд Биокомбинатаа эд бүрийг нь шинэчилъе. Вакцин дотроо хийдэг болчихъё. Тэгээд вакцинжуулалтад шаардлагатай тэр мал эмнэлгийн төлбөр үйлчилгээг нь сайжруулчихъя.

Хамгаалагдсан тэр бүсийг тэр Дорнод хилийн цаана биш, зах хязгаарт биш, яг дотор дотор нь бид зохион байгуулах нь зүйтэй гэж байгаа юм.

Үйлдвэрүүдийнх нь дэргэд, тэр бүс нутгийнх нь дэргэд. Хамгийн гол нь дагасан нөгөө тэжээлийн бааз нь сайн бэлтгэгдэх ёстой юм байна лээ. Ингэсэн нөхцөлд экспортын ажил нэлээн хөнгөвчлөх бололцоотой.

Ер нь мал эмнэлэг дээр, олон улсын гоц халдварт өвчин дээр бас их нааштай боломжийн боломжийн үр дагаврууд гараад. Та бүхэн анзаарч байгаа бол шүлхийнээс авхуулаад сүүлийн жилүүдэд ер нь нэлээн хумиад ирсэн.

Бүх мөшгөх тогтолцоо, шаардлага, программ хангамж тэр юмнууд технологиуд нэлээн нэвтрээд ирлээ.

Бидний зорьж байгаа зорилт бол цахим хөдөө аж ахуй, ухаалаг хөдөө аж ахуй буюу ухаалаг малчин, ухаалаг ногоочин, ухаалаг тариаланч бүгд энэ системд холбогддог. Эндээсээ мэдээллээ авдаг. Хөдөө аж ахуйн салбарын бүх бүтээгдэхүүний урсгал хянагддаг. Хөдөө аж ахуйн бирж дээрээ орж ирдэг. Буцаад үйлдвэртэй нь холбодог ийм ил тод том платформыг энэ “Цахим засаг” гэдэг хүрээнд эд боловсруулаад түрүүчийн үр дүнгүүд нь гарч байна.

Дараагийн удаа би гишүүддээ яг мал мах дээр зориулсан хийж байгаа хөгжүүлсэн программуудыг танилцуулна.

Б.Бейсен: Ж.Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Тэр хамгаалагдсан бүсийг хойд хангай бүс

рүү хийчих гээд би санал хэлээд байгаа юм шүү дээ. Энэ дээр нэг анхаарал хандуулаадхаач.

Хойгуураа уултай устай. Орж ирэх боломж байхгүй. Урдуураа голтой. Тэрийг гарах гарц байхгүй. Хоёрхон гүүртэй, гуравхан гүүртэй. Тэр гурван гүүрэн дээр нь хяналтаа тавьчихад энэ чинь тэр чигээрээ хамгаалалтын бүс байхгүй юу.

Үүнийг яагаад хийчхэж болдоггүй юм, яагаад үүнийг анзаарч болдоггүй юм.

Тэр гуравхан гүүрэндээ л хяналтаа тавьчих л даа. Тэгвэл тэр дотор байгаа бүх асуудлуудыг малчид өөрсдөө тэрийг чинь хянаад явчихна. Тэндээс мал тэр чигээр нь борлуулагдаад л, тэр чигээрээ ачигдаад л тэр урагшаа гарна уу, хойшоо гарна уу шууд ачдаг ийм системийг л хийчих л дээ. Ядаад байх юм байхгүй шүү дээ. Зөндөө ярилаа шүү дээ.

Тэгтэл тэр Дорнодын бүс дээр хэдэн талаасаа сэт сэт тавьсан газар аваачаад хийнэ гээд л ингээд зөрөөд л яваад байдаг.

Хоёрдугаарт, энэ малчдынхаа том том аж ахуйн нэгжүүдийг бид дэмжих нэг бодлогууд зөндөө явлаа.

Сая тэр “Хүнсний хувьсгал” гэдэг асуудал чинь эцсийн эцэст яг том аж ахуйн нэгжүүд дээрээ очсон шүү. Зээл чинь.

Бид уг нь үүнийг жинхэнэ нөгөө нэг үйлдвэрлэгчид, шинээр юм хийх гээд байгаа хүмүүсээ хаана л бол хаана борооны дараах мөөг мэт гарч ирээд үйлдвэрлэгч болоосой гэсэн зүйлийг хүсэж хийсэн бол яг газар дээрээ очихдоо

хэдэн аж ахуйн нэгжүүд дээр дэмжигдээд явчихсан.

Яг үүнтэй адилхан бид малчдаа, өөрсдөө тэр үр тариагаа тариалдаг, өөрсдөө тэр хадан тэжээлээ авдаг, өөрсдөө ногоон тэжээлээ тарьдаг ийм боломж бололцоог нь хангахгүй бол зүгээр тэнд нэг аж ахуйнуудыг дэмжинэ гэж яваад байгаа бол хэзээ ч монгол малчид хөл дээрээ босохгүй шүү.

Хэдэн аж ахуйн нэгж халтар мултар яваад тэд нарын бүтээгдэхүүнийг ч авах чадал байхгүй, тэр малчид чинь.

Тэгэхээр тэр бүтээгдэхүүнээ авдаг чадалтай болгох хэрэгтэй байна. Хөл дээр нь босгох хэрэгтэй байна. Тэр өөр өөрсдийгөө малынхаа чанарыг сайжруулдаг чадвартай болгох хэрэгтэй байна шүү дээ. Тэр 5 сая төгрөгийн бухыг чинь хэн ч авч чадахгүй байхгүй юу даа.

Тэгэхээр 5 сая төгрөгийн бухыг нь аваад өөрийнхөө малыг сайжруулдаг чадалтай болгохын болгохын тулд эхлээд тэр бараа, бүтээгдэхүүн нь зарагддаг, мах нь зарагддаг, арьс шир нь.../минут дуусав/

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Тэр хамгаалагдсан бүстэй тантай яг санал нэг байгаа юм.

Ялангуяа манай хангайн бүс, төвийн бүс, зүүн бүсийн ойт хээр үхэр сүргийн гол цөм нутгуудад ийм хамгаалагдсан бүс нутгийг дотор нь хийж өгөөд, тэнд нь байгаа мал сүргийг бүрэн яг фокуслан вакцинжуулалтыг өндөр хийгээд, эндээсээ мал махаа бэлтгэлээ хийгээд экспортынхоо чиглэлээр хөгжүүлэх бололцоотой.

Тэжээлтэй холбоотойгоор энэ хоршсон малчдын тавьж байгаа хүсэлтийн дийлэнх нь хэрхэн тэжээл тарих вэ гэдэг дээр саналууд нэлээн орж ирсэн байна лээ.

Та бүхэн хөтөлбөр дээр анзаарсан бол бид 200 мянган га талбайг эргэлтэд нэмж оруулах гэж тусгасан байгаа.

Энэ маань хоршоолол, малчин өрхийнхөө тоогоор тооцоод 5 га-гаар дундаж хэмжээ гарсан гээд тооцоход зөвхөн малчдад гэхэд 50-аас 80 мянган га талбайг тэжээлийн тарих зориулалтаар олгох шаардлага гарч байгаа юм.

Тэгэхээр энэ хөтөлбөрт туссан гол зорилтууд амжилттай батлагдвал энэ тэжээлийг малчид өөрсдөө тарих, газар эзэмших бололцоо нээгдэнэ. Түүн дээр нь яам нь бодлогоор шаардлагатай тоног төхөөрөмж, тэр тарих арга ухаан, үр сортоор нь хангаад өгвөл үр дүн гарах байх.

Нэг үеэ бодвол хамгийн гол нь хоршсон байгаа байдал нь их чухал байгаа юм.

Хоршсон малчдын сэтгэл зүйг л алдаж болмооргүй байгаа юм. Улам үүнийгээ идэвхжүүлээд, улам дараагийн арга ухаанд нь суралцуулаад, үйлдвэрлэлтэй нь холбоод явбал үр дүн гарах байх гэж найдаж байна.

Б.Бейсен: Цагаанхүүгийн Мөнхбат. Б.Уянга гишүүн байгаа юм байна шүү дээ. Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Гишүүддээ болоод ажлын хэсгийнхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд Байгаль орчны яам руугаа хандаж л хоёр асуулт асууя.

Тусгай хамгаалалттай 3.4.1.1 дээр “тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлээд, тэгээд менежментийг сайжруулна” гэсэн заалт орсон байгаа.

Тэгээд миний асуух гэж байгаа асуулт, бид яагаад тусгай хамгаалалттай газар нутгаа одоо байгаа хэмжээнээсээ илүү заавал өргөтгөнө гэж үеийн үед ингэж орж яваа юм бэ гэдгийг асуух хэрэгтэй байгаа юм.

Яагаад ингэж байгаа юм бэ гэх юм бол тусгай хамгаалалттай газар нутаг, тусгай хэрэгцээнд байгаа газар нутаг, орон нутгийн болоод улсын хэмжээний эдгээр бүх талбайд эзэлж байгаа хувь хэмжээнүүдийг нь нэмэхэд 74 хувьд хүрдэг.

Та хэдийн бас энэ хөтөлбөр дээр тавьсан танилцуулга дээр тусгай хамгаалалт нь дангаараа 21 хувь, тусгай хэрэгцээний газар нь ингээд 20-иод хувь.

Тусгай хэрэгцээний газар Засгийн газраар авагдаад буцааж гарах тохиолдол их ховор байдаг.

Тэгэхээр бараг тусгай хамгаалалттай гэсэн үг.

Тэгээд энэ хоёрыгоо нэмэхэд л 40-өөд хувьтай байгаа ийм газар нутаг дээр түүнийхээ менежментийг ярихаасаа илүү заавал өргөтгөнө гээд байдаг шалтгааныг нь асуухыг хүсэж байгаа юм.

Яагаад вэ гэхээр Оросын Холбооны Улс тусгай хамгаалалттай газар, тусгай хэрэгцээт газар нутагтай. Нутаг дэвсгэрийнхээ 13.5 хувийг,

Казахстан 8.2-ыг, Украин 8.1 гээд. Ер нь манай эргэн тойрны байгаа Хятад 12 хувь.

Ингээд олон улсын стандартаа харахаар 10-аас 12 хувь байгаад байгаа байхгүй юу.

Тэгсэн манайх аль хэдийн 20.1, 21 хувь буюу Байгаль орчны яам маань хангалттай ажлаа хийчихсэн байхад дахин өргөтгөнө гээд байгаа юм.

Тэгээд аль орон хамгийн их талбайгаа тусгай хэрэгцээ хамгаалалтад авсан байна вэ гээд харангуут Африкийн нэг орон 44 хувьтай байгаа байхгүй юу.

Тэгэхээр манайх бүх тусгай хамгаалалт хэрэгцээгээ нэмээд 74 хувь болчихсон.

Тэгээд дээрээс нь дахиад өргөтгөнө гэж оруулж байгаа дээр хариулт авмаар байна шүү.

Шалтгаан гээд нэг зүйлийг хэлье. Манай их олон газар тусгай хамгаалалттай гээд урд хэсгээр зүүн урагшаа, урагшаагаа байдаг.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тусгай хамгаалалттай гээд яг хил даваад гарангуут хил рүүгээ тулгаад 500 метр ч хүрэхгүйгээр үйл ажиллагаа явуулж байдаг юм.

Энэ бол баталгаатай. Танай яамныхан ч мэдэж байгаа. Бид Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр хүртэл ярилцаад сууж байлаа.

Тэгэхээр та хэд маань яг энэ оруулж ирж байгаа “өргөтгөнө” гэж

байгаа зүйл дээрээ хариулт өгвөл их зүгээр байна.

Хоёр дахь нь, усны нөөцийн хэсэг байгаа юм. 3.4.

Тэгэхээр усны нөөц. Ер нь тэгээд л бас Байгаль орчны яамныхантайгаа урьд нь яаман дээр байхдаа ярилцдаг байсан.

Бид нүдэнд харагдахгүй байгаа юмаа байхгүй гээд бодчихдог. Тэгээд газрын доор байгаа усныхаа чанарыг, хэмжээг нь судлахгүйгээр маш олон жил, бараг 20-иод жил явчихсан.

Тэгэхээр үүнийгээ нэмэгдүүлэх, газрын доорх усны нөөцийг нэмэгдүүлэх гэсэн.../минут дуусав/

Б.Бейсен: Хариултаа сонсчихоод тодруул. Байгаль орчны яам. 4 номер.

Э.Баттулга: Б.Уянга гишүүний асуултад хариулъя.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тоо хэмжээг нэмэгдүүлэх. Яагаад нэмэгдүүлэх гээд зориод байдаг юм бэ гэдэг дээр эхлээд хариулъя.

Монгол Улс энэ Биологийн олон янз байдлыг хамгаалах олон улсын конвенцод нэгдсэн.

Энэ конвенцын гол зорилт нь 30, 30 гэсэн зорилт байгаа. 2030 он гэхэд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 30 хувьд хүргэх гээд.

Одоогийн байдлаар манай улсад 120 улсын тусгай хамгаалалттай газар. Газар нутгийн 21 хувийг эзэлж байгаа.

Удахгүй бид дахиад 52 газрын улсын тусгай хамгаалалтад оруулах асуудлыг оруулна.

Гэхдээ энэ дундаа сүүлийн жилүүдэд тусгай хамгаалалтад авч байгаа газруудын сонголтыг хийхдээ бид их олон талыг харгалзаж үзэж байгаа.

Эхний ээлжид тухайн бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг харж байгаа юм. Дараа нь тэнд амьдарч байгаа иргэдийн амьжиргааны эх үүсвэр. Дээрээс нь Уул уурхайн яамтайгаа ярьж байгаад ашигт малтмалын болоод газрын тосны хайгуул, судалгааны ажил явж байгаа талбайнуудтай аль болох давхцуулахгүй байх хэлбэрээр явуулахыг хичээж байгаа.

Гишүүний хэлж байгаа асуудал нөгөө 74 хувьд хүрчихлээ гэдэг маань орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг нэмсэн тоо нийлээд Монгол Улсын хэмжээнд авч байгаа.

Бидний энэ талаар авч байгаа гол бодлогын зорилт юу байна вэ гэхээр тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг өөрийг нь дан төр хамгаалдаг биш хувийн хэвшлийн олон талт менежментийн хэлбэр лүү шилжүүлбэ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн одоогийн 4 ангилал дээр тодорхой ангиллуудыг нэмье.

Ингээд тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар одоогийн энэ ашиглалтгүй байгаа маш их нарийн хилийн бүсчлэлийн дэглэмийг шаардаад ихэнх үйл ажиллагааг хориглодог зүйлсийг уян хатан болгоё гэдэг ийм бодлогын өөрчлөлтийг хийж байгаа.

Одоо эхнээс нь бид Тусгай хамгаалалттай газрын 35 захиргаанаас 6-г нь орон нутгийн санхүүжилттэй, олон улсын байгууллагын санхүүжилттэй, төрийн бус байгууллагын санхүүжилттэй болгоод эхнээс нь шилжүүлээд явж байгаа.

Тэгэхдээ бид энэ тоогоо нэмэгдүүлэх ажлаасаа ухрахгүй. Яагаад гэвэл энэ ерөөсөө олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгаль хамгааллын хамгийн шилдэг менежмент тухайн газар орныг тусгай хамгаалалтад авах.

Тэгэхдээ энэ дээрээ бид нөгөө экологийн үнэ цэн. Жишээлбэл, ус бүрэлдэх эхийг зайлшгүй авахаас өөр аргагүй. Зарим нэг ховор, нэн ховор амьтан, ургамлын тархалттай газруудыг авахаас өөр арга байхгүй.

Бусад дээр нь дотоод зохицуулалттай. Ялангуяа тэр 4, 5 ангилалтай байгаа тэр ангиллын доторх мөрдөгддөг дэглэмүүдийг өөрчлөх замаар зарим төрлийн үйл ажиллагааг зөвшөөрүүлэх ийм хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж харж байгаа.

Б.Бейсен: Нэмж тодруулъя. Б.Уянга гишүүн.

Б.Уянга: Байгаль орчны яамныхаа байр суурийг ер нь ойлгоод л байдаг юм.

Тэр нэг олон улсын конвенцод 30 хувь гээд амлачихсан юм гээд.

Тэр бол тэгэхдээ манай эрх ашиг яг биш юм. Олон улсын стандартыг дахиад дурдаад протоколд үлдээе.

12 хувиас хэтрэхгүй байгаа шүү. Манайх аль хэдийн 21 хувь, орон нутгийн

тусгай хамгаалалттай газар, нөөцөд авсан газар, бүх газрууд нийлээд 74 болчихоод байхад одоо тэгээд менежментээ эхлээд сайжруулъя гэж бодохын оронд нэмнэ гээд яваад байгаа нэг тийм ашиг сонирхол байгаа юм шиг байдаг.

Газрын доорх усныхаа судалгааг хэрхэн сайжруулах гэж байгаа вэ? Түүн дээрээ нэмээд хариулчхаарай.

Б.Бейсен: Төрийн нарийн хариулъя. Бас холбогдох асуулттай холбоотой ажлын хэсгийн ирсэн улсууд тодорхой асуулт байвал бас нэмж хариулаарай. 4 номерын микрофон өгье.

Э.Баттулга: Гишүүний асуултад хариулъя.

Усны нөөцтэй холбоотой асуудал Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн 3.1.1.7 дээр байгаа.

Юу гэж томьёолсон бэ гэхээр усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны үнэ цэн, үнэлэмжийг нэмэгдүүлэн ашиглалт, хэрэглээнд хэмнэлт, дахин ашиглалтыг дэмжинэ гэсэн.

Энэ агуулгын дотор юу хийгдэх вэ гэхээр хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох, хайгуул судалгааны ажлуудыг идэвхжүүлнэ. Жилдээ 5-аас доошгүй газарт хийнэ гэж байгаа.

Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлж, усны нөөцийн тархалтыг тогтооно гэж байгаа.

Гуравдугаарт, ус ашиглалт, хэрэглээний норм, нөөц ашигласны төлбөрийг хэрэглэсэн хэмжээнээс нь хамаараад шатлан тогтоох ийм зарчимд

үндэслээд шинэ концепцоор усны үнэ цэн, үнэлэмжийг нэм дүүлнэ гэж байгаа.

Газрын доорх усны нөөц баялгийг бүртгэлжүүлэх, ашиглалт хяналтыг сайжруулах, гадаргын болон газрын доорх усны хэмжилтийн цэгийг нэмэгдүүлж, цэвдэг, мөстлийн төлөв байдлыг шинэчлэн тогтооно гэж.

Хамгийн сүүлд нь усны хэрэглээ, ашиглалтыг бүрэн тоолууржуулж, усны үр ашиг хэмнэлтийг сайжруулна гэж байгаа юм.

Энэ дотор жишээлбэл унд ахуйн зориулалтаар иргэн усны төлбөрөөс чөлөөлөгдөж байгаа шүү дээ. Гэхдээ бид нарын барьж байгаа бодлого бүгдийг нь тоолууржуулчихъя. Ямар ч байсан нөөцтэйгөө уялдуулсан хэрэглээг бий болгоё.

Нөөцөөс давсан хэрэглээ гараад ирсэн тохиолдолд усны төлбөрийг шатлан нэмэгдүүлэе.

Эндээсээ уялдуулаад жишээлбэл худгийн юм уу, цооногийн юм уу, өрөмдлөгийн зөвшөөрлүүдийг нөөцийнхөө ашиглалттай уялдуулж тогтооё гэдэг чиглэл барьж байгаа.

Тийм. Энэ хөтөлбөр дээрээ орсон байгаа. 3.1.1.7-д. Тийм.

3.1.1.7 дээр үндсэн зорилт нь орж байгаа. Одоо Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө дээр орох заалтууд нь байгаа.

Б.Бейсен: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Би энэ хоёр яамнаас хоёр хоёр асуулт асуух гэсэн юм.

Хөдөө аж ахуйн яамнаас “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг үргэлжлүүлж, “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэсэн байгаа.

Энэ “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд одоогоор хэчнээн малчин хоршоод ямар хэмжээний зээл аваад байгаа юм бэ?

Цаашлаад үүнийг үргэлжлүүлэхдээ бас ямар хэмжээний эх үүсвэр гаргаж өгөх юм бэ?

Одоо энэ төсөл чинь явж байна уу, зогсчихсон уу? Миний авч байгаа мэдээллээр сонгуулийн өмнө нэлээн идэвхтэй өрнөж байгаад, тэгээд сонгуулиас хойш зогсчихоод байна, банкнууд нь зээлээ зогсоочоод байна. Баахан хоршоодын хүсэлтүүд гарч ирчхээд байна гэсэн нэг ийм ойлголтой байгаа юм. Энэ дээр хариулт авъя гэж бодож байна.

Хоёрдугаарт, арьс ширний цогцолборууд. Дарханы арьс ширний цогцолбор, тэр Эмээлтийн арьс ширний цогцолбор гэж ярьдаг.

Энэ цогцолборууд ямар хэмжээнд явж байна. Үргэлжлэх юм уу? Хэзээ ашиглалтад орох юм?

Тэгээд энэ ашиглалтад ортол хэдүүлээ энэ малын гаралтай түүхий эдээ яах юм бэ? Гадагшаа экспортоор гаргах юм уу? Эсвэл аймгийн бүсийн төвүүд дээр арьс ширний үйлдвэрүүдийг энэ “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ гэсэн юм байна.

Энэ дээр бас тодорхой ойлголт авмаар байна гэж хэлэх гэсэн юм.

Байгаль орчны яамнаас. Сая Байгаль орчны сайд томилогдсонтой дараахан нь усны ажлын хэсэг гээд байгуулагдсан гэж байгаа юм. Нэлээн том бүрэлдэхүүнтэй ийм ажлын хэсгийн мэдээлэл байгаа.

Энэ ажлын хэсэг хуралдсан уу? Энэ ер нь ямар ажил хийх, ямар үүрэг гүйцэтгэх ийм ажлын хэсэг юм бэ?

Тэгээд эд нар маань энэ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт ямар санал, дүгнэлтүүд өгч байна аа?

Одоо “Хэрлэн-Тооно”, “Орхон-Онги” гээд 2 төслийг л аль арван хэдэн жилийн өмнөөс, бараг хориод жилийн өмнөөс одоо хүртэл хүн бүгд л яриад байх юм. Үүнийг хийнэ, хийнэ л гээд. Яг тодорхой ямар алхмууд хийх юм бэ гэдэг ийм зүйлийг асуух гэсэн юм.

Мөн Байгаль орчны яаман дээр маш олон олон улсын төсөл, хөтөлбөрүүд хэрэгждэг гэнэ.

Энэ төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг гаргаж өгч болох уу?

Хоёрдугаарт, энэ говийн бүс нутаг, энэ цөлжилт уур амьсгалын өөрчлөлтөд нэрвэгдээд байгаа, хөрсний доройтолд ороод байгаа энэ бүс нутгууд руу жишээ нь чиглэж байгаа энэ олон улсын хөтөлбөрүүд байна уу? Ийм асуултуудыг асуух гэсэн юм.

Б.Бейсен: Эхлээд Хөдөө аж ахуйн яам. Дараа нь Байгаль орчны яам хариулъя. 4 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Хоршоо хөдөлгөөн улс орны хэмжээнд амжилттай өрнөж байна.

Өнөөдрийн байдлаар 442.7 тэрбум төгрөг малчдын гар дээр олгогдсон байна. Нийт 12 мянга 885 мянган малчин, 3 мянга 467 хоршоо энэ зээлийг авсан байна.

Одоо судлагдаж байгаа банкууд дээр 66.0 тэрбум төгрөгийн хүсэлт судлагдаж байна.

Ингээд өнөөдөр үндсэндээ 2024 оны төсөвт суусан 500.00 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрэн үндсэндээ олгогдоод дуусаж байна.

Үүнийг цаашдаа үргэлжлүүлэх шаардлага байна гэдэг ийм байр суурийг Хөдөө аж ахуйн яам илэрхийлж байгаа.

Хэрвээ энэ амжилттай Сангийн яам, Монголбанк дэмжээд шинэ эх үүсвэрийг гаргаж өгвөл малчдыг дэмжих энэ зээлийг дахин хугацааг сунгах нь зүйтэй гэж үзэж байна.

2025 ондоо ахиад 500.00 тэрбум байгаа.

Өнөөдрийн байдлаар бүрэн олгогдоод үндсэндээ дуусаж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ эрч хүчийг алдуулахгүй он дуустал ахиад хангалттай хугацаа байгаа тул бид төсвийн тодотгол дээр жоохон тодотгол хийгээд тэр зээлийн хүүний дэмжлэгийн эх үүсвэрийг нь тодорхой суулгаад өгөх юм бол энэ нэлээн сайн гарахаар байна.

Ер нь малчид хамгийн гол зорилго бол энэ жалгаар нэг байгаа малчдаа л хоршоолоод авъя.

Хамгийн доод нэгж нь 9 малчин өрх шүү дээ. 9 малчин өрх нэгдээд нэг хоршоо болоод ороод ирэхээр нэгдүгээрт санхүүгийн харилцаанд орж байна., төсөв хөтөлбөртэй болж байна, хийх ажил нь тодорхой болж байна.

Энэ дээр нь яг заадаг, сургадаг, тэр газар олгодог, бодлогыг нь залгаад өгөхөөр малчид маань арай илүү түвшинд босоод гараад ирэх болов уу л гэсэн л явж байгаа шүү дээ.

Нөгөө талаар байгаль цаг уурын эрсдэл улам л амаргүй болж байгаа.

Ийм маягаараа цаашдаа энэ амьдрах арга ухаан дээр бид эрс өөрчлөлт хийхгүй бол байгаль цаг уурын улс орныг хамарсан томоохон хэмжээний ган, зудын ачааллыг даахгүй болж байгаа. Маш эмзэг байдалтай байгаа.

Энэ нь цаанаа маш олон тийм нийгмийн асуудлыг өдөөх эрсдэл байгаа тул ер нь малчдаа хоршоолох, яаралтай зохион байгуулалтад оруулах, тэр тэжээл таримал тарьдаг болгох, хамтарч хоршдог болгох ийм чиглэл рүү нь чиглүүлэх нь зүйтэй л гэж бодож байна.

Түүхий эдтэй холбоотойгоор түүхий арьс ширийг экспортлох зөвшөөрлийг Засгийн газар 2023 онд гаргаад 2026 он хүртэл мөрдөж байгаа хэдий ч урд зах зээл ерөөсөө энэ дээр маш идэвхгүй байгаа.

Эргээд л нөгөө түүхий түүхий эд гэдэг маань өөрөө малын өвчлөлтэй холбоотой.

Яагаад гэвэл манай нөгөө эрүүл бүс нутаг вакцинжуулалтын түвшин хангалттай болж чадахгүй байгаа тул бас л эрсдэлээ бодоод хил хаачаад байна.

Тэгэхээр бид энэ “Цагаан алт” гэдэг хөтөлбөрөөрөө дамжуулаад ямар ч байсан анхан болон дунд шатын боловсруулалтаа л ерөөсөө сайжруулаад авъя.../минут дуусав/

Б.Бейсен: Байгаль орчны яам хариулъя. 3 номер.

Э.Баттулга: Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулъя.

Яаман дээр ажлын хэсэг байгуулагдсан. Тэр ажлын хэсгийн нэр бол ер нь “Өмнийн говийн усан хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр санал боловсруулах” ажлын хэсэг байгаа. Нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй. Мэргэжлийн байгууллагуудаас ороод явсан.



Энэ ажлын хэсэг ажиллаад үндсэн хэд хэдэн шийдлүүдийг гаргаад тэгээд үйл ажиллагааны хөтөлбөрийн энэ төслийн 2.2.4.2, 2.2.4.3 гэсэн хэсгүүд дээр заалт болгож оруулсан.

Энэ нь говийн бүсэд байгалийн ургамлын бүрхэвчийг нэмэгдүүлэх замаар бэлчээрийн доройтлын бууруулах, элсний нүүлтийг сааруулна.

Нөгөөх нь, говийн болон ус хангамжийн дутагдалтай бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилтот төслүүдийг төслүүдийг хэрэгжүүлэх гэж.

Тэрний дараа “Хэрлэн-Онги” голд урсцын тохиргоо хийнэ гэж байгаа.

Бид зөвхөн энэ олон жил ярьж байгаа “Хэрлэн-Тооно”, “Орхон-Онги” төслүүдээс гадна бусад дэвшилтэт технологиудыг нэвтрүүлэх арга замуудыг хайж байгаа.

Тухайлбал, газрын доорх усны нөөцийг зориудаар баяжуулах  MAR MANAGED  гэж технологи байгаа юм.

Үерийн усны юм уу, бусад гадаргын усыг гүний усны тодорхой түвшинд буцаан оруулж гүний усны түвшнийг нэмэгдүүлдэг ийм туршилтын төслийг бид өнгөрсөн хугацаанд Багануур дүүрэгт хэрэгжүүлсэн. Тэгээд амжилттай болсон учраас усны дутагдалтай бүсүүд рүүгээ энэ технологийг нэвтрүүлээд явъя гэдэг ийм зүйл ярьсан.

Дараагийнх нь далд усан сан, нэвчүүлэх цооног байгуулах ийм шийдлүүдийг гаргаж ирж байгаа.

Энэ дээр манай усны газар ажиллаад явж байгаа.

Ганцхан энэ гадаргуун ус хуримтлуулснаар энэ усны асуудал шийдэгдэхгүй.

Тийм учраас бид энэ цаг агаарт зориудаар нөлөөлөх чадавхыг бэхжүүлэх гэсэн энэ төслүүдийг олон улсын санхүүгийн байгууллагууд, санхүүжүүлэгч нарт тавиад тэргүүлэх ач холбогдол өгөөд явж байгаа.

Тэрний дараагийн асуудал энэ ургамалжилтын асуудал байгаа. Цөлжилт газрын доройтлийг бууруулах бас нэг гол шийдэл бол ургамалжилт.

Ургамалжилтыг бид яаж дэмжих вэ, тэтгэх вэ гэхээр нэг талаас эдийн

засгийн хөшүүрэгтэй болгоё.../минут дуусав/

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн асууя. Ц.Мөнхбат гишүүн тодруулья.

Ц.Мөнхбат: 2025 онд 500.0 тэрбум жишээ нь энэ “Шинэ хоршоо” руу чиглэх юм байна гэж ингэж ойлголоо.

Одоо зогсчихоод байна уу? Эх үүсвэр нь дуусчихаад зогсожчихоод байна. Тийм үү? Ойлголоо.

Хоёрдугаарт, нь арьс ширний 2 цогцолбор маань явах юм уу? Ямар хэмжээтэй байгаа юм бэ гэдэг дээр хариулт авч чадсангүй.

Байгаль орчны яаман дээр тэр нөгөө төсөл, хөтөлбөрүүд. Тийм.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулья.

Ж.Энхбаяр: Арьс ширний салбартай холбоотойгоор 3 газар томоохон хөрөнгө оруулалт, зураг төслийн, газар олголтын асуудал шийдвэрлэгдсэн.

Нэгдүгээрт нь, Ховд аж үйлдвэрийн парк байгаа юм.

Тэрний цэвэрлэх байгууламж, дэд бүтцийн холболт, барилгын ажлууд нэлээн өндөр үр дүнтэй явж байгаа.

Хоёрдугаарт нь, Дархан хотыг түшиглээд арьс ширний үйлдвэрийн парк. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай **“Арьс ширний үйлдвэрийн парк-1”**.

Мөн Засгийн газрын хөрөнгө оруулалттайгаар тусдаа “Арьс ширний үйлдвэрийн парк-II” гэсэн ийм хоёр хувилбар явж байгаа.

Хувийн хэвшил маань нэлээн маргаан үүсээд Хөгжлийн банктэй зээлтэй холбоотойгоор шүүх үйл ажиллагаанд орчихсон гээд маргаантай явж байгаа.

Төрийн арьс ширний үйлдвэрийн парк Дархан хотоос 25 га талбайг аваад, түүндээ дэд бүтэц, цэвэрлэх байгууламжийг хийх зураг төсөл нь хийгдчихсэн. Улсын төсөвт тодорхой эх үүсвэрүүд нь суучихсан явж байгаа.

Засгийн оролцох бодлого хамгийн хүнд газрыг нь шийдээд өгье, дэд бүтцийг нь татаад өгье, цэвэрлэх байгууламжийг нь бариад өгье.

Дээр нь баригдах асуудал бол хувийн хэвшлийн асуудал.

Бид бодлогын хувьд зөвхөн арьс шир гэж авчрахгүйгээр “Хөнгөн үйлдвэрийн парк” гэж оруулж байгаа.

Энд ноосоо угаана уу, арьсаа элдэвшүүлнэ үү, янз янзын тэр аль аль нь хөрөнгө оруулах нь нээлттэй байдлаар гаргая гэсэн бодолтой.

Гүравдугаарт нь, “Эмээлтийн аж үйлдвэрийн парк” буюу Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтаар Эмээлтэд ажил нэлээн 40 хувьтай гэлүү, 60 хувьтай гэлүү ийм гүйцэтгэлтэй гэсэн ийм мэдээ авсан.

Ингээд үндсэндээ Дархан, Эмээлт, Ховд гэсэн 3 газар нэлээн томоохон хэмжээний арьс шир боловсруулах ийм ажлууд хийгдэж байгаа.

Мэдээж үүнийгээ гүйцээж дуусахын төлөө явна. Үүнийгээ бүтгийг нь “Цагаан алт” гэдэг хөтөлбөр лүүгээ оруулсан.

“Цагаан алт” хөтөлбөрийн маань гол агуулга бол ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүнийг эцэслэн боловсруулах, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх гэсэн ийм зорилгын хүрээнд хийгдэж байгаа. Эх үүсвэр нь суучихсан.

Б.Бейсен: 3 номерын микрофон хариулъя.

Э.Баттулга: Байгаль орчны чиглэлээр 20 гаруй олон улсын санхүүжилттэй төслүүд хэрэгжиж байгаа.

Тэгэхдээ ихэнх нь техникийн туслалцааны гэхээсээ илүүтэйгээр чадавх бэхжүүлэх төслүүд байдаг.

Говийн бүсэд хэрэгжиж байгаа төслүүдээс онцлох төслүүдийг говийн “Мазаалай баавгай хамгаалах” төсөл байгаа. Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хэрэгжүүлж байгаа.

Ойрын хугацаанд хэрэгжүүлэх төсөл бол энэ “Цөлжилттэй тэмцэх судалгааны төв” байгуулах төсөл байна.

Их төлөв ховордсон амьтдыг хамгаалах чиглэлийн жижиг төслүүд байгаа. Ялангуяа дэд бүтцийн нөгөө шугаман байгууламжид зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахтай холбоотой энэ талын зохицуулалтуудыг боловсронгуй болгох төслүүд байна.

Хамгийн сүүлд эхэлж байгаа энэ говийн бүстэй холбоотой уул уурхай их явагддаг бүс нутгууд ач холбогдолтой төсөл бол энэ биологийн нөхөн

сэргээлтийн аргачлалыг боловсронгуй болгох төсөл байгаа.

Ердөө техникийн нөхөн сэргээлтээ хийчхээд, ерхөг, шогооворын үр цацаад явдаг байдлыг нь арилгаад тухайн унаган ургамал байгаль орчны үнэлгээгээрээ яаж гарсан юм, тэрийг нь буцааж сэргээдэг. Энэ дээрээ үндэслээд нөгөө ургамлын гений банк байгуулах. Тэндээсээ яг унаган ургамалыг буцааж авч ашиглаад хуучин хэвэнд нь оруулж биологийн нөхөн сэргээлтийг жинхэнэ утгаар нь хийх ийм төсөл эхэлж байгаа.

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа.

Тэгэхээр хоёр чиглэлээр ярья.

Нэгдүгээрт, цаг үеийн ажил асуудлуудын талаар бид анхаармаар байна.

Ер нь Монголд энэ луу жилүүд ямархуу болж өнгөрч байсан юм, аль бүс нутагтаа хүндрээд байсан юм гэдэг юмаа нэг жоохон тандмаар байна.

Намайг энэ орон нутгийн ажил амьдрал үүрч байх үед өмнөх дарга нарын хэлж байсан юм бол Төв аймагт энэ луу жил ер нь жоохон төвөгтэй болдог юм шүү. Мич жил гэж яриад байдаг боловч гэдэг юм яриад байдаг байсан байхгүй юу.

Тэгэхээр үүнийг нэлээн анзаарч бид өвөлжилтийн бэлтгэлээ хангах ёстой. Үүнийг нэг судалъя гэж.

Хоёрдугаарт, малаа ангилж, мах бэлтгэлээ нэмэгдүүлж малчдаа орлогожуулъя. Тэгж байж хэдүүлээ

өвөлжилтийн бэлтгэл хангах тухай асуудал яригдана.

Гуравдугаарт, өвс, тэжээлийн бэлтгэлт, нийлүүлэлт, борлуулалтын асуудлыг шийдэхгүйгээр бид явахгүй. Үүнийгээ нэг анхаараадхаач гэсэн нэг санаа байна.

Улсын төсөвт тодотгол хийгдэж байгаа цаг үетэй яг давхцаж байгаа шүү дээ.

Тийм учраас Байнгын хороо их санаачилга гаргаж улсын төсвийн тодотгол дээр энэ хөдөө аж ахуйг, дам дамаа энэ “Шинэ хоршоо”-г дэмжих чиглэлээрх зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүүгийн зөрүү олгох хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж батлах дээр л хэдүүлээ анхаарах ёстой. Тэгж байж энэ чинь амь орох ёстой зүйл байхгүй юу.

Тэгэхээр одоо төсөл дээр явж байгаа 120 хэдэн тэрбум билүү дээ. Би тэгж санаад байна. Түүнийг нь ахиухан шиг дэмжээд, болж өгвөл хэлэлцүүлгийн түвшинд жоохон нэмэгдүүлээд баталчих ямар боломж байна вэ гэж.

Цаг үеийн ажил, асуудлын талаар нэг ийм хэдэн зүйлийг анхааралдаа авч яам маань бэлтгэлээ хангавал яасан юм гэж.

Хоёр дахь зүйл. Хөтөлбөртөө холбоотой юм.

Төвийн бүсийг хэдүүлээ эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн төрөлжилт, эрчим хүчний дэд бүс гэж нэршмээр байна.

Би учир шалтгааныг нь эртээд хэлэлцүүлгийн түвшинд ярьчихсан. Одоо

ингээд минут цөөхөн болохоор яриад байх боломжгүй гэж.

Мал аж ахуйн салбар дээр хоёр зүйл анхаармаар байгаад байдаг.

Бид хэдийн бодлого бол цогцоороо явж байгаа. Гэхдээ илэрхийлэлт, энэ бичилтүүдийг харахаар дан эрчимжсэн аж ахуй руугаа чиглэхээд байгаа юм шиг харагдаад ерөөсөө болж өгөхгүй юм.

Тэгэхээр уур амьсгал, байгаль цаг ууртаа дасан зохицсон тэр тэсвэрт чанартай нутгийн шилмэл малаараа үржлийн ажлаа явуулах бүс нутгуудаа их тодорхой болгож, үүнийгээ орхигдуулалгүй зэрэгцүүлж явах асуудлаа энэ хөтөлбөр юмандаа их тодорхой тусгаж, хөрөнгө мөнгөө чиглүүлэх ёстой гэж нэг ийм зүйл хэлмээр байна.

Хоёр дахь зүйл. Газар тариалангийн бүс нутагтайгаа давхцуулж өнөө өндөр ашиг шимт малаа хөгжүүлэх юмаа тов тодорхой авч хэрэгжүүлж байж энэ хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ. Энэ талаар тодорхой юмнууд орсон юм билээ.

Тэжээлийн талаар дуугарчихсан юм билээ. Зүгээр ашиг шимийн чиглэлтэй найрлах тэжээлүүдийн бэлтгэлтийн асуудал байгаа юм.

“Тэжээл” гээд хэлчхээр ерөнхий дуугарчхаад ерөөсөө болж өгөхгүй байгаа байхгүй юу. Сүүний мал нь юу идэх юм.../минут дуусав/

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүн нэмж асуулт асууя.

Ж.Батжаргал: Энэ талаар ер нь ямархуу чиглэл байна вэ? Ер нь хараад байгаа гэж.

Хоёр дахь зүйл. Энэ сорт сорилын төв, үрийн аж ахуйнуудаа хэрхэн яаж дэмжиж, үрийн шинэчлэл хангалттай хийх юм бэ гэдэг юмыг хэдүүлээ тодорхой болгохгүй бол болохгүй байгаа. Үүнийг юу гэж бодоод байна вэ? Нэг.

Хоёрдугаарт, энэ үрд урамшуулал өгөх юм уу? Дан дамаа гол тарималын үрүүдэд урамшуулал өгч байж энэ аж ахуйнууд чинь босож ирэх юм байна лээ шүү. Тэгэхгүй бол явахгүй байгаа гэж.

Дараагийн нэг зүйл. Хэдүүлээ баахан үйлдвэр ярьдаг юм. Тэгээд болж өгөхгүй байгаа юм нь юунд байгаа вэ гэхээр би ингэж хараад байдаг байхгүй юу.

Үйлдвэр, технологийн парк байгуулж байгаа бол тэр орон нутгуудад хагас гэдэг юм уу, анхан шатын боловсруулалт хийсэн жижиг үйлдвэрүүдтэйгээ үүнийгээ уяхгүй бол явахгүй байгаа юм.

Сумандаа яаж түүхий эдээ бэлтгэж авч, ямар хэмжээний боловсруулалт хийж, тэндээ ажлын байр бий болгох юм. Дахиад дараагийн шатын тэр үйлдвэр, технологийн паркуудтайгаа яаж технологийн хоршилт хийж, эцсийн бүтээгдэхүүн болох юм гэдэг юмыг л зөв шийдэж чадах юм бол Монгол үйлдвэржих бололцоо байгаа. Бүс нутгууд бас нэг жоохон хөгжих бололцоо байгаа. Үүнийг л хэдүүлээ хэлхээг нь зөв харж, зөв томьёолж, бодлогоо чиглүүлж чадвал болно. Энэ тал дээр Та хэдийн бодлого чиглэл юу байна вэ гэж.

Дараагийн нэг зүйл. Энэ “үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх” гэдэг юм сүүлийн үед яригдаад байх болчихлоо.

Үүнтэй уялдаж тэр стратегийн нөөц, технологийн нөөц бүрдүүлэлтийнхээ асуудлыг шийдэхгүй бол болохгүй болчихоод байгаа юм.

Улаан буудай дээр 100 мянган тонн улаан буудай нөөцлөх ёстой. 18-аас 20 мянган тонн үрийн будаа нөөцлөх ёстой.

Үүнийг энэ бодлого, хөтөлбөрт суулгаж жил жилийн төсөвт хөрөнгө мөнгийг нь тусгаж явахгүй бол энэ чиглэлийн ажил цаашаагаа явахад нэлээн төвөгтэй байх гээд байна уу гэсэн нэг ийм зүйл харагдаад байх юм. Энэ дээр ямар бодол байна.

Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчин, малчид, тариаланчдын залуу халааг бэлтгэх асуудлыг энэ хөтөлбөрт тусгахгүй бол энэ салбар цаашаагаа хүний хүчин зүйлээс хамааралтай, боловсон хүчний хүчин зүйлээс хамааралтай явж өгөхгүй байгаа шүү.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулъя. 4 номер.

Ж.Энхбаяр: Хүний нөөц шинжлэх ухааны бодлогоос нь эхэлье.

Уг нь яг энд хамт Боловсролын сайд энэ Байнгын хороонд л орж ирэх ёстой болоод байгаа юм.

Бүх шинжлэх ухааны шийдэл нь Боловсролын яам авчихсан. Хүний нөөцийн Боловсролын яам авчихсан.

Яг үнэндээ Хөдөө аж ахуйн яам нэг том толгой л байна. Хөдөө аж ахуйн салбарын шийдэл шинжлэх ухаан дээр суурилж гарах ёстой. Бидний бүх бичиг баримт “шинжлэх ухаанч” байх гээд гаргаад ирчихсэн. Бидэнд тийм бололцоо байхгүй.

- *Боловсролын яам руу бичиг явуулна.*
- *Боловсролын яам Хөдөө аж ахуйн их сургууль руу бичиг явуулна.*
- *Хөдөө аж ахуйн захирал нь Мал эмнэлгийн хүрээлэн рүү бичиг явуулна.*
- *Тэндээс бодлого гараад буцаж дамжиж ирнэ.*

Яг ийм л нэг ийм бүтцийн хувьд маш том ноцтой алдаатай байдал үүсчхээд байгаа юм. Үүнийг яаралтай засахгүй бол салбар өөрөө шинжлэх ухаанаасаа хөндийрчихсэн.

Үүнтэй холбоотой таны саяын санал бол дандаа л бодлогын асуудал. Хэрхэн шинжлэх ухаанч хөгжүүлэх вэ гэж асуулт гараад байна шүү дээ.

Тэр болгоны хариултыг өгөх ёстой мэргэжлийн тэр эрдэмтэн, судлаачид, хүрээлэнгүүд нь хашааны цаана гараад суучихсан. Нэг л ийм л байдалтай болчихоод байгаа юм.

Мэдээж яам бол өдөр тутмынхаа аж ахуйн үйл ажиллагаандаа зохион байгуулалт хийгээд явж байна.

Энэ үр сорт дээр онцгой анхаарна. Үнэхээр шинжлэх ухаанч биш болохоор манай тарьж байгаа таримлын үр, сортын бодлого алдагдсан.

Нөгөө дотооддоо үржүүлдэг шинэ таримал сортыг баталгаажуулдаг ажлууд маш муу болсон. Үүнийгээ дагаад гаднаас төрөл бүрийн импортын үрээр тариалалт явагдаж байна. Дагаад төрөл бүрийн хөрсний өвчлөл үүсэж байна.

Монгол Улсад байгаагүй янз бүрийн шавж үүсэж байна. Үүнийгээ дагаад газар тариалангийн салбарын хор, бордоо, гербицидийн зардал эрс өсөж байна.

Тэгэхээр үр сортын аж ахуйнуудыг яаралтай байгуулах хэрэгтэй болж байгаа юм. Үүнийг бид хийхээр төлөвлөж байна.

Нөгөө талдаа мал аж ахуй адилхан. Үржлийн аж ахуйнуудыг зохион байгуулж, мах нь махаараа, сүү нь сүүгээрээ ингээд төрөлжүүлэн хөгжүүлэх юмаа хийхгүй бол махлаад мах гардаггүй, саагаад сүү гардаггүй ийм л мал сүрэгтэй болж хувирчхаад байгаа юм.

Түрүүн хэллээ. Амьдын жин 30 жилийн дотор эрс багаслаа. Гарч байгаа ноос, ноолуур, арьс ширний бүтцэд маш ноцтой өөрчлөлтүүд орчихсон.

Тэгэхээр үүнийг засахын тулд “шинжлэх ухаанч” тэр судалгаанууд, тэр эрдэмтдийн бүтээлүүд л бидэнд хэрэгтэй байгаа юм л даа.

Харамсалтай нь тэрийг маань одоо ингээд шинжлэх ухаан гэдгээр нь Боловсролын яам авчхаад энэ салбарын том байдал их тун хүнд байгаад байгаа юм.

Аж үйлдвэржилтийг сум, орон нутгийн бүтэцтэй нь яаж холбох вэ гээд. Хамгийн анхны доод суурь нэгжээ бид энэ малчдаа нэг хоршоолсон малчид. Үүн

дээр нэмэх нь сум дундын хоршоодоо үүсгээд. Тэгээд хоршооны түвшинд, сум дундын хоршооны түвшинд, аймгийн төвд байгаа үйлдвэрлэлийн түвшинд, нэгдсэн том аж үйлдвэрийн паркийн түвшинд гээд боловсруулалтуудыг нь тэр гинжинг буюу нэмүү өртгийн сүлжээг нь их зөв тооцоод ингээд нэг бүсчилсэн маягаар л зохион байгуулахаар л.../минут дуусав/

Б.Бейсен: Сайд гүйцээж хариулья.

Ж.Энхбаяр: Ер нь цаашдаа ингэж “кластер” буюу яг анхан шатны түүхий эд нийлүүлж байгаа малчин, тариачин, ногоочин, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэгч хоёрын холбоосыг л нэг шугам дээр тавихгүй бол ажил явахгүй юм билээ гэдэг нь тодорхой.

Тэгэхээр энэ чиглэлээр ажлууд хийгдэж байна.

Нөөцтэй холбоотой. Үнэхээр санаа зовж байна. Гадаад орчин хүндэрч байгаа. Ялангуяа стратегийн нөөцийг эрс бүрдүүлэхгүй болохгүй.

Сая Аюулгүйн зөвлөлийн танилцуулга дээр хамгийн сүүлд дүгнэлт дээр стратегийн хүнсний нөөцийг яаралтай бүрдүүлээрэй. Дэлхий ертөнц ер нь тун эмзэг байдал руугаа орж байгаа шүү гэсэн.

Харамсалтай нь энэ бас л хангалтгүй буюу бас л төсөв, санхүү дээр ерөөсөө явж өгөхгүй байна.

Мах бэлтгэлтэй холбоотой асуудлуудыг жишээлбэл Улаанбаатар хотын мах бэлтгэлийг нийслэл Улаанбаатар хотод шилжүүлсэн байна.

Нийслэл Улаанбаатар хот өөрөө зохион байгуулж хангалттай хийдэг болсон байна.

Луу жил ер нь олон жилийн туршлагаар их хүнд өвөл болдог.

Энэ жил 2 долоо хоногийн өмнө үр тариа боловсорч байна. Тариалан хураалт эхэлчихсэн байна. Хулгана, зурам хөөсөгөө эрт зөөж байна. Байгалийн жимс, ногоо эрт боловсорч байна. Энэ жил цаг эрт хүйтрэх нь л гэдэг ийм төлөв байдал гараад байна.

Тэгээд “Шинэ хоршоо” дээр чинь 500.0 тэрбумын эх үүсвэр арилжааны банкуудаар олгогдоод, бид төсөв дээр юу авч байна гэвэл сарын 5 тэрбум төгрөгийн хүүгийн зөрүү өгч байгаа юм.

Улсын төсөв 12 хувийн хүүгийн ачааллыг дааж байгаа. Үүнийг нь сард нь хуваавал нэг сард нэг хувийн ачааллыг л малчдын өмнөөс төсөв суулгаж төлж байгаа.

Энэ жил 25 тэрбум орчим суусан. Ирэх онд 24 орчим тэрбум байгаа.

Ингээд суулгаад яваад байвал малчид маань овоо зохион байгуулалтад ороод явах юм болов уу л гэж.

Төвийн бүсийг эрчимжсэн хөдөө аж ахуйн бүс гэж томъёолох нь зүйтэй. Үүнийг Та зарчмын зөрүүтэй санал гаргаад Байнгын хороогоор дэмжүүлчихвэл. Одоо л оруулах ёстой.

Яамнаас оруулсан боловч энд ямар учир шалтгаантай юм бүү мэд. Тэр “эрчимжсэн” гэдэг үгүүд хасагдаад байгаа. /минут дуусав/

Б.Бейсен: Хариулт болсон уу? Тодруулах уу? Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм. Хоёр зүйл байгаа юм.

Бид хэд энэ хамгаалагдсан аж ахуйг нэлээн яриад өнөө тайван бүсийнхээ асуудлыг жоохон бүдгэрүүлээд байгаа.

Халдварт өвчний голомтгүй тайван бүсийн асуудлыг илүү онцгой авч үзээд, тэгээд тэр дотор хамгаалагдсан аж ахуйн тухай л яригдах ёстой. Үүнийг ер нь нэлээн сайн анхаарах ёстой шүү гэж. Нэг ийм зүйлийг хэлье.

Байгаль орчны чиглэлээр хоёр, гуравхан зүйл байгаа юм. Байгаль орчныг хамгаална гээд бид хэд нэлээн сайн ярьдаг юм.

Тэгээд энэ байгалийн нөөцийн төрөл зүйлсийнхээ нөөцийг тогтоогоод, түүнийгээ зүй зохистой ашиглах, хамгаалах асуудал л хамгийн гол зүйл байх ёстой. Үүнийгээ та хэд энэ хөтөлбөр юмнууд дотроо нэлээн сайн оруулж өгөх ёстой гэж.

Дээр нь энэ “[дүйцсэн хамгаалалт](#)”-ын зарчмыг бид одоо нэлээн хатуу барих ёстой.

Дэлхий нийтээрээ энэ хүлэмжийн хий ялгаруулаад байгаа томоохон корпорациуд “[дүйцсэн хамгаалалт](#)” руу хөрөнгө гаргаад байна. Үүнээс олж авах боломж их өргөн байна.

Үүнийг ашиглах талаар ер нь нэлээн сайн бодмоор байна.

Энэ үндэсний хэдэн том дан дамаа заяагдмал баялаг дээр тулгуурлагдсан үйлдвэрүүд чинь “дүйцсэн хамгаалалт” хийх ёстой шүү дээ. Дэлхий нийтийн хандлага ийм болчихоод байхад.

Үүнийг зөв харж байгаль орчны хамгаалалтын чиглэл рүү зөв ашиглах зайлшгүй шаардлага байна. Энэ талаар хөтөлбөрт юу оров? Би олж уншиж чадахгүй яваад байна уу гэдэг нэг ийм зүйл байх юм.

Дараагийн нэг зүйл. Байгаль орчны яам энэ ашиглагч яамд, салбартайгаа их сайн хамтарч ажилламаар байна.

Цөлжилтийн тухай ярина. Та хэд дангаараа яриад бүтэхгүй. Наад Хөдөө аж ахуйн яамтайгаа ярь. Мал аж ахуйн салбар нь наад дээр чинь байгаа.

Уул уурхайн юм ярина. Тэр сайдтайгаа, тэр яамтайгаа ярь.

Тэндээс шаардлагатай хөрөнгүүдийг нь гаргуулж энэ асуудлаа шийд ээ. Тэр аж ахуй түншлэлийнх нь хүрээнд байдаг юм уу. Үүнийг хийх талаар энэ хөтөлбөрт ер нь эрх зүйн зохицуулалтынх нь хүрээнд бид юу харж, юу бодоод байгаа юм гэдэг юм нэг чухал байна.

Дараагийн нэг зүйл.../минут дуусав/

Байгаль орчны яам хариулъя. 3 номер.

Э.Баттулга: Гишүүний асуултад хариулъя. Сүүлээс нь эхлээд хариулчихъя.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх чадавх бэхжүүлэх дээр түрүүн бид онцгой анхаарч байгаа гэдгийг хэлсэн. Олон улсын сангуудаас санхүүжилт авах гол чиглэл маань байгаа.

Одоогийн байдлаар ерөөсөө 46 хөдөлгөөнт экспедиц, 36 газрын генератор л байгаа юм. Энэ болохоор өргөн уудам нутаг дэвсгэртэй Монгол орны хувьд яагаад ч энэ хүрэлцээтэй байж чадахгүй байгаа.

Хоёр дахь асуудлын хувьд энэ байгалийн нөөцийн тогтвортой менежмент гэдэг дээр бид маш чухал ач холбогдол өгч байгаа.

Үүнтэй холбоотой заалт 3.1.1.2 дээр байгаа. Дүйцүүлэн хамгаалал болон та бас юу ярьж байх шиг байна? Нөгөө нүүрсхүчлийн хийн худалдаа, “carbon credit”, “carbon trade” гээд сүүлийн үед энэ Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйл 6.2-г заасан энэ хамтарсан кредит олгох механизм гэдэг зүйлийн талаар дэлхийн улс орнууд их хүчтэй ярьж, үүнийг эдийн засгийн мөнгө болгох арга замуудаа эрэлхийлж байгаа.

Тэгэхээр бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртөө яг энэ талаар 3.1.2.2 дээр заалт болгоод оруулчихсан, бүр бүлэг байж байгаа. Уур амьсгалын өөрчлөлт гэсэн.

Бидний хувьд эхний ээлжид Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулиа боловсруулж, энэ анхдагч хуулийг өргөн барина.

Үүний дараа хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлнэ гээд нэг чухал ажлууд байгаа юм. Энэ яах вэ гэхээр хүлэмжийн хийн шингээлт гэдэгтээ юу гэж тооцох юм, бууралт

гэдэгтээ яаж тооцох юм, нэг тонн хүлэмжийн хий бууруулахад ямар өртгөөр тооцож шингээсэн байгууллагаасаа мөнгөө олж авах юм гэх мэтчилэн арга аргачлалуудаа тодорхой болгох энэ ажлууд хийгдэнэ.

Тэгээд түрүүн би хэлээгүй орхичхож. Манай дээр энэ санхүүгийн шинэлэг арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, тухайлбал ногоон зээл, ногоон бонд, ногоон бирж, ногоон даатгал, өрийн солилцоо.../минут дуусав/

Б.Бейсен: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр чуулганы хуралдаан дээр хэлэлцэх эсэх асуудал хэлэлцэж байх үед ерөнхийд нь асуусан.

Энд яг салбарын асуудлууд яригдах учраас би нэлээн тодорхой асууя гэж бодож байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 25, 26 зүйл заалтууд орж байгаа юм байна. Үүнийг уншаад үзэхээр яг л хөдөө аж ахуйн салбар дээр, малчид дээр гардаг бэлчээр, газар тариалан, эрчимжсэн бэлчээр, малын өвчин зовлон гээд л бүх л юмнууд орсон байна.

Гэхдээ энэ тусгасан ажлаа хэрэгжүүлэх гол хүчин зүйл би санхүүгийн эх үүсвэр гэж харж байгаа. Одоо ингээд төсвийн тодотголоор 14 том төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр орж ирж байгаа.

Тэгээд энэ дотор хөдөө аж ахуйн салбартай холбоотой нэг ч юм байхгүй байгаа.

Гэтэл хөдөө аж ахуйн салбарын доголдол, эдийн засгийн энэ өсөлт, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, бүх юман дээр сөргөөр нөлөөлж эхэлж байгаа.

Тэгэхээр жишээ нь одоо Биокомбинатыг дотооддоо вакцинаа үйлдвэрлэдэг болно гэдэг том зорилт тавьчихсан байна.

Би 2021 онд 3.Мэндсайхан сайдыг байхад яг энэ Биокомбинатын асуудлаар 10 сарын 22-нд асууж байсан юм. Удахгүй Унгарын Засгийн газраар хийнэ л гэсэн.

Өнөөдөр 2024 оны 7 сар, 8 сар энэ ажил огт яваагүй.

Тэгэхээр ирэх 4 жилд энэ Биокомбинатынхаа асуудлыг ядаж шийдвэрлэх хөрөнгийн эх үүсвэрийг хаана харж байгаа юм бэ?

Энэ 25 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрүүдээ ер нь яаж төлөвлөж байгаа юм бэ гэж нэгдүгээрт асуумаар байгаа юм. Энэ томоохон төсөл, хөтөлбөрт оруулах бололцоо байсангүй юу?

Хоёрт нь, 2025 он яг төсвийн шинэ хуулийн дагуу одоо бараг боогдоод дуусаж байгаа.

Магадгүй та хэд ингээд энэ мөрийн хөтөлбөр батлагдахаар дараа нь нөгөө үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдана. Тэр дээр сууна гэж хариулах байх.

Гэхдээ цаг хугацаа болон төсвийн хуулийн дагуу 2025 онд энэ төсөл, арга хэмжээнүүдээсээ хэдийг нь өнөөдөр Эдийн засгийн яам руу, Сангийн яам руу хэрэгжүүлэхээр саналаа өгөөд явж байгаа вэ? Ингэж байж энэ чинь 2025 онд ажил хэрэг болно.

Тэгэхээр би энэ дээр тодорхой асуултууд авмаар байна. Хариултууд авъя. Яагаад гэвэл энэ Байнгын хороо энэ хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааг явуулахад энэ төсөв санхүүгийн энэ асуудал дээр ч гэсэн бид яамтай бас бодлогоо нэгтгээд ингээд явах нь зүйтэй.

Тэгэхээр яамны зүгээс шалтгаалах, үүнийгээ хийсэн үү гэдгийг би Та бүхнээс асуумаар байгаа юм. Энэ 25-аас аль нь явж байгаа юм бэ? Хугацаа дуусах гээд байдаг.

Дараагийнх нь, энэ хоршоотой холбоотой асуудал. Одоо 100 гаруй тэрбум төгрөг суух гэж байна.

Б.Бейсен: Хариулт авчихаад тодруулаарай.

Хөдөө аж ахуйн яам. 4 номер.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуйн салбарын хувьд харьцангуй бодлогуудаа багцлаад,

- “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрүүдээ,
- Хоршооны хүрээнд малчдынхаа асуудлыг,
- “Атар-IV” гэдгийн хүрээнд тариаланч, тогоочдынхоо асуудлыг ер нь ингээд багцалчихсан. Боломжийн.

Тодорхой эх үүсвэрүүд нь дандаа Улсын Их Хурлын тогтоолтой, төсөвтэй. Дагалдаад овоо суучихсан.

Тэгээд үүгээрээ сая бид энэ төсөв батлахад нэлээн олон зүйл зүтгүүлсэн боловч зарим зүйлүүд нь хасагдсан. Гэхдээ боломжийн.

Одоо энэ хөтөлбөр суусан арга хэмжээнд хэрэгжүүлэхэд салбарт нэлээн бодитой үр дүнгүүд гарна гэж бодож байна.

Биокомбинаттай холбоотой Унгарын Засгийн газартай хамтран хийх тэр асуудал үндсэндээ Унгарын тал татгалзсан. Хэрэгжүүлэх бололцоогүй гэдгээ мэдэгдсэн байна.

Гэхдээ бид бас зүгээр суугаагүй. Өөрийн дотоод эх үүсвэрүүдээрээ дотоод энэ вакциныхаа шугамыг, савлах шугамыг шинэ вакцины үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлуудыг хөөрхөн хийж байна.

Иж бүрэн шинэчлэх тэр зураг төсөл, ТЭЗҮ-гээ үндсэндээ бүрэн боловсруулсан.

Ер нь гишүүдийг Биокомбинат дээр уримаар байгаа юм. 100 жилийн ой болж байгаа.

2023 онд юм байна. Анх мялзангийн станц гэж байсан юм байна. Энэ Оросын. Биокомбинатад. Тэрийг худалдаж авснаар энэ анх удаа Монгол Улс дотооддоо мал сүргээ эрүүлжүүлэх ажил эхэлсэн юм байна.

Ер нь их суурь их сайн технологитой, сайн боловсон хүчинтэй, 100 жилийн түүхтэй ийм томоохон үндэсний том үйлдвэр байгаа.

Энэ дээр бид хоёр, гурван хувилбараар хөгжүүлэлтийн бодлогыг даалгавар өгөгдөөд явж байна.

- *Нэгдүгээрт, улсын төсвөөр хийгдэх.*
- *Хоёрдугаарт, гаднын зээл, тусламжаар хийгдэх.*
- *Гуравдугаарт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийж,*

энэ улсын үйлдвэрийн газрыг олон нийтэд нээлтэй хувьцаат компани маягаар зохион байгуулж, эх үүсвэр татах ийм гурван хувилбарыг гишүүдэд танилцуулахаар бэлдэж байгаа.

Ер нь жоохон тордчиход бид дотооддоо вакцинаа 100 хувь үйлдвэрлэх бололцоотой, эдийн засгийн хувьд үр ашигтай төсөл байгаа.

Бид 2025 оныхоо төсвийн төсөөлөл, бүх юмаа Сангийн яаманд хүргүүлсэн. Мэдээж аль болох л ахиухан. Мэдээж төсвийн хязгаар гээд Сангийн яам нэлээн хязгаарлаж байгаа тэр дүнгээс бид хоёр, гурав дахисан, давсан хэмжээний л санал, хөтөлбөрүүдээ тэргүүн ээлжид тавиулах гээд бүх саналаа өгчихсөн. Тэгээд энэ болгон чинь тэгээд Сангийн яам дээр шүүгдээд Эдийн засаг, хөгжлийн яамны бодлого дээр нийцүүлээд гарах байх.

Ер нь энэ богино хугацаанд уул уурхайн таатай үеийг ашиглаад хөдөө аж ахуйн салбараа, аж үйлдвэрлэлээ л яаралтай босгож авах нь Монгол Улсын тэргүүлэх эрх ашиг байна гэж үзэж байна даа. Үүнийг л бүгдээрээ хамтраад хийвэл уул уурхайн таатай үеийг ашиглаад энэ салбараа босгоод авах нь, малаа эрүүлжүүлээд авах нь.

Б.Бейсен: Ц.Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Би төсөвтэй холбоотой юм асуугаад байдаг нь мэдээж яамны явуулсан санал нэлээдгүй танагдана.

Тэгэхээр нэг номерт аль нь байх вэ гэдэг дээр бид саналаа нэгтгэх нь зүйтэй болов уу. Ингэж байж явах болов уу гэж.

Хоёрдугаарт, Биокомбинатыг онцлоод байгаа нь өнөөдөр түүхий эд Хятад руу чөлөөтэй гаргаж байгаа шүү дээ. Авахгүй байгаа. Мах гаргаж байгаа. Бас хязгаарлагдмал байгаа. Шалтгаан ердөө л малын өвчин.

Тийм учраас өвчнөө дарна гэж байна. Зөв харжээ гэж хэлмээр байна.

Харин үүнийгээ хэрэгжүүлэхэд санхүүгийн эх үүсвэр нь тодорхой байгаасай гэсэн үүднээс үүнийг асууж байгаа юм гэдгийг хэлье.

Хоршоотой холбоотой миний гурав дахь тодруулах зүйл.

Одоо ингээд 100 гаруй тэрбум төгрөг тавина. Одоо ингээд хүсэлтээ өгсөн хүмүүс оны сүүл гэхэд авчих байх.

Ирэх оны төсөв дээр дахиад бидэнд энэ хоршооны эх үүсвэр дээр 1 их наяд төгрөг хэрэгтэй болно. 1 их наяд төгрөг.

Үүнийг 2025 оны төсөв дээр яаж харж байгаа вэ. Сангийн яамтай үүнтэй яаж ойлголцож байгаа вэ?

Би нэгдсэн чуулганы хуралдаан дээр асуусан. Болно гэсэн юм ярьж байгаа.

Би тэгээд энэ Байнгын хороон дээр илүү детальчилж ярих учраас тодорхой асуугаад байгаа юм шүү гэдгийг би онцгойлж хэлье гэж бодож байна.

Хоршоотой холбоотой нэг зүйлийг бас дахиад хэлчихэд энэ удаагийн олгож байгаа хоршооны зээлүүд нэлээн онцлогтой. Хувь хүний гар дээр мөнгө очихгүй. Шууд худалдан авалтуудыг нь хийгээд банкнаас шилжүүлж байгаа гэж ойлгож байгаа.

Яг орон нутаг дээр, ялангуяа энэ хилийн бүсийн ард иргэдтэй уулзаад явахаар энэ хоршооныхоо мөнгөөр тоног төхөөрөмж авах туйлын бололцоо байна.

Гаалийн албан татвар эд нар гээд янз янзын татварууд нь бидэнд нөгөө нэгж техникийнх нь үнэ өсөж орж ирэх ийм зүйлүүд байна.

Тэгээд би Хоршооны хуулийг өнгөрсөн хавар чуулганы хуралдаан дээр орж ирэхэд энэ ямар жийп оруулаад ирэх гэж байгаа биш, тансаг зэрэглэлийн юм оруулж ирэх гэж байгаа биш, энэ трактор комбайн, энэ хамаг ч, эд нарынх нь гаалийн албан татварыг бүр тэглээд энэ дагалдах хууль дээрээ оруулаад ирэх бололцоо байгаа юу гэж ингэж асууж байсан.

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд хариулья.

Ж.Энхбаяр: Энэ хоршоо маань өөрөө хуультай. Хуулиараа хийх ажлыг нь төлөвлөөд бүр заачихсан.

Энэ онд 500 тэрбум. Ирэх онд 500 тэрбум гэж л суусан байгаа.

Нэмэгдүүлэх асуудлыг Ерөнхий сайд, Сангийн сайд асуудал тавьчихсан.

Ер нь Их Хурлын дарга бас энэ дээр дэмжиж байгаа. Ер нь энэ эрчийг нь алдуулахгүй жоохон хоршооллынхоо ажлыг үргэлжлүүлье гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгээд аяндаа энэ чинь Монголбанкнаас мөнгөний бодлоготой холбоотойгоор эх үүсвэрүүдийг нь хаанаас гаргах вэ, яаж бий болгох вэ гэдэг асуудал байгаа юм байна лээ. Тэгээд тэр нь шийдэгдвэл ер нь нэмчихье гэсэн маягтай байгаа.

Тэр татвартай холбоотойгоор нэг жижиг техникүүд байгаа. Хөдөө аж ахуйн. Ногооны, тэжээлийн, тариалалтын.

Энэ техникүүдийг худалдан авалтынх нь үнийн дүнгийн 50 хувийг нь буцаан олгож байгаа.

Тэгэхээр энэ талын мэдээлэл улсын хэмжээнд жоохон дутуу байна лээ. Ялангуяа газар тариалангийнхан, ногоочидтой их сайн оччихсон боловч хөдөө орон нутагт мэдээлэл дутуу байгаа.

Хэрвээ ийм зориулалтын жижиг техник авбал үнийн дүнгийн 50 хувийг нь буцаан олгож байгаа.

Тэгэхээр гааль дээрээ татвараа төлөөд, НӨАТ төлөөд, баримт квитанцаа бүрдүүлээд хандахад 50 хувь нь буцаан олголт хийгдэж байгаа.

Б.Бейсен: Ц.Идэрбат гишүүнд тодруулья.

Ц.Идэрбат: Тийм ээ. Тэрийг иргэд мэдэж байгаа. Иргэдийн хүсээд

байгаа юм юу вэ гэхээр өөрсдөө явж худалдан авалтаа, өөрсдийнхөө санхүү мөнгөтэй уялдсан тийм худалдан авалтыг хийх гээд байгаа байхгүй юу.

Таны хэлж байгаа зүйл бол энд байгаа компаниас худалдаж авсан тохиолдолд тэр саяын хөнгөлөлтийг чинь эдлэх гээд байгаа юм.

Тэгэхээр иргэд тэр “Али Баба”, хаашаа байдаг юм, тийшээ ороод урд ямар үнэтэй миний сонирхоод байгаа жижиг оврын тармуур хэд байгаа вэ гэдгийг мэдээд байгаа байхгүй юу.

Тэгвэл нэгэнт л хөнгөлөх л юм бол заавал тэгж баахан шат дамжлага болгож, 100 хувь төлж байж, дараа нь хөнгөлөлтөө авна энэ тэр гэдэг энэ механизмаа жоохон хөнгөлөөд энэ механизмаа жоохон хөнгөлөөд өөрсдөө өөрсдөө оруулаад ирэхэд гаалийн татваргүй орж ирдэг болчихвол энэ хоршооноос гарч байгаа мөнгө эргээд өөрөө жинхэнэ хэрэгцээгээ хангах юм шүү.

Заавал хоёр, гуравхан компаниар дамжуулсан. Тэрийг 100 хувь төлж авч байж дараа нь хөнгөлөлт эдэлнэ гээд ийм хүнд суртлын механизмыг заавал байлгаж яах гээд байгаа юм.

Гаалиас хөнгөлж, татвараас хөнгөлж болж л байгаа юм бол тэр гааль дээр нь, хил дээр нь хөнгөлөөд л малчид өөрсдөө гараад л аваг л даа. Одоо гадаад паспортгүй хүн байхгүй болчихсон шүү дээ. Үүнийг л би хэлээд байгаа юм.

Тэгэхээр энэ бол тэр 50 хувь хөнгөлдөг эд нар гэдгийг малчид мэдэж байгаа. Их ярьсан. Сонгуулиар бүр ч их мэдээлэлтэй болсон байх.

Зөрүүлээд өөдөөс заавал тийшээ биш бид энэ Бичигтийн боомтоор гараад, Баянхошууны боомтоор гараад цаад талаас нь хямдханыг аваад ороод ирмээр байна шүү дээ л гэдэг юм яриад байгаа байхгүй юу. Ингэх юм бол гаргаж байгаа хоршооны энэ хөрөнгө мөнгө чинь илүү үр дүнтэй болох юм.

Би тэр хэдэн компанийн нэр хэлээд яах вэ. Тэр компаниудаар дамжаад явж байгааг ойлгож байгаа.

Тэгэхээр үүнийг л жоохон яагаад өгөөч л гэж миний хувьд хэлэх нэг санаа байгаа юм.

Дараагийн асуудал цаг үеийн холбогдолтой асуудал. Хэдүүлээ энэ өвөлжилтийн нөхцөл байдалтай холбоотой асуудлыг яг Хөдөө аж ахуйн яамнаас дангаар нь асуугаад бас хэцүү юм байна лээ шүү.

Тийм учраас Улсын онцгой комисс, тэр Шадар сайдын ажлын алба байдаггүй. Яг энэ хүмүүстэй нь цуг сууж байгаад өвөлжилтийн нөхцөл байдал, бэлтгэл ажилтай холбоотой асуух нь зүйтэй болов уу гэж миний хувьд бодогдож байна. Баярлалаа.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулья.

Ж.Энхбаяр: Тоног төхөөрөмжийн 50 хувийн буцаан олголт үйлчлэхээс гадна хэрвээ зээл авагч, хоршоологч өөрөө хүсвэл банкууд нь гадна шилжүүлгийг нь шууд хийж өгч байгаа. Заавал тэндээс юм ав гэж заахгүй байгаа. Ийм боломж байгаа гэдэг нь байж байгаа.

Хэрвээ дотроосоо худалдан авалт хийвэл тэр нь 50 хувь нь олгогдож байгаа.

Мөн өөрөө гадагшаа төлбөр хийгээд өөрөө гаднаас шууд худалдан авалт хийнэ гэвэл тэр нь бас байгаа.

Тэгсэн нөхцөлд 50 хувийн буцаан олголтын асуудлаа тэр гааль дээрээ татвар хураамжаа төлсөн баримтаар нь асуудал шийдэгдэж байгаа.

Сангийн яам болохоор энэ татварын суурь системийг эвдэхгүй ээ. Ингэж янз янзын шүүр шанага шиг хөнгөлөлтүүдийг өгөхгүй.

Малчин ч бай, хэн ч бай бүгд энэ бүртгэлтэй байгаа. Татвараа төлөөд явдгаараа явна. Ороод ирсний дараа нь тэр бичиг цаас бүртгэл нь үзэж байгаад нэгдсэн журмаар тэр хөнгөлөлтийг, буцаан олголтуудыг олгоно уу гэсэн ийм байр сууриа хатуу бариад байгаа юм.

Б.Бейсен: Болсон уу? Ц.Идэрбат гишүүн.

Л.Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаясгалан: Байгаль орчны яамны Төрийн нарийн, Усны газрын дарга, Ус цаг уурынхан хариулаад өгвөл их сайн байна.

Говийн усны нөөц яг хэр хэмжээтэй үлдсэн бэ? Гүний ус.

Гүний усаа уурхайд хэрэглээд манай улс удаж байгаа шүү дээ. Усны төлбөр нэмэхээс өөр яг ямар хариуцлага байдаг юм? Нийгмийн хариуцлага нь байдаг юм уу?

Тэгэхдээ би энд байна шүү дээ аймгийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан ч юм уу, орон нутагт дотаци өгдөг тийм хариуцлагыг хэлээгүй.

Яг одоо манай гүний усыг хэрэглээд уул уурхайд хэрэглэснийхээ хариуд юу өгдөг юм.

Өнөөдөр Монголын говь ерөөсөө энэ гүний усаа уул уурхайд хэрэглүүлснийхээ үйл лайг үүрч байгаа хамгийн том жишээ байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр яг юу хийж байгаа вэ гэдгийг асууя.

Байгаль орчны яаман дээр байгуулагдсан тэр усны ажлын хэсэг.

Сая хэрвээ би буруу ойлгосон бол Өмнөговь аймгийн усан хангамжийг нэмэгдүүлэх талаар байгуулагдсан гэнэ үү. Би буруу сонссон байх. Тийм ээ. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр Улсын Их Хуралд ирэхээс өмнө байгуулагдсан ажлын хэсэг. Энд ямар нэгэн тодорхой санал өгсөн үү? Ийшээ оролцоотой байгаа юу?

Соён гэгээрүүлэх ажил хэр хийж байгаа вэ? “Хэрлэн-Тооно”-ыг хэрэгжүүлснээр Хэнтийнхэнд ямар ашигтай байх юм. “Орхон-Онги”-ийг хэрэгжүүлснээр Өвөрхангайнханд ямар ашигтай байх юм гэдгийг Та бүхэн судалж гаргаж ирсэн үү.

Тэгэхгүй бол одоо 16 жилийн өмнөх шигээ Хэрлэн голоо хэрчлүүлэхгүй гээд нэг нөхөр үсрээд гараад ирэх юм бол бүхэл бүтэн 3 их наяд төгрөг төлөвлөчихсөн байгаа Засгийн газрын тэргүүлэх чиглэл болсон усны ажил зогсох гээд байгаа юм.

Тэгэхээр яг соён гэгээрүүлэх ажил юу хийж байгаа вэ?

Говийн бүсэд сүүлийн жилүүдэд унадаг хур тунадас багассан. Тэгтэл гүний усыг хур тунадас, одоо тэр хөрсний уснаас нэмэгдүүлнэ гэж сая ярилаа шүү дээ. Энэ дээр Ус цаг уурын газраас юм уу, эсвэл тэр эрдэм шинжилгээний газраас надаа хариулт өгөөч.

Говьд ордог хур тунадасны хэмжээ сүүлийн жилүүдэд багассан.

Тийм учраас гүний усанд ямар ч тийм сэлгэх боломжгүй болсон гэж ярьж байсан.

Энэ дээр хариулт аваад тэгээд тодруулга явъя.

Б.Бейсен: Байгаль орчны юм хариулъя. 3 номер. Холбогдох бусад мэргэжилтнүүд байвал хариулаарай.

Э.Баттулга: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Миний араас манай Усны агентлагийн дарга З.Батбаяр нэмээд хариулаарай.

Өмнөговийн ус биш ээ. Энэ “**ӨМНИЙН ГОВИЙН**” гээд яг бүс нутгаар нь хэлж байгаа. “Өмнийн говийн” бүс нутгийн усны нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах ажлын хэсэг маань ажиллаад явж байгаа.

Энэ дээр манай сайд, сайдын зөвлөх нэлээн ач холбогдол өгөөд явж байгаа.

Олон нийтэд хандсан мэдээлэл, сурталчилгааны ажлууд яг таны хэлсэн

шиг байхгүй байгаа. Би байгаа гэж хэлж чадахгүй байна.

Гадаргын усны хур тунадасны хэмжээ говийн бүс нутагт яах вэ олон жилийн дунджаар хур тунадасны хэмжээ өсөө ч үгүй, буураа ч үгүй. Ямар өөрчлөлт гарч байна вэ гэхээр ер нь энэ уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөр нэг өдөрт унадаг хур тунадасны хэмжээ л их өөрчлөлт гарч байгаа.

Нэг бол маш их ороод, нэг бол огт орохгүй. Олон хоног. Хуучин жишээлбэл өдөрт ордог хур тунадасны хэмжээ харьцангуй тогтмол, олон жилийн дундажтай ойролцоо байдаг байсан бол сүүлийн үеийнх нь прогнозууд ерөөсөө төсөөлөхийн аргагүйгээр давтамж нь дээшээ доошоо болж байгаа асуудал байгаа юм.

Хур тунадасны хэмжээ угаасаа Монгол орны дундаж 225 миллиметр байгаа. Жилийнх хамгийн их нь Хэнтийн Дадал 550 орчим байгаа байх. Тэгээд л Алтайн өвөр говь, Их нууруудын хотгороор бараг зарим жилүүдэд хур тунадас унахгүй. Жилдээ 50 миллиметрийн хур тунадастай л байгаа.

Тэгээд ийм үед яг таны хэлж байгаа шиг бид газрын доорх усыг зориудаар баяжуулах тэр **MAR** MANAGED AQUIFER RECHARGE гэдэг төсөл зөвхөн үерийн ус, уруйн ус, тэгээд хаврын шар усны үерийн усыг хуримтлуулах зорилготой төсөл байгаа юм.

Урьдчилсан төсөл нь туршилтаар амжилттай болсон учраас бусад бүс нутагтаа бид хэрэгжүүлнэ гэж байгаа.

Таны хэлдэг усны нөөцийн талаарх олон нийт, нийгмийн нөлөөллийн ажлуудыг бид Байгаль орчинд нөлөөлөх

байдлын үнэлгээний тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийднэ гэж харж байгаа.

Хуулийн төслийг үзэл баримтлалыг нь батлуулчихсан байсан. Сая Засгийн газрын бүтэц шинэчлэгдсэнтэй холбоотойгоор дахиж батлуул гээд буцаагдчихсан.

Ер нь хамгийн түрүүнд оруулах манай хуулийн төслүүдийн нэг байгаа.

Усны талаарх хариуцлагын тухайд гэвэл мөрийн хөтөлбөрийн төслийн 2.4.3.7-д байгаа бохирдуулагч үйлдвэр, үйлчилгээний салбарын хаягдал усны хяналтыг сайжруулна гэж.

Одоо ингээд 8 дугаар сарын 22-нд бид байгаль орчны салбарын стандартын зөвлөлөөр хаягдал усны стандартыг шинэчилж байгаа.

Энэ шинэчлэлийн ажлыг Мянганы сорилтын сангийн цэвэр усны төслийн судалгааны ажил дээр үндэслэж хийж байгаа.

Б.Бейсен: Усны газрын дарга нэмж яриулъя. З.Батбаяр. 1 номер.

З.Батбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Бүрэн эрхийн хугацаа эхэлсэнд баяр хүргэж, амжилт хүсье.

Тэгээд гишүүний асуултад говийн усны нөөц хэр үлдсэн бэ гэж.

Тэгэхээр түрүүн Б.Уянга гишүүний асуусантай адилхан юм хэлэх гээд байгаа юм.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн 87 хувьд нь геологийн эрэл хайгуул хийгээд үзчихсэн, мэдчихсэн байна.

Гэтэл харамсалтай нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн дөнгөж 17 хувьд нь усны нөөцийн судалгаа хийсэн буюу 200 мянганы зураг хийчихсэн байдалтай л байна.

Тэгэхээр яг бодит амьдрал дээр бид ямар нэгэн байдлаар гоё сайхан ярих биш бодит юмаа л хэлэх ёстой учраас.

Гишүүний асуултад говийн усны нөөц хэр вэ гэдэг дээр хэд үлдсэн бэ биш, хэд вэ гэдэг асуултад хүртэл хариулж чадахгүй сууж байна гэж.

2024 оны төсөвт усны газар дээр 600 сая төгрөгөөр Говь-Алтай аймгийн Төөрөг сумын төвийн усан хангамжийн асуудлыг хийж байна. 200 сая төгрөгөөр маш бага хэмжээтэй 200000-ын зураг хийгээд сууж байна.

Өөрөөр хэлбэл энэ жилдээ зарцуулж байгаа 600, 800 сая төгрөг маань хаанаа ч хүрэхгүй байгаа учраас бид маш яаралтай томоохон төслүүдээсээ өмнө түрүүлээд газрын доорх усны эрэл хайгуулаа бүрэн дүүрэн хийж дуусгая гэж.

Түрүүн Б.Уянга гишүүний асуусан асуултын хариулт бас энэ байгаа. Бидний барьж байгаа бодлого энэ.

Ерөнхийдөө Монгол Улсын нутаг дэвсгэрийн гуравны нэг орчим буюу говийн бүс нутагтаа маш яаралтай газрын доорх усны эрэл хайгуулыг хийе гэж.

Үүнтэй холбогдуулаад гишүүний асуусан хур тунадасны асуудал дээр хугацаа нь холдож байгаа учраас багасаад байгаа юм шиг харагдаж байгаа.

Гэтэл нэгж хугацаанд орох хур тунадасны хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалаад бидний урьд нь бороотойгоо харьцдаг байсан арга барилаа өөрчлөх зайлшгүй шаардлага гарч ирж байгаа юм.

Тэр нь нэгдүгээрт ил хуримтлуулах. Энэ маань нөгөө түрүүн хуригдаж байсан хөв цөөрмийн асуудал.

Одоогийн байдлаар 12 метрийн нарийвчлалтайгаар тогтоосон байдлаар Монгол Улсад 54 мянган цэг дээр их бага том жижиг нийлсэн хөв цөөрөм байгуулах боломж байна.

Манай сав газрын захиргаад яг энэ мөчид ажиллаад сав газрын захиргаа болгон 10-ыг буюу ойролцоогоор 21-ийг үржүүлэхээр.../минут дуусав/

Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулья.

Л.Мөнхбаясгалан: Тэр усны хайгуул чинь танай дээр хийгддэггүй байх аа? Үндэсний геологийн агентлаг дээр усны хайгуул харьяалагдаж байна уу? Танай дээр байгаа юу? Гадаргын ус нь? Байхгүй юу.

Тэгэхээр ийм байна. Одоо дагалдах хууль түрүүн тэр орж ирээд дахиад буцчихлаа гээд тэр Төрийн нарийн бичгийн даргын хэлж байгаа хуулиа оруулж ирж болох байхгүй юу? Энэ маш чухал хууль шүү дээ.

Тэгээд соён гэгээрүүлэх ажил хийхгүйгээр одоо энэ том төслүүд чинь ерөөсөө явахгүй байхгүй юу. Үүнийг маш чухал анхаармаар байх юм.

Тэгээд усны төлбөр одоо яг хэд байгаа вэ? Уул уурхай дээр. Гүний уул уурхай дээр гүний ус ашиглаж байгаа уул

уурхайн компаниуд дээр усны төлбөр хэд байгаа вэ? Цаашид нэмэх боломж байгаа юу?

Соён гэгээрүүлэх ажил гэдгийг Та нар зүгээр нэг хэвлэл мэдээллийн албатай ч юм уу, хэдэн сайттай хөдөө аж ахуй холбогдох ажил гэж битгий ойлгоорой.

Энэ үндэсний хэмжээний том төсөл шүү. 25 жил гацсан байсан төслийг одоо явуулж байгаа.

Их Хурлын гишүүдтэйгээ хамтарч ажиллаарай. Би Байгаль орчны яамныхныг, ялангуяа усны газрынхныг хамгийн түрүүнд гүйж ирэх байх гэж бодсон чинь та нар таг дуугүй байсан юм шүү.

Маш олон жил гацсан асуудлыг өнөөдөр бид нар төрийн хэмжээнд гаргаж тавьсан.

Тэгэхээр хамтарч ажиллах уялдаа холбоо дутуу байгаа шүү.

Тэр хариулт авчихъя. Усны төлбөр.

Б.Бейсен: З.Батбаяр дарга хариулья.

Л.Мөнхбаясгалан: Тэр дагалдах хууль.

З.Батбаяр: Маш их баярлалаа. Тэгээд мэдээж хамтарч ажиллалгүй яах вэ.

Монгол Улсад 29 сав газраар ангилсан байгаа. Тэгээд 29 сав газар болгон дээр өөр өөр үнийн дүнтэй байгаа. Гадаргын ус, газрын доорх ус.

Жишээ хэлье. Туул голын сав газар дээр газрын доорх ус нь метр куб нь 9400 төгрөг байгаа. Гадаргын ус нь 4000 байгаа санагдаж байна.

Галав-Өөш-Долоодын говь буюу Оюу Толгой багтаж байгаа газар дээр 1 метр куб ус нь 4300 төгрөг байгаа.

Ингээд тооцох юм бол тухайн нутаг дэвсгэрээсээ шалтгаалаад өөр өөр байж байгаа. Үүнийг нь бид нар “усны экологи, эдийн засгийн үнэлгээ” гэдэг зүйл дээр явж байгаа.

Тийм учраас усны үнийг өөрчлөх тухай асуудал дээр саяын таны хэлсэн хамтын ажиллагааны үр дүнд бид яаж хийж болох вэ гэхээр тухайн бүс нутгийн буюу сав газрынх нь хэмжээнд экологи, эдийн засгийн үнэлгээг нь өөрчлөх замаар хийчих боломжтой юм.

Яг одоо хэрвээ Та бүхэн маань анзаарсан бол Улаанбаатарын хөрсний ус гээд л ингээд шүүх гээд л янз бүрийн юм яриад яваад байгаагийн цаад талд нь уул уурхайн компаниуд маань хөрсний ус, шүүрсэн усны төлөө төлбөр төлөөд одоо арван хэдэн жил, хорин хэдэн жил болчихсон явдаг.

Гэтэл барилгын компаниуд нь ус шүүрүүлчхээд ямар ч төлбөр төлдөггүй байж байгаа. Үүнийг авахын төлөө явж байгаа юм.

Үүний ар талд нь түрүүн асуултад дутуу үлддэг юм. Говьд байж байгаа усны хэрэглээгээ бид нар бүрэн дүүрэн тодорхойлох шаардлагатай байна. Боломжоо ашиглах хэрэгтэй байна. Тэр Төрийн нарийн бичгийн даргын яриад байгаа газрын доорх усны зүгээр л худаг бол урьд нь ус авдаг байсан бол одоо бид нар урвуу хамааралтай худаг хийгээд

бороо ороход тэр нь тэр худгаар нь дамжаад доошоо ордог юм хийж газрын доорх усны нөөцийг нэмэгдүүлье гэж “Газрын доорх усан сан” гэж яриад байгаа маань л энэ.

Тэгэхээр үүний ар талд нь мэдээж соён гэгээрүүлэх ажлаа бүх талаараа хамтарч хийе. Говийн усан хангамж гэхээс илүү Монгол Улсын хэмжээнд усны нөөцийн жигд хуваарилалтыг бий болгохын тулд боломжит бүх менежментийг хэрэгжүүлье гэсэн ийм санаатай байгаа.

Тэгээд Их Хурлын гишүүд маань ийм өндөр байдалтайгаар дэмжиж байгаад маш их баяртай байна. Цаашдаа тэгээд бүх асуудлуудаа танилцуулж ажиллана.

Б.Бейсен: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Засгийн газрын мөрийн хөтөлбөр ирэх 4 жилд Засгийн газраас төрөөс баримтлах чухал бичиг баримт төдийгүй улс орны эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, бүтээмжтэй байлгах, улс орны хөгжлийг авч явах, хөтлөх, иргэдийн амьдралыг, амьдралын чанарыг бодитойгоор өөрчлөх ийм ирэх 4 жилийн чухал бичиг баримт гээд бид хэлэлцээд сууж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар, тэр дундаа газар тариалан, мал аж ахуйн салбар сүүлийн жилүүдэд яагаад ингэж улс орны хэмжээнд тэгтлээ доройтолд орсон бэ гэдэг асуудал, доошоо яваад байгаа юм бэ гэдэг үзүүлэлтүүд нь асуудал бас энд хөндөх ёстой асуудал болоод байгаа.

Өнөөдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар томилогдсон Ж.Энхбаяр гишүүнд итгэлтэй байна.

Түрүүн С.Ганбаатар гишүүн бас хэлсэн. Энэ салбарыг нэг айлын дайтай айл болгож өөд нь татаж, салбар шиг салбар болгож энэ ирэх 4 жилд бодитой чанарын өөрчлөлт түвшинд нь гаргаж ажиллах байх гэж нэгдүгээрт найдаж байна.

Тэгээд миний хэдэн асуултууд С.Ганбаатар гишүүнтэй, мөн Ж.Батжаргал гишүүнтэй давхардсан тул ганц нэг асуулт асууя гэж бодож байна.

Ер нь Ж.Энхбаяр сайд мал аж ахуй, газар тариалан, хүнс, хөдөө аж ахуйн салбар дотроо мал аж ахуй, газар тариалангийн салбарт бодитой өөрчлөлт, дорвитой өөрчлөлт хийх таны яг нэг хувийн бодлыг нэг сончихъё.

Үзүүлэлтүүд доошоо орсныг ойлгож байгаа. Тийм ээ. Энэ нөгөө зудны асуудалтай холбоотой 8.1 сая толгой мал хорогдсонтой холбоотойгоор үзүүлэлтүүд бусад салбаруудаасаа хоцорч бусдын ард орсон байгаа гэдгийг ойлгож байгаа.

Танд нэг тийм яг сайд хүний хувьд энэ салбарыг өөд нь татаад аваад явах хувийн өөрийн яг нэг бодлоо нэг хэлээд өгөөч.

Дараа нь энэ хүнсний аюулгүй байдал өнөөдөр үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүрч улаан гэрэл асааж байгаа. Энэ хүнсний аюулгүй байдал, хангамж, хүртээмжийн асуудал, махны нөөцийн асуудал.

Энд одоо тусгай мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсан, алга болсноос хойших үргэлжилж байгаа энэ стандарт, чанарын асуудал үнэхээр иргэдийн асуудалд маш хүнд байна.

Өнөөдөр эрүүл хүнс авч хэрэглэх энэ иргэдийн амь насны асуудал, эрүүл мэндийн асуудал бүр алга болчихлоо шүү.

Тэгэхээр хүнсний аюулгүй байдал дээр тусгайлан лаборатори, хяналт шинжилгээ гэхээсээ илүү, судалгаа гэж ярихаасаа илүүтэй одоо бид нар бүр тийм лаборатори байгуулах тийм чадамж асуудал орж ирэх үү?

Дараагийн асуудал нь, Байгаль орчны сайд өнөөдөр алга байх шиг байна.../минут дуусав/

Б.Бейсен: Хариулт. Хүнс, хөдөө аж ахуйн яам уу? Байгаль орчны яам. 4.

Ж.Энхбаяр: Дэмжиж байгаад баярлалаа.

Монгол Улс мал аж ахуйн орон, хөдөө аж ахуйн орон гэж хэдийгээр ярьдаг боловч яг өнөөдөр манай хөдөө аж ахуйн салбар маань туйлын хүнд байгаа.

Мал аж ахуй нь ч тэр, газар тариалан нь ч тэр, малын бэлчээр нь ч тэр аж ахуйн үр өгөөжтэй үйлдвэрлэлтэйгээ холбосон, нэмүү өртөг бий болгосон экспортод гаргах ийм чадавх үндсэндээ байхгүй.

Үндэснийхээ хэмжээнд бид хэрэглэгч. Хэт уул уурхайдаа найдаж, хэт уул уурхай дагаж байж энэ бүтээх чанараа ер нь их сулруулсан.

Бүгдийг худалдаан дээр асуудлыг шийдэж ирсэн. Зөвхөн хүнс гэхэд л хүнсний импорт тэрбум доллар хүрч байгаа.

Тэгэхээр үүнийг өөрчлөхийн тулд, үйлдвэрлэлээ босгохын тулд “Цагаан алт” хөтөлбөр, малчдаа идэвхжүүлэхийн тулд энэ “Шинэ хоршоо” хөтөлбөр, энэ хүнсний аюулгүй байдлаа хангахын тулд энэ “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнүүд санаачлаад хийгдээд байгаа учир нь тэр.

Нэг зүйлийг их сайн хатуу барина. Энэ салбар дахь төрийн оролцоог дээд зэргээр л хязгаарлах ёстой.

Хэтэрхий яам өөрөө тендерт орооцолддог, тоног төхөөрөмж нийлүүлдэг, үр бордоо нийлүүлдэг, энэ бизнесийн үйл ажиллагаанд хутгалдаж байгаа байдлаас эрс татгалзана.

Зөвхөн арилжааны банк буюу бизнесийн эрсдэлээ банкнууд дагаад, тэнд судлагдсан салбарын зээлүүдэд дэмжих тэр зээл, хүүгийн бодлогыг их түлхүү ахиухан шиг ашиглая.

Малчдыг ч тэр, тариаланчдыг ч тэр, үйлдвэрлэгчдийг тэр хүрэлцээтэй зээлийн бодлогоор л дэмжээд байя.

Тэр зээл нь хөрөнгө оруулалт хийх бололцоотой, урт хугацааны эргэлтийн хөрөнгө хангах бололцоотой хямд эх үүсвэрээр л хангаад байх нь хамгийн зөв бодлого байна гэж ойлгож байна.

Нөгөө талаар салбарын бүтцийг боловсронгуй болгох, зөв болгох тал дээр гишүүд маань санал санаачилга гаргаж өгөөч ээ.

Ахиад хэлье. Манай харьяанд байсан 6 хүрээлэн,

- мал аж ахуйн чиглэлийн 2,
- ургамлын чиглэлийн 2,
- хүнсний аюулгүй байдлын 1,
- хөнгөн үйлдвэрийн 1 хүрээлэн

нийт 6 хүрээлэн өөр салбар луу шилжчихсэн.

Ингээд салбар шийдвэр гаргахад, Байнгын хороо бодлого гаргахад хүртэл энд хажууд энэ хүрээлэнгүүдийн, тэр эрдэмтдийн дуу хоолой ерөөсөө байхгүй болчихоод цэвэр улс төрчдийн сэтгэл хөдлөлийн асуудал руугаа л ороод байгаа ийм байдал байна.

Салбар өөрөө их дур зоргын болж хувирч байгаа.

Тариаланчид шинжлэх ухааны үндэслэлгүйгээр тариалалтууд, янз янзын үр, сорт, хөрс, хөрсний технологиуд орж ирж байна.

Мал аж ахуй дээр бас дур зоргын ийм үржил селекц ажлууд явж эхэлж байна. Энэ болгон чинь их нарийн шүү дээ. Үйлдвэртэйгээ холбодог.

Сүү гэхэд л ямар үүлдрийн үнээ байх нь тодорхой байдаг. Зөвхөн тэрийгээ үржүүлдэг, тэр селекцийг нь хийдэг.

Мах гэхэд ямар үүлдрийн үхэр үржих вэ. Тэр нь бодлого нь тодорхой байдаг.

Нэг ийм зүйл үндсэндээ алдагдаад ирэхээр л үйлдвэрлэл маань өөрөө баталгаатай, найдвартай, чанартай.../минут дуусав/

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд нэмж хариулъя гэж байна.

Ж.Энхбаяр: Тэгэхээр ахиад хэлье.

Уул уурхайн энэ үнийн өсөлт явж байгаа нь экспорт сайжирч байгаа энэ таатай үеийг ашиглаад л энэ

- *хөдөө аж ахуйн салбараа л хурдан босгомоор байна.*
- *аюулгүй нөөцөө ч бүрдүүлмээр байна,*
- *хөрсөө хамгаалмаар байна,*
- *үр сортынхоо аж ахуйг сайжруулмаар байна,*
- *малынхаа үржил селекцийг сайжруулмаар байна,*
- *лабораториудаа бэхжүүлмээр байна,*
- *биокомбинатаа нэг шинэчлээд босгоод авмаар байна.*

Энэ дээрээ тулгуурлаж байгаад хөнгөн хүнсний үйлдвэрүүдээ нэг өрсөлдөх чадвартай болгоод авмаар байна.

Ингэхийн тулд иж бүрэн цогц, шинжлэх ухаанч бодлого, үйлдвэрлэл, шинжлэх ухаан холбосон ийм л. Тэгээд улс төрийн дэмжлэг.

Монгол Улсын Ерөнхийлөгч Төрийн тэргүүн маш сайн дэмжлэг үзүүлж байгаа.

Одоо Их Хурлын, манай мэргэжлийн Байнгын хорооны дэмжлэг ингээд нэг гарт бүгдээрээ ороод хамтраад ажиллавал бодитой үр дүн гарна.

Ер нь байдал их ужгирсан байгаа шүү. Ялангуяа уламжлалт мал аж ахуй эрхэлж байгаа малчдын маань амьдрал их

эмзэг. Нэг хүчтэй байгаль цаг уурын эрсдэлийг дааж чадахгүй.

Улс орныг хамарсан нэг том зуд болоход л ер нь тэгээд л 100, 100 мянгаараа л шууд амьжиргаагаа алдаад л ядуурал түвшинд буюгаад л Улаанбаатар хотод ирэхээс аргагүй ийм л бодит байдал.

Сая Монголын хамгийн их өвс, хадлан авдаг зүүн бүс Сүхбаатар аймаг гэхэд л нийт мал сүргийнхээ бараг 60 хувийг алдлаа шүү дээ. Олон мянган малчин малгүй болцгоосон.

Тэгэхээр хамгийн өвс тэжээлтэй газраа ийм эрсдэлтэй байна. Бусад газар гэхэд бас л энэнээс илүү хүнд байгаа шүү дээ. Тэгээд нийтийг хамарсан эрсдэл гарвал ер нь тун амаргүй байгаа.

Тэгэхээр яаралтай мал аж ахуйгаа эрчимжүүлэх, хорших, тэр эрсдэлийг даван туулах чадавхыг бий болгохын тулд тэр тэжээл, тарималыг тарьдаг болох, тэр хүсээд байгаа нэмэлт газрыг яаралтай тэр малчдад олгох, тариаланчдад нэмж олгох.

Энэ гахай, тахиа, сүүний аж ахуйг хөгжүүлэхийн тулд заавал тэжээлийн ургамлын ургамалын эрс нэмэгдүүлж байж хөгжих гээд байдаг.

Тэгээд тэр болгон чинь газрын бодлого дээр гацаад байгаа юм.

Тэгээд энэ оруулсан. 200 мянган га талбайг нэмж эргэлтэд оруулья.

Мах, сүүний чиглэлээр.../минут дуусав/

Б.Бейсен: Тодруулах уу? П.Батчимэг гишүүн тодруулья.

П.Батчимэг: Тодруулга байхгүй. Зүгээр Байгаль орчны яамнаас асуулт асууя даа.

Хөрсний бохирдол, агаарын бохирдол бидний мөнхийн сэдэв ярьж байгаа асуудал л байгаа.

Яасан бэ яагаад инээгээд байгаа юм бэ? Асуулт асууж болох уу? Хөрсний бохирдлын асуудал.

Одоо бид нар энэ мөрийн хөтөлбөрт энэ сая оруулж ирсэн материал дээр 360 газраас сорьц авахад 88 хувийн нян мөөгөнцөр үүссэн гэсэн ийм мэдээ байна.

Тэгэхээр энэ хөрсний бохирдол намар хаврын цагт маш их босдог. Энэ бидний үр хүүхдүүд, ирээдүй болсон хүүхдүүдийн эрүүл мэндийн асуудал хамгийн түрүүнд яригдах ёстой.

Ийм бохир нөхцөлд, ийм хөрсний бохирдолтой орчинд амьдарч байгаа.

Үүнийгээ юу гэж хэлдэг вэ, тайлбарладаг вэ гэхээр муу усны нүх, задгай жорлон, нөгөө л ярьдаг уламжлалт аргаараа ярьдаг, хаадаг, ам хаадаг. Тийм ээ.

Тэгэхээр хөрсний бохирдол. Энэ дээрээс харахаар дандаа нэг ийм судалгаа авсан, ингэж хяналт тавина, үнэлгээ хийнэ энэ тэр гэсэн ийм нэг сонин хий агаарт ийм юм яриад байна.

Энэ ярьж ирсэн уламжлалт аргаасаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ямар бодитой, дорвитой ажлыг энэ 4 жилд хийх юм бэ?

Хөрсний бохирдлоо энэ жил хэдэн хувиар бууруулж чадах юм, Энэ талаар асуултад хариулж өгөөч.

Б.Бейсен: 3 номер хариулъя.

Э.Баттулга: П.Батчимэг гишүүний асуултад хариулъя.

Хөрсний бохирдолтой холбоотой зөвхөн хөрс гэхгүйгээр энэ орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ гээд энэ 3.1.3.3 дээр заачихсан байгаа. Зорилт орчихсон байгаа.

Гэхдээ гишүүний асуулт бол илүү нөгөө бодлогын шилжилтийг яаж хийх юм бэ гэдэг рүү чиглэж байна гэж ойлголоо.

Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам ер нь өнгөрсөн хугацаанд явж ирсэн арга барилаас илүүтэйгээр ер нь хаягдлыг баялаг болгодог, дахин сэргээж эргэлтэд оруулдаг байх арга замуудыг хэрэгжүүлье гэж байгаа юм.

Хөрсний бохирдуулагчийн эх үүсвэрээс нь харах юм бол их төлөв ахуйн хог хаягдал, тэгээд юу эзэлдэг л дээ. Үнсний хаягдал ч гэдэг юм уу. Одоо иймэрхүү зүйлүүд эзэлдэг. Тэгээд бохирдуулагч эх үүсвэрээс нь хамаараад хэн хариуцаад цаашаа явах вэ гэдэг нь хамаардаг учраас би яг яамныхаа хариуцсан чиглэлд ярья.

Жишээлбэл, үнстэй холбоотой асуудал дээр бид нар энэ цахилгаан станцуудаас гарч байгаа үнсэн сангийн хаягдлыг уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн эвдэрсэн газруудын нөхөн сэргээлтэд дүүргэгч болгож ашиглах нь зүйтэй гэдэг ийм нэг чиглэл байгаа.

Ганцхан жишээ хэлж байгаа шүү дээ. Тийм ээ.

Хоёр дахь нь, жишээлбэл үнсэн оролцоотой бордоо үйлдвэрлэх. Бордоогоороо ойжуулалтын ажилд дэмжлэг үзүүлэх ч гэдэг юм уу.

Жишээлбэл, Улаанбаатар хотын тулгамдсан асуудал болоод байгаа Төв цэвэрлэх байгууламжийн лагийн асуудал байгаа. Бас л нэг бохирдуулагч. Тэгвэл лагаас бид бордоо гаргах технологийг гаргаад энэ тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд бордооныхоо асуудлыг бас давхар шийдээд явах боломж байна гэж харж байгаа.

Энэ мэтчилэн ер нь бохирдуулагч эх үүсвэрүүдээ дахиж ашиглаж эдийн засгийн эргэлтэд оруулах талынх нь ажил руу илүү анхаарна. Эдийн засгийн хөшүүрэгтэй болгоно гэдэг ийм чиглэл рүү.

Та тоо асуусан. Нийслэлийн гэр хорооллын айл өрхийн 25-аас доошгүй хувийг орчны.../минут дуусав/

Б.Бейсен: У.Отгонбаяр гишүүн асуулт асууя.

У.Отгонбаяр: Миний минут яваад байгаа шүү. Эхнээс нь.

Б.Бейсен: Хариултаа гүйцээе. 3 номер.

Э.Баттулга: Ер нь бохирдолтой холбоотой асуудлууд явж явж бүгдээрээ эрх зүйн орчноосоо хамаараад байдаг.

Тийм учраас бид энэ жил Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль. Тэгээд Байгалийн ургамлын

тухай хуулиуд гэсэн энэ хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар өргөн барина.

Ойн тухай хууль, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль дахин ярьсан асуудалтай холбогдуулаад Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд бэлэн болсон байгаа.

Б.Бейсен: Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуулт асууя.

У.Отгонбаяр: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Ж.Энхбаяр сайд сая хэлж байна. Салбарын бүтэц нь ер нь буруу болчихсон байгаа гэж.

Тэгээд үүнтэй уялдуулаад би жижиг, дунд үйлдвэр, бичил бизнесийн бүтэц яг зөв явж байна уу, буруу явж байна уу?

Яагаад гэвэл жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр хөтөлбөрийн 2.1.3.12-т жижиг, дунд бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ гэж заасан байгаа.

Үнэхээрийн салбарын бүтэц тэр чигтээ гажуудалд орсон байна уу, эсвэл зөвхөн та сая бас хөдөө аж ахуйн чиглэлийг ярив уу?

Хэрвээ үнэхээрийн салбарын хэмжээнд гажуудалд орсон, буруу тийшээгээ хэлбийсэн байгаа бол энэ хөтөлбөрт тусгагдсан жишээ нь энэ жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлийн асуудал цаашдаа хэрэгжихэд бас их хүндрэл учрах байх.

Тэгээд цаашдаа энэ зээлийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ гэж заасан байна. Энэ чиглэлээр цаашдаа яам ямар бодлого, ямар ажил авч хэрэгжүүлэх вэ гэж асуух гэсэн юм. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Хөтөлбөрт мөн тусгагдсан. Хөтөлбөрийн 3.3.4.3-д малын гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатын боловсруулалт хийх дундын хоршоог сумдаар бүсчлэн байгуулна гэж заасан байгаа.

Энэ өөрөө бас тийм чухал малчид руу чиглэсэн, малчдын ахуй амьжиргааг дэмжих чиглэлд нэлээн чухал заалт гэж үзэж байгаа.

Өнгөрсөн хавар үндсэндээ нийгмийн захиалгаар “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөр улс орон даяар хэрэгжиж эхэлсэн.

Хамгийн сүүлийн авсан мэдээгээр улсын хэмжээнд 5 мянга 637 хоршоо байгуулагдсан. 58 мянга орчим хоршооны гишүүн шинээр элссэн.

Тэгээд үр дүнг нь харахад 508 орчим тэрбум төгрөгийн хүсэлт ирсэн. Үүнээс 442 тэрбум орчим төгрөгийн зээл олгогдохоор шийдвэр гарсан гэж хамгийн сүүлийн мэдээ надад ирсэн байна.

Энэ маань яг өнөөдрийн түвшинд одоо яг юу нь болж байгаа юм бэ, болохгүй байгаа юм бэ, алдаа оноо юу байгаа юм бэ, засаж залруулах юм юу байгаа юм бэ гэдэг чиглэлээр Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Монголбанкт хамтраад дунд хугацааны мониторинг хийж болох уу?

Одоо нэг асуулт гэх үү, санал гэх үү. Алдаа оноотой зүйл байгаа бол үүнийгээ засаж залруулъя.

Яагаад гэхээр энэ жилийн улсын төсвийн тодотгол дээр.../минут дуусав/

Б.Бейсен: У.Отгонбаяр гишүүнд нэмж микрофон.

У.Отгонбаяр: Энэ жил яагаад гэхээр тодотгол дээр 25 орчим тэрбум төгрөг тавигдаж байгаа. Ирэх жилийнх дээр мөн ижил тооны.

Тийм учраас дундын мониторинг хийх тийм нэг ажлын хэсэг байгуулаад алдаа оноогоо одоо нэг их хол оччихоос нь өмнө бас засаж залруулах юм байвал засаж залруулаад цаашаа явбал зүгээр болов уу гэж бодож байна.

Тэгээд үүнийг одоо асуулт гэх юм уу, санал гэх юм уу. Та бүгд маань бас энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч. Баярлалаа.

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Ер нь эрх зүйн орчин нэлээн хоцрогдсон.

Энэ салбарт мөрдөгдөж байгаа арваад хуулиуд дээр ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Ер нь хөдөө аж ахуйн салбарын багц хууль гэж Байнгын хороондоо оруулж ирж танилцуулна.

Ингээд энэ 4 жилд ер нь ойрын 2 жилд нь багтаж хөдөө аж ахуйн салбарын багц хуулийг иж бүрэн шинэчлэх, дагалдах дүрэм, журмыг энэ XXI зууных нь тэр аж ахуй эрхлэх ухаан, тэр үзэл санаа, байгаль орчинд ээлтэй байх, тэр

органик чиг баримжаатай тэр зах зээл рүү хөгжих тэр тал руу нь нэлээн үзэл санааг нь шингээгээд хуулийн өөрчлөлтийг хийе.

Ингээд деталь ярихаар их олон зүйл ярих гээд байна. У.Отгонбаяр гишүүнд мэдээллийг сайн өгье.

Ер нь жижиг, дунд үйлдвэрийн сан гээд 2009 оноос анх үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Энэ жилийн байдлаар нийт 1.1 их наяд төгрөгийн зээлийг гадаадын зээл тусламж, Засгийн газрын бонд, Хөгжлийн банкны эх үүсвэрээс олгосон байна.

Өнөөдрийн байдлаар нийт энэ татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг зээл, хүүгийн хамт бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын хамгийн сайн хэрэгжүүлсэн ийм төсөл үйл ажиллагаа болсон. Ямар нэгэн өр шир байхгүй. Одоо өөрийн үлдэгдэл 200 орчим тэрбум төгрөгийн эргэлтийн сантайгаар энэ Жижиг, дунд үйлдвэрийн газар.

Дээд хэмжээ нь нэг аж ахуйн нэгжид 300 сая төгрөг хүртэлх зээлийг судалж арилжааны банктай хамтран олгож байгаа ийм л жижиг, дунд үйлдвэрийг дэмжих байдал маань ийм байдалтай байна.

Б.Бейсен: М.Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Баярлалаа. Би ерөнхийдөө зарим гишүүдийн асуусан асуулт дээр дахиад нэг тодруулаад асуух асуулт байгаад байна.

Нэг нь болохоор Монгол Улсын Засгийн газрын 107 дугаар тогтоол гэж

байгаа. Тийм ээ. Энэ нь болохоор нөгөө гаалийн албан татварыг хөнгөлөх тухай 2022 оны ийм зүйл, заалтуудтай. Тэгээд энэ тогтоолыг 2027 оны 01 сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөх зориулалттай.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулууны үед гаргаж байсан тогтоол.

Тэгэхээр энэ тогтоолыг Засгийн газрын шийдвэрээр тодорхой хэмжээний өөрчлөлтүүд оруулж болно гэж үзэж байгаа.

Тэгэхээр импортын барааны гаалийн албан татвараас хөнгөлөх, хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэдэг шинэ тоног төхөөрөмжийн жагсаалт гээд нэлээн хэдэн жагсаалтууд гарсан байгаа юм байна лээ.

Бараг 276 нэр төрлийн тоног төхөөрөмжүүдийг багтаасан.

Энэ бол яах вэ “Шинэ хоршоо” гэдэг хөдөлгөөн эхлэхээс өмнөх үед гарсан, баталсан байсан.

Тэгэхээр одоо ингээд нэгэнт үндэсний том хөтөлбөрүүд эхэлж байгаа учраас “Шинэ хоршоо” хөдөлгөөнтэй холбоотой. Түрүүний Ж.Бат-Эрдэнэ гишүүний хэлсэн яг малчдад тулгамдаад байгаа, Ц.Идэртбат гишүүний бас хэлсэн малчид тоног төхөөрөмж авъя гэхээр хөнгөлж чадахгүй байгаад байна.

Тэгэхээр энэ жагсаалтдаа ялангуяа энэ “Шинэ хоршоо” хөдөлгөөнөөр олгож байгаа зээл нь өөрөө очиж байгаа хөрөнгө

оруулалтын тэр тоног төхөөрөмжийг энэ жагсаалтад нь багтааж өгч болох уу.

Тэгэх юм бол ядаж малчдад очих тэр авч байгаа тоног төхөөрөмжөө өөрөө энэ жагсаалтынхаа дагуу хөнгөлөлт чөлөөлөлтөө эдлээд явах бас боломжтой харагдаж байна. Энэ дээр Та бүхэн гаргалгаа гаргаж аль болох “Шинэ хоршоо” холбоотой авч байгаа тэр хөрөнгө оруулалт нь тодорхой байгаа учраас оруулж өгч тусална уу гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт нь, энэ үндэсний 3 том хөтөлбөрийг хэрэгжүүлэх. Ер нь энэ үндэсний 3 том хөтөлбөр өөрөө хэрэгжинэ гэдэг чинь хөдөө аж ахуйн салбар ер нь бэхжиж хөгжихийн хамгийн том суурь гэж харж байгаа.

Тэгэхээр үүнийг хэрэгжүүлээд явахад яаман дээр яг хэрэгжүүлэх ямар бүтэц байх юм бэ?

Миний сонссоноор Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар хоршооны нэг хэлтэс гэж байгуулна гэж байгаа юм.

Гэхдээ тэр нь “Шинэ хоршоо” хөдөлгөөн биш ерөнхийдөө ерөөсөө манай Монгол Улсад байгаа бүх хоршоодын нэгтгэсэн хэлтэс гэж байгаа байхгүй юу. Тэр дотор нь бүр хадгаламж зээлийн хоршоо хүртэл орчихсон.

Хэрэв ийм олон хоршоог зүгээр нэг хэлтэс аваад, тэгээд дээрээс нь бид “Шинэ хоршоо” гээд үндэсний хөтөлбөрөө хэрэгжүүлнэ гэвэл наадах чинь бүтэхгүй ээ.../минут дуусав/

Б.Бейсен: М.Мандхай гишүүнд 1 минут нэмж өгье.

М.Мандхай: Ерөнхийдөө яах вэ зүгээр өгүүлбэрээ дуусгачихад.

Тийм учраас энэ том үндэсний хөтөлбөр урт хугацаанд бас нэг тодорхой хэмжээний энэ чинь 5 жил хүртэл хэрэгжинэ. Цаашаагаа үргэлжлээд явах ийм хөтөлбөр учраас тусгайлсан яг энэ хөтөлбөрийг дагнасан ийм бүтэц байж энэ өөрөө амжилттай яг хэрэгжинэ.

Бидний хувьд ч гэсэн яг энэ хэрэгжилтийг нь тууштай хянах, дата мэдээллээ чөлөөтэй авдаг ийм харилцаа үүсэх, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх боломж урсгал бий болох юм.

Тэгэхээр энэ дээр бас нэгд хариулт авья.

Тэгээд гуравт нь угаасаа зарчмын зөрүүтэй санал байгаа. Тэрийгээ дараа нь хэлээд явчихъя.

Б.Бейсен: Хариулъя. Ж.Энхбаяр сайд.

Түрүүчийн нөгөө У.Отгонбаяр гишүүний хоршооны талын асуудал дээр бас хариулчхаарай.

Ж.Энхбаяр: Үнэхээр хоршоо маань үндэсний хэмжээний том хөдөлгөөн болж байгаа тул энэ хоршоог бүх талаар дэмжих, салбар хооронд уялдааг хангах, хэрэгжилтийн явцад нь дүн шинжилгээ, мониторингууд байнга хийж байх, бүх татвар, зээл, хөнгөлөлтийн бүх дэмжлэг үзүүлэх зайлшгүй шаардлага байгаа.

Үнэхээр ямар их хэрэгцээ байсан бэ гэдэг нь тодорхой болсон.

Тэгэхээр өнөөдөр яг одоогийн байдлаар Хүнс, хөдөө аж ахуйн яам энэ хоршооны асуудлыг өөр дээрээ шилжүүлэн авч амжаагүй л байна. Одоог хүртэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа “Хурдасгуур төв” дээр энэ асуудал явж байгаа.

Сая Засгийн газрын хурлаар тогтоолын төсөл ороод Хүнс, хөдөө аж ахуйн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газарт шилжүүлэхээр эхний шийдэл хийгдсэн.

Тэгээд бидний санал бол нэгэнт жижиг, дунд үйлдвэрийн газар гээд Засгийн газрын агентлаг байгаа. Энэ агентлаг өөрөө энэ асуудлаа дотроо хоршоогоо багтаагаад энэ “Хурдасгуур төв” дээр байгаа 5, 6 хүний орон тоог шилжүүлж аваад тэндээ энэ хоршооны газар гэдгээ жижиг, дунд үйлдвэрийнхээ бүтэц дотор хийгээд ингээд явахаар одоо бид бэлтгэл ажлыг хангаж байна. Хараахан шилжиж ирээгүй.

Ер нь цаашдаа энд нэгэнт хоршсон хамтарч байгаа энэ малчдыгаа зохион байгуулалтыг дээд зэргээр хангаад. Таны хэлдэг саяын тэр тоног төхөөрөмж, тэр хийж бүтээх тэр урам зоригийг нь өгсөн тэр санхүү, зээл, татварын бодлогыг нь цогц хийгээд ингээд мониторингоо зөв хийгээд явбал. Хамгийн гол нь үйлдвэрлэлтэйгээ их зөв холбож чадвал их үр дүн гарах болов уу гэж бодогдоод л байгаа юм.

Тэгээд миний хувьд Хүнс, хөдөө аж ахуйн яам нь яг салбарын хувьд үйлдвэрлэлтэйгээ, малчидтайгаа, хоршоололтойгоо нэг цогц болгоод бодлогын хувьд уялдуулаад явах нь зүйтэй гэсэн л ийм байр суурьтай илэрхийлэл байж байгаа.

Б.Бейсен: М.Мандхай гишүүн тодруулъя.

Ж.Энхбаяр: Тийм. Энэ 19 чиглэлийн 428 нэр төрлийн тоног төхөөрөмж байгаа. Энэ дээр их олон зүйл байгаа.

Мал аж ахуй, туслах аж ахуй, гурил, сүү, мах, шувуу, зөгий, ноос ноолуур, арьс шир, модон бүтээгдэхүүн, эрдэс бордоо гээд. Нийт 428 нэр төрөл дотор манай хоршоодын эрхлэх бололцоотой их олон заалтууд энд бараг байгаа. Бараг 60-аад хувь нь малчид яг энэ үүнийг ашиглаад нөгөө татвар хөнгөлөлт эдлэх бололцоотой.

Дээрээс нь бас нэлээн тооны тоног төхөөрөмжийг худалдан авсан нөхцөлд 50 хувийг нь буцаан олгодог нэг ийм систем бас байгаа.

Тэгэхээр одоо энэ хөтөлбөрийн хүрээнд энэ нэг асуудлыг миний хувьд ярих боломжгүй болчхоод байгаа юм. Байнгын хороо бодлого гаргаад зарчмын зөрүүтэй саналуудаа одоо хураагаад, тэр бодлогынхоо хүрээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, зарим бодлогын асуудлаа шигтгээд өгвөл одоо л яг таатай үедээ, одоо л яг хийдэг үе нь байхгүй юу.

Тэгэхээр гол нь бодлогоо бид сайн эндээ нэгтгэчихвэл.../минут дуусав/

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдээс санал ирсэн байна.

М.Мандхай гишүүнээс 2 санал ирсэн байна.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.2 дахь заалт нэмэх:

“3.3.4.2.Хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгохтой холбогдуулан зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлж хоршооны гишүүн малчинд олгосон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг төрөөс хариуцна.”

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол 2 гэж байна.

Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөрт” 3.3.4.3 дахь заалт нэмэх:

3.3.4.3.Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хоршооны загвар төслүүдийг бэлтгэх, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах.” гэсэн байна.

Энэ саналынхаа томьёолол үндэслээд танилцуулна уу? М.Мандхай гишүүн.

М.Мандхай: Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах зарчмын зөрүүтэй саналыг танилцуулж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтын Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр”-ийн хүрээнд 3.3.4.1-д “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг үргэлжлүүлж, Чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж оруулсан байна.

Дараах байдлаар нэмэлт оруулахаар санал гаргаж байна. Үүнд,

3.3.4.2.Хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгохтой холбогдуулан Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлж, хоршооны гишүүн малчинд олгосон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг төрөөс хариуцах.

3.3.4.3.Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хоршооны загвар төслүүдийг бэлтгэх, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах.

Эдгээр нэмэлт санал нь дараах хууль тогтоомж болон эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актаар зохицуулагдсан болно.

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6, 6.1.7 дахь заалт.

2.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт

хугацааны хөгжлийн бодлогын зорилт 8.3.2, 8.3.3, 8.3.4, 8.3.5 дахь зүйл.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын 4.2, 4.4 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн зорилт 8.3.13, 8.3.14, 8.3.15 дахь зүйл.

Дээрх хууль тогтоомж болон эрх зүйн хэм хэмжээ Засгийн газрын үйл ажиллагааны хүрээнд өнөөдрийн байдлаар 58 мянга орчим малчин гишүүнтэй 5637 хоршоо үүсгэн байгуулагдаад байна.

Энэ хүрээнд нийт 442 тэрбум төгрөгийн санхүүжилтийг арилжааны банкаар дамжуулан олгогдоод байна.

Цаашид дээрх зээл авсан хоршоод болоод шинээр хүсэлтээ гарган хүлээж байгаа малчид хоршоодыг дэмжиж хамтран ажиллах зорилгын хүрээнд “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд мэргэжлийн дэмжлэг тусалцаа үзүүлж, оролцогчдыг уялдаа холбоо, зохион байгуулалттайгаар хангаж ажиллах болон хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг үргэлжлүүлэх, төв орон нутгийн нэгдсэн арга хэмжээ, бүсийн уулзалт хэлэлцүүлэг, сургагч багш бэлтгэх сургалт, сургагч багш нарын орон нутагт ажиллах томилолт, замын зардал, мэдээллийн нэг цэгийн үйлчилгээг бий болгох.

Хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгохтой холбогдуулан Зээлийн батлан даалтын

сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, нөөц санг бүрдүүлж, хоршооны гишүүн, малчинд олгосон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг төрөөс хариуцах зэрэг үйл ажиллагааг тасралтгүй, тогтвортой хэрэгжүүлэх шаардлагатай байгаа тул энэхүү саналыг оруулж байна.

Эдгээр үйл ажиллагаа нь өөрөө хүнсний хувьсгал буюу хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээ болон “Цагаан алт” хөтөлбөр буюу малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний салшгүй нэг хэсэг буюу үндсэн суурь хөдөлгөөн гэж харж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхнийг зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Бейсен: Санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Нэг. Түрүүн би уншиж танилцуулсан. Дахиж унших шаардлага байна уу?

Малчинд олгосон хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүг төрөөс хариуцах гэдэг. Санал хураалт.

М.Мандхай гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Санал хураалт. /алх цохив/

58.8 хувиар дэмжлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол хоёр. Түүрүүн бас уншиж танилцуулсан.

Малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарын бэлтгэх сургалт зохион байгуулах тухай. Санал хураалт. /алх цохив/

64.7 хувиар дэмжигдлээ.

Ж.Батжаргал гишүүн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн хоёрын саналыг дэмжсэнээр протоколд тусгаарай.

Гурав дахь санал.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга гишүүний санал юм байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.1.1 дэх заалтын “байгалийн төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөн, хамгаалалтын менежментийг сайжруулна” гэснийг “байгалийн төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулна” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Гишүүн тайлбар хийх юм байна. Энэ санал хураалтыг хүчингүй болгочих. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо. /алх цохив/

Б.Уянга гишүүний микрофоныг өгье.

Б.Уянга: Өргөтгөн гэдгийг яагаад дэмжихгүй өөр зарчмын зөрүүтэй санал оруулж байгаа вэ гэдэг нь нэгдүгээрт бид дэлхийн дунджаас хамаагүй дээр 20-иод хувийг тусгай хамгаалалтад авчихсан.

Дээрээс нь тусгай хамгаалалтын тухай хууль дээрээ тусгай хамгаалалттай газар юу хийхийг хориглодог гэхээр ан амьтан агнах, барих, мод зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, мал аж ахуй эрхлэгч малчин өрхөд өвөлжөө хаваржааны газар олгох, голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

Тэгэхээр угаасаа хамгаалалтад авлаа гэдэг нь аягүй тийм хэрэгтэй гоё нэр юм шиг мөртөө ард талд нь энэ хуулиараа малчид амьдрах тийм өвөлжөө, хаваржааны газар ч байж болохгүй, мал ч бэлчиж болохгүй иймэрхүү хориглосон зүйл заалтууд нь тэр чигтээ явчихдаг учраас тэртээ тэргүй дэлхийн дунджаас дээгүүр хамгаалалтад автсан тохиолдолд заавал бид өргөтгөнө гэдэг үгийг байнга авч явуулах шаардлагагүй юм. Ийм тайлбар байгаа шүү. Манайхан.

Б.Бейсен: Б.Уянга гишүүний зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

52.9 хувиар дэмжигдлээ.

Т.Аубакир гишүүнийг дэмжсэнээр аваарай. Протоколд тусгаарай. У.Отгонбаяр гишүүнийг мөн дэмжсэнээр аваарай. Протоколд тусгаарай.

4 дэх зарчмын зөрүүтэй санал. А.Ундраа гишүүний зарчмын зөрүүтэй санал юм байна.

Төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.3.7 дахь заалтын “үйл ажиллагааг дэмжин” гэсний дараа “, Үндэсний ногоон барилгын үнэлгээний систем нэвтрүүлж,” гэж нэмэх.

Санал хураалт. /алх цохив/

Ц.Идэртбат гишүүн, Т.Аубакир гишүүн, М.Мандхай гишүүн, Ж.Бат-Эрдэнэ гишүүн дэмжсэн байна.

Гишүүдийн 64.7 хувь нь дэмжсэн. Ингээд дэмжигдлээ.

Дараагийн А.Ундраа гишүүний санал. 2 дахь санал.

Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад 3.4.2.9 дэх заалт нэмэх:

Төслийн 1 дүгээр хавсралтын “3.4.2.Уур амьсгалын өөрчлөлт” зорилтод доор дурдсан агуулгатай 3.4.2.9 дэх заалт нэмэх:

“3.4.2.9.Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хот, суурин газруудад яндангүй бүс байгуулж эрчим хүч, усны ухаалаг хэрэглээтэй амины орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.”

Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 76.5 хувь нь дэмжигдсэн.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн, Т.Аубакир гишүүн хоёр протоколд тусгаад дэмжсэнээр аваарай.

А.Ундраа гишүүний 3 дахь санал.

Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” гэсэн зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.29 дэх заалт нэмэх:

“3.3.4.29.Малчдад эрчим хүчний хэмнэлттэй өвлийн жишиг сууцны загвар түгээж, мэдлэг олгоно.”

Санал хураалт. /алх цохив/

52.9 хувиар дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ гишүүний саналыг дэмжсэнээр аваарай. М.Ганхүлэг гишүүнийг бас дэмжсэнээр аваарай. Протоколд тусгаарай.

Ж.Батжаргал гишүүний зарчмын зөрүүтэй санал.

Төслийн 1 дүгээр хавсралтын “1.3.5.Төвийн бүс- “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”” гэсэн зорилтын гарчгийг “1.3.5.Төвийн бүс-“Эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэржилт, эрчим хүчний дэд бүс”” гэж өөрчлөх.

Санал хураалт. /алх цохив/

64.7 хувиар дэмжигдлээ.

Ж.Батжаргал гишүүний 2 дахь санал.

Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.32 дахь заалт нэмэх:

“3.3.4.32.Сорт, сорилын төв, үрийн аж ахуйг дэмжиж, үрийн шинэчлэл хамгаалалтыг сайжруулан, гол нэр төрлийн тариалангийн үр үйлдвэрлэлд урамшуулал олгоно.”

Санал хураалт. /алх цохив/

52.9 хувиар дэмжигдлээ. М.Ганхүлэг гишүүнийг дэмжсэнээр аваарай. Ж.Бат-Эрдэнэ гишүүнийг бас дэмжсэнээр аваарай.

Ж.Батжаргал гишүүний 3 дахь санал.

Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.31 дэх заалт нэмэх:

“3.3.4.31.Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчин, залуу малчид, тариаланчдыг бэлтгэх зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.”

Санал хураалт. /алх цохив/

64.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.4.Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр” зорилтод доор дурдсан агуулгатай 3.3.4.33 заалт нэмэх:

“3.3.4.33.Үндэсний сөрөн гэсвэрлэх чадавх, хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн нөөц бүрдүүлэх хүрээнд жил бүр 100.0 мян.тн хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлнэ.”

Санал хураалт. /алх цохив/

70.6 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Одоо 2 дугаар зүйлд оръё.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай тогтоолын төслийн 2 дугаар зүйлд холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүн байна уу? Гишүүдээс санал ирээгүй байна.

Уучлаарай. О.Амгаланбаатар гишүүн байгаа юм байна. О.Амгаланбаатар гишүүнээр тасалъя. О.Амгаланбаатар, С.Ганбаатар гишүүн хоёроор тасалъя.

О.Амгаланбаатар гишүүний микрофоныг өгье.

О.Амгаланбаатар: Та бүгддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Өнгөрсөн өвөл их хүнд зуд болоод Монгол даяар.

Говь-Алтай аймагт Засгийн газрын ажлын хэсэг очсон юм.

Тэгээд Засгийн газрын ажлын хэсэгт Монголын хөдөө аж ахуйг яаж өөрчлөх вэ гээд илтгэл тавьсан чинь тэрнээс хамгийн сүүлчийн зээл өгнө гэсэн хэсгийг нь тасдаж аваад “Шинэ хоршоо” гэдэг зүйл явчихлаа.

Хамгийн буруу зүйл Монгол даяар 4 жил хэрэгжихээр болчхоод байгаа юм. “Шинэ хоршоо” гэдэг зүйл Монгол Улсыг үнэхээр самрах ийм зүйлийг хийж байна.

Тэгээд 500-аад тэрбум төгрөг гэж байна. Тэндээс ямар ч тийм үйлдвэр, малчдын амьдрал дээшлэх юм нэг ч гарахгүй.

Ж.Энхбаяр сайд хөдөө аж ахуйн салбарт бизнес хийдэг хүн өөрөө хэрвээ хувьдаа ийм ажил хэзээ ч хийхгүй гэдэгт би итгэлтэй байгаа юм.

Одоо бидний нэг алдаа бол сүүлийн 20 жилд аливаа зүйлийг саланги бүгдийг нь бодож явсан.

Өнөөдрийг хүртэл нэгдсэн иж бүрэн цогц хөтөлбөр Монгол Улс даяар

нэг ч байхгүй байна шүү дээ. Энэ хөтөлбөр дотор.

Түүрүүн Ж.Энхбаяр сайд хэлж байх шиг байна лээ. Ингээд энэ бас нэг ийм иж бүрэн биш байна гээд. Нэгэнт л энэ намууд хамтарч байгаа бол гэрээгээ хийгээд, энэ хөтөлбөрөө батлаад, үүндээ таарсан бүтцээ угсраад, энэ бүтцэдээ таарсан хийж чадах хүнээ тавиад, тэр эрх мэдлийг нь өгөөд явах ёстой байтал чинь бүх юмыг нь ингээд буруугаар нь эхэлчихсэн.

Одоо энэ 4 жилийн дараа нэг малчин хүний амьдрал дээшлэхгүй. Харин өрөөс өрөнд унаад энэ Монголын хөдөөгийн ард иргэдийн амьдрал сүйрнэ.

Ж.Энхбаяр сайдын хувьд юу ямаар байна. Хуучин нэгдэл байгуулагдаж байсан тэр бүх зүйлийг эхнээс нь сайн үзмээр байна.

Миний хувьд аймгуудад нэгдэл байгуулагдаж байсан, сангийн аж ахуй байгуулагдаж байсан. Ямар ч байсан аймагтай холбоотойгоор бүх эх сурвалжуудыг нь татаж үзээд Монголын хөдөө аж ахуйг өөрчлөх, тархай бутархай өргөн уудам нутагт яаж бид нэгдэж нийлж нэг баг болж, хөдөөгийн ард иргэд сайхан амьдрах вэ гэдэг дээр иж бүрэн цогц төлөвлөгөөг нь гаргачихсан байгаа юм, уг нь.

Тэгээд үүнийгээ танилцуулах дээр сонгууль дөхсөн. Д.Амарбаясгалан зөвхөн сонгуульд ялах тактик болгоод явчихсан.

Яг үнэндээ хэлэхэд үүнийг дахиад сонгуулийнх нь 500 тэрбум төгрөгөө буцааж авахын төлөө энэ 4 жил Монголын ард түмний хувьд ийм нүглийг хийж болохгүй.

Өнөөдөр тэр 500 тэрбум төгрөгийнхөө араас нэг бүрчлэн тэр У.Отгонбаярын хэлдгээр үнэлгээ хийгээд үзэхэд эндээс ёстой 5 хувь нь ч үйлдвэр болохгүй.

Аливаа зүйл чинь эхлэхээсээ төгсгөл хүртэл, төрөхөөсөө бараг үхэх хүртлээ бүх юмыг нь иж бүрэн тооцож байж энэ үйлдвэрлэл энэ зүйл чинь явах ёстой юм.

Тэгэхээр Ж.Энхбаяр сайдын хувьд одоо нэгэнт энэ хувийн хэвшилд үр дүнтэй ажилладаг хүн юмаа иж бүрээр нь цогцоор нь хараадхаач ээ. Юмаа цогцоор нь хараад тэр эрх мэдэл авах юмнуудаа бүр оруулж ирээд аваад яг энэ Монголын хөдөө аж ахуйг тэр хуучин нэгдлийн орчин үеийн хэлбэрээр өөрчлөөдхөөч ээ л гэж хүсэх байна. Үүнийг дагаад.../минут дуусав/

Б.Бейсен: О.Амгаланбаатар гишүүнд 2 минут олгоё.

О.Амгаланбаатар: Үүнийг дагаад хөдөөгийн тэр хөгжил чинь, хүн ам зүйн бодлого чинь, энэ орлого чинь бүх юм ингээд жигдрээд явчих юм.

Хөдөө орлого нь хангалтгүй байж байхад хөдөө хүн очиж амьдар гэж тэр хөдөөгийн сэргэлт гэж хэлээд 10, 10 хувийнхаа хүнийг татаж ав гэж хэлээд тийм социализмын захиргааны арга хэзээ ч явахгүй.

Хэн хаана орлого олж байна тэр газар л хүний төвлөрөл бий болдог. Гэтэл үүнийг чинь иж бүрнээр нь хийчих загвар нь үндсэндээ гарчихсан байж байгаа гэдгийг би Ж.Энхбаяр сайдад жич очиж танилцуулъя.

Тэгэхээр юмыг ингэж нэг ийм зөвхөн өнөөдрийн Их Хурлын нэг, хоёр гишүүнд тааруулж, эсвэл амьдрал мэдэхгүй эрх баригчид, амьдрал мэдэхгүй дарга нарынхаа үгээр ийм юм хийгээд явах юм бол Монголын хөдөө аж ахуй сүйрнэ шүү.

Одоо үе үеийн бүх сайд нар байна. Тэр Байгаль орчин, хөдөө аж ахуй, Ерөнхий сайд нарт. Яг энэ хүнээр овоглох юу үлдсэн бэ гээд үзэхээр, энэ хүн яг юуг хийсэн бэ гээд үзэхээр юу ч байхгүй шүү дээ.

30 жил бид нар утаа гээд ярьж байна. Тэр дундаа сүүлийн 20 жил ямар их мөнгө зарцуулав. Хөдөөгийн хөгжил гэж л ямар их мөнгө тарааж өгөв. Энэ болгон чинь бүгдээрээ үр дүнд хүрээгүй юм.

Тэгэхээр аливаа зүйлийг нэг ийм иж бүрдлээр нь, цогцоор нь хараадхаач ээ.

Дахиад хэлье. Үндсэн хуульд чинь сум, аймаг нийгэм, эдийн засгийн цогцолбор байна гэж байгаа бол тэр цогцолбор луу нь явуулаач. Эрх мэдлийг нь өгөх хэрэгтэй байна. Дахиад тэр хуулийнх нь орчныг бүрдүүлж өгөх хэрэгтэй байна.

Хөдөөгийн ард иргэд нийлж нэг баг болох тэр боломж нь маш амархан байгаа шүү дээ. Өнөөдрийн энэ аргаар бүтэхгүй гэдгийг дахин дахин хэлье.

Тэгээд та хэд яах вэ, дарга нарынхаа үгээр гар өргөөд явчихдаг ийм л нам юм байна. Үнэхээр хэцүү юм байна.

Монголыг дахиад 4 жил хамгийн том хорлох юм бол энэ “Шинэ хоршоо” гэдэг дээр 100 хувь байна шүү.

Та хэд энэ мөнгөнийхөө араас одоо хэдэн жил хөөцөлдөнө. Эргээд энэ 4 жилийн дараа Монголын хөдөөд нэг ч үйлдвэр ашиглалтад орохгүй, Монголын хөдөөд байгаа малчин ард иргэдийн нэг ч орлого нэмэгдэхгүй, нэг хонины үнэ 10 мянгаар ч бараг нэмэгдэхгүй байх. Инфляцаар л нэмэгдвэл нэмэгдэнэ.

Тэгэхээр дахиад хэлье.

Ж.Энхбаяр сайд аа, Та бүх өнгөрсөн 20 жил дээр үнэлгээ хийгээдхээрэй. 20 жил дээр үнэлгээ хийгээд, социализмын үеийнх дээр үнэлгээ хийгээд тэгээд нэг шинэ загвар гаргаж ирээрэй гэж захья.

Б.Бейсен: Гишүүд тогтоолын төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуухгүй, 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад. Дэгээ барихгүй бол бас болохгүй шүү.

Г.Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Би ч жоохон хоцорч орж ирээд асуулт асуух, санал тавих юунаасаа хоцорчихлоо.

Гэхдээ одоо энэ тогтоолын төсөлтэй холбоотой саналаа хэлчихье гэж бодож байна.

Өнгөрсөн өвөл нийт мал сүргийнхээ 10 гаруй хувийг нэг жилийн зуднаар 8.1 сая толгой мал хорогдсон.

4816 өрх айл нийт мал сүргийнхээ 70-аас дээш хувийг, 509 өрх айл огт малгүй болсон гэсэн ийм мэдээ байдаг.

Тэгэхээр малчдаа малжуулах чиглэлээр яам сайн анхаарч ажиллаарай. Энэ “Шинэ хоршоо” төсөл чинь малгүй малчдыг малжуулж байгаа эд биш шүү. Малтай малчдад малаар нь барьцаа авч барьцаалж үндсэндээ хоршоолж байгаа хэлбэр.

Тийм учраас үндсэндээ энэ чинь 5 мянга гаруй өрх огт малгүй, амьдрал нь хүнд байдалд орсон гэсэн үг.

Тэр “Шинэ хоршоо”-той холбоотой. Ер нь яах вэ яамнаас нэг бодлого чиглэлийг нь сая сонслоо.

“Цагаан алт” гээд хөнгөн үйлдвэрийн чиглэлээр, “Шинэ хоршоо” гээд хөдөө малчдыг, “Атрын-IV” газар тариалангийн салбарт. Ийм 3 гол бодлого л явах юм байна.

“Цагаан алт” хөнгөн үйлдвэрийн бодлогыг сайн дэмжиж байгаа.

Өнөөдөр үндсэндээ малчид махнаас өөр зүйл үнэгүй учраас үндсэндээ малынхаа тоо толгой өсөөд хүн малгүй ядарч байна, мал нь давжаарч байна, бэлчээрийн даац талхлагдаж байна.

Хөдөөд залуу малчид, Монгол орны хөдөө үндсэндээ байгаль цаг уураас болоод эзэнгүй. Малчид халширч эхэлж байна. Манай мал аж ахуйн салбарт залуу малчид гэдэг ойлголт байхгүй боллоо.

Яах вэ энэ зун говийн бүс, ер нь нийт орон даяар гайгүй зуншлага болсон учраас малчид арай жоохон урам зориг сэргэж байгаа байх.

Түүнээс биш яг үндсэндээ сүүлийн хоёр, гурван жил байгаль, цаг уур хяхаад малчдын амьдрал ч үнэхээрийн энд ярьж

байгаагаас тэс өөр байгаа шүү гэдгийг бас хэлье.

Тэгээд ер нь цаашдаа энэ чинь хүн төрөлхтний ганц олж эрсдэлээс сэргийлсэн ганц арга бол ерөөсөө даатгал шүү дээ.

Энэ мал аж ахуй, энэ уламжлалт мал аж ахуйг үндсэндээ даатгалын системийг нь сайжруулахгүй бол. Дээрээс нь Үндсэн хуулийн заалт байгаа. Мал сүрэг төрийн хамгаалалтад байна гээд.

Үнэхээрийн тэр Үндсэн хуулийн заалттай юм бол ядаж малчдаа хариуцлагажуулаад 50 хувийг нь малчид өөрсдөө даатгалаа төлдөг, төрөөс 50 хувийнх нь тодорхой хэмжээний даатгалыг нь төлдөг ийм систем рүү яваад даатгалынхаа системийг арай боловсронгуй болгохгүй бол зуд болоод өнгөрснийх нь дараа нэг жоохон тусламж очдог.

Тэгээд энэ жилийн хувьд түрүүний хэлсэн тийм хэмжээний хохирол бас 8.1 сая толгойгоо малаа алдталаа нэг зудад хохирч байна гэдэг бол манай хөдөө аж ахуй ямар эмзэг байгааг, ямар эрсдэлтэй байгааг харуулж байгаа юм.

Тэгээд энэ чиглэлээр сайн анхаарч ажиллаарай гэдгийг Хөдөө аж ахуйн яамныхандаа хэлье.

Тэгээд тэр “Шинэ хоршоо” дээр бас Та бүхэн маань тоогоо нэгтгэхгүй бол түрүүн сайдын.../минут дуусав/

Б.Бейсен: Г.Ганбаатар гишүүнд 1 минут нэмж олгоё.

Г.Ганбаатар: Түрүүн сайдын илтгэлд 442 тэрбум төгрөг 3467 хоршоо

авсан гэж ярихад гишүүдийн мэдээлэл бол 5637 гээд. Ийм их зөрүүтэй байна.

Тийм учраас энэ тоонуудаа бас нэгтгэж хараарай.

Тэгээд нэн тэргүүний асуудал бол одоо малчдыг орлогожуулах асуудал, малжуулах асуудал байгаа шүү гэдгийг хэлье.

Тэгээд Та бүхэнд амжилт хүсье. Баярлалаа.

Б.Бейсен: Тогтоолын төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тогтоолын төслийн 3 дугаар зүйлтэй холбоотой гишүүдээс санал ирээгүй байна.

Асуулт асуух гишүүн байна уу? 3 дугаар зүйлтэй холбоотой. Байхгүй байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тогтоолын төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдээс санал ирээгүй байна.

Асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Тогтоолын төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн талаарх хэлэлцүүлэг хийж дууслаа. /алх цохив/

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулна. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

Хоёр. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг оруулья.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 онд төсвийн тухай хуулийн төслүүдийг Засгийн газар 2024 оны 8 сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн байгаа. Мэдүүлсэн.

Ажлын хэсгийг танилцуулья.

Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Д.Загджав Монгол Улсын ерөнхий аудитор, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч, Ц.Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Л.Мөнхцацрал Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын аудитын удирдлагын менежер, Ю.Энхтуяа Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын менежер, Э.Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, З.Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дарга, Т.Гантогтох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга, Л.Идэрцогт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Г.Наранчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Н.Оюунсүвд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга, Х.Гэрэлмаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, А.Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Б.Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн

газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга, Н.Мандуул Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Д.Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Б.Батхуяг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын зөвлөх, Б.Анар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хяналт шалгалтын багийн ахлах хянан шалгагч, Ө.Ариунболор Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн, Д.Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Д.Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Л.Хосбаяр Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч, Э.Цолмон Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах шинжээч, Т.Отгонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч, Б.Дэнсмаа Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Г.Мөнхзул Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Б.Энхжин Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Д.Дэчин Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайд ирээгүй юм уу?

Ж.Энхбаяр сайдад микрофон олгоё. Б.Жавхлан сайд хурал давхцаж байгаа учраас Засгийн газрын гишүүн Ж.Энхбаяр сайд танилцуулна.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Төсвийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

“Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн 2024 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа.

Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудлыг шийдэх, эдийн засгийн өсөлтийг 5-аас 6 ба түүнээс дээш хувьд, инфляцыг нэг оронтой тоонд, зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх хурдтай, зоригтой, эрс шийдвэрүүдийг гаргаж шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндэс суурийг тавьж байна.

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна. Үүнд,

Нэгдүгээрт, бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд нийслэлийн их, бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, “Өөдөө тэмүүлэх Монгол” буюу GoMongolia ган татлагат гүүр, Хөшгийн хөндийн туннел, Хөшгийн хөндийн төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох шинэ сэргэлтийн “5 тойрог” авто замын төсөл, “Шинэ Хархорум” төсөл, “Шинэ Зуунмод” хот, “Туулын хурдны зам” зэрэг төслүүдийг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах тэг техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

Хоёрдугаарт, гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлж буй бүсчилсэн хөгжил, шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг 984.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотголд тусгалаа.

Гуравдугаарт, 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж либералчлах, хувийн хэвшил тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх шилжилтийн үеийн зардлыг тусгалаа.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль тогтоолын төслүүд батлагдсан.

Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхий захирагч хооронд шилжсэн, шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон, мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийлээ.

Тавдугаарт, эрдэс баялгийн салбараас төсөв төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж “Ирээдүйн өв сан”, “Хуримтлалын сан”, “Хөгжлийн сан” гэсэн 3 төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгосон билээ.

Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2004 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны

төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайддаа баярлалаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна.

3 номерын микрофон өгөөрэй.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь төсвийн ерөнхийлөн захирагчдын хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн гурван намаас “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэрээ байгуулж, эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.4-д заасан нөхцөл төсөвт тодотгол хийх шаардлагыг бий болгосон байна.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны

төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт нийт 124.9 тэрбум төгрөгийн өөрчлөлт оруулсан байна.

Танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Д.Загджав даргад баярлалаа.

Монгол Улсын 2024 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлсэн.

Та бүхэнд үүнийг хүргүүлсэн болно.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүн байна уу? Нэрс өгнө үү.

Ц.Идэртбат гишүүнээр тасаллаа. М.Мандхай гишүүнийг оруулъя. Кноп нь ажиллахгүй байгаа юм байна.

М.Ганхүлэг гишүүнээс эхэлж асуулт асууя.

М.Ганхүлэг: Улсын төсвийн тодотголтой холбогдолтойгоор яг одоо манай Байнгын хороотой хамааралтай байгаль орчны асуудал, хөдөө аж ахуйн асуудалтай холбогдолтой гол гол агуулгуудыг яамд маань тодорхой зааглаад нэгдсэн мэдээллийг салгаад өгчих нь зөв байх. Ийм ийм гол асуудлууд тодотголын хүрээнд шийдвэрлэгдэж байна гэдэг талаас нь.

Миний хувьд ерөнхий агуулгаар нь улсын төсвийн энэ өөрчлөлтийг дэмжиж байгаа.

Энэ удаад цаг хугацаа хожих томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлэх, ялангуяа нийслэлийн асуудал дээр нэлээн анхаарсан ийм тодотгол орж ирж байгаа юм.

Тэр утгаар нь тодорхой ажлуудыг эхлүүлэх, техник, эдийн засгийн үндэслэлүүдийг боловсруулах ажлуудыг хэрэгжүүлэх нь зөв гэж харж байгаа.

Яг хөдөө аж ахуйн салбартай холбогдолтой энэ тодотголоор зайлшгүй шийдэх цаг үеийн нөхцөл байдал, малчдын асуудалтай холбогдолтой асуудлуудыг харгалзан үзэх, тодорхой тусгасан агуулгуудыг нэмэгдүүлэх саналууд байгаа юм.

Жишээлэх юм бол бид бүхний нэлээдгүй хэмжээнд яриад байгаа “Шинэ хоршоо” хөдөлгөөнтэй холбогдолтой энэ асуудал 5 жилийн хугацаатай 5 их наядын хөтөлбөр байгаа юм.

Ингээд ойролцоогоор жилд 1 их наяд төгрөгийн санхүүжилтийг банкуудаар дамжуулж хүүгийн дотацийг нь Хүнс, хөдөө аж ахуйн сайдын багцад

суулгаж олгох ийм зорилготой хөтөлбөр байгаа.

Тэгэхээр бид бүхэн эхний удаад төлөвлөснөөр 6 сараас эхлээд хэрэгжинэ.

Тэгээд хагас жилийн хугацаа учраас 500 тэрбумын санхүүжилт байхад бүрэн боломжтой гэдэг байдлаар хандсан.

4 сарын 19-ний өдөр батлагдсан уламжлалт мал аж ахуйгаа уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй болгоё гэдэг зорилтын хүрээнд батлагдсан хуулийн үр дүн гишүүд янз янзын байр суурьтай байх шиг байна.

Яах вэ улс төрийн өнцөг талаас нь тодорхой агуулга талаас нь харж болно. Гэхдээ яг энэ хоёр, гуравхан сарын дотор нэгдэж байгаа нийт хоршоодын тоог нэг хараарай. Энд гишүүнээр элссэн байгаа малчдын тоог хараарай.

Үнэхээр энэ хөтөлбөр үр дүнгүй, муу гэж үзэж байсан бол хоёр, гурван сарын дотор үр дүн гарахгүй.

Өнөөдрийн байдлаар нийт малчдын 4 малчин тутмын нэг нь хоршооны гишүүн болсон байна.

Эдгээр 57 мянган малчдаас 12 мянга нь эхний зээлийн үр дүнг авсан байна. Үүний цаана ойролцоогоор 40 орчим мянган малчид дараагийнхаа хүсэлтийг хүлээгээд байж байгаа нийгмийн хэрэгцээ үүсчихсэн байна.

Энэ өвлийн нөхцөл байдал энгийн сайхан болно гэдэг баталгаа алга.

Тэгэхээр энэ өвлийн нөхцөл байдлыг даван туулахад нь малчдаа дэмжих.../минут дуусав/

Б.Бейсен: Сангийн сайд хариулъя. Хөдөө аж ахуйн яам хариулъя. 4 номер.

Ж.Энхбаяр: Үнэхээр малчдын зээлийн хэрэглээ байгаа. Одоо байгаа эх үүсвэр үндсэндээ бүрэн олгогдоод дуусаж байгаа.

Ер нь эх үүсвэрийг нэмэх зайлшгүй шаардлага байна. Ялангуяа өнгөрсөн өвлийн хохирол амссан бүс нутгуудад хорших, тэгээд зээл авах, түүгээрээ үржлийн мал авах, мал худалдан авах саналууд ихээр төвлөрч байгаа.

Тэгэхээр миний хувьд Засгийн газраас өргөн барьсан хэмжээнд байна.

Хэрвээ мэргэжлийн Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналыг М.Ганхүлэг гишүүн гаргаад, энэ эх үүсвэрийг нэмье гэдэг маягаар саналын томьёолол гаргаад, хураалгаад, чуулганаар хэлэлцүүлэгт хийх бололцоотой байгаа.

Ер нь шаардлага байгаа нь тодорхой. Бид албан бичгээ Сангийн яам болон Монголбанканд хүргүүлж байгаа. Энд нэмэгдэх зайлшгүй шаардлага үндэслэлийг гаргаж байгаа.

Б.Бейсен: М.Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Яах вэ, тодорхой хэдүүлээ яриад дүн балтай нь яриад явчихвал зүгээр байх л гэж бодоод байна л даа.

Төсвийн тодотгол дээр малчдын хоршоо, малчдын зээлийн тодорхой энэ хөтөлбөр “Цагаан алт” хөтөлбөртэй

холбогдолтой 126 тэрбум гэж орж ирсэн гэж ойлгосон.

Үүнээс “Шинэ хоршоо” хөдөлгөөнтэй холбогдолтой нь 25.9 тэрбум байгааг тодорхой хэмжээгээр буюу 10 тэрбумаар нэмэгдүүлэх зарчмын зөрүүтэй саналыг оруулбал процессын хувьд яаж явах ёстой вэ? Тэр дээр манайхан мэдээллүүд өгөөч ээ.

Ингэснээрээ энэ жилийн 500 тэрбум төгрөгийн санхүүжилтийг арилжааны банкуудаас гаргах эх үүсвэрийг дахин нэмэгдүүлэх бололцоо юмнууд бүрдэх саналтай байгаа юм.

Тэгэхээр энэ зарчмын зөрүүтэй саналаар Байнгын хороон дээр санал хурааж өгөөч ээ гэдэг саналтай байна.

Б.Бейсен: Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

Чиглэлийн яам нь зах зээлийнхээ судалгааг хийгээд, багтаамжаа хараад, зах зээлийн бэлэн байдлыг хараад тооцоо судалгаагаа хийгээд ирүүлсэн л дээ.

Тэр нь нэг мөнгө ч дутаагаагүй тавьсан байгаа. Яагаад вэ гэхээр энэ бодлого өөрөө их чухал юм. Дээрээс нь хамтарсан Засгийн газрын хөтөлбөрт орчхож байгаа учраас.

Тэгэхээр энэ тооцоолол дээр М.Ганхүлэг гишүүн эргээд нэг хараарай. Дотор нь нэг задлаад үзээрэй.

Тэгэхээр энэ мөнгө хангалттай дүн байхгүй юу. Юу вэ гэхээр эндээс тодотгол хийгдчихэнгүүт маргааш нь энэ чинь бүх дүн гарахгүй. Нэгдүгээрт.

Тэр банк дээр очсон бэлэн хүлээгдэж байгаа зээлийн шийдвэр гаргасан хэсэг нь эхлээд гарна. Дараа нь судлагдана.

Тэгээд энэ чинь одоо ингээд гуравхан сар үлдчихлээ. Тэгээд 10, 11, 12 сарынх гүйцэтгэл Монголбанк 1 дүгээр сард гүйцэтгэлээ Сангийн яаманд ирүүлнэ.

Тэгээд 1 дүгээр сард энэ зузаатгал гарна. Энэ улирлын сүүлийн 3 сарынх.

Хэрвээ сүүлийн 3 сарынхыг өгнө гэж байвал 2025 оны төсөв дээр тавьж байж энэ цаашаа явах байхгүй юу.

Тэгэхээр та юу гэдэг юм, дахиад хэдэн зууг гаргана. Тэр нь өнөө маргаашгүй гарна. Энэ жилийнх гэдэг тийм ойлголт жоохон зөрүүтэй шүү.

Тэгэхээр 2024 оны 4 дүгээр улиралд 2025 оны 1 дүгээр улирал дээрээ хувааж тавьж байж энэ оны эцсийнх гарна.

Б.Бейсен: М.Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Тийм. Манай яамныхан нэмэлт мэдээлэл юмнуудыг өгөх нь зөв байх.

Одоогийн хүсэлт нь 508 тэрбум болоод тулчихсан. Үүнтэй холбогдолтой хүүгийн дотаци буюу 25.9 тэрбумыг нь оруулаад, энэ бол 8 сарын өмнөх зээлүүдийн үндсэндээ эх үүсвэр баталгаажна гэсэн үг.

Үүнээс цаана би 40 мянган малчин хоршоо болоод нэгдчихсэн. Хүсэлтээ өгчихсөн бас мянга гаруй хоршоод зээл

авахгүй гэдэг шалтгаанаар бүрэн зогссон байдалтай 2 долоо хонож байгаа юм.

Тийм учраас энэ өвлийн нөхцөл байдал хүндрэх нь тодорхой байна.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын хоршоо хашаа саравчаа өвлөөс өмнө бариад авчихъя л гэдэг саналыг хэлж байгаа юм.

Эрдэнэцагаан дээр ажиллаж байгаа хоршоод намрын энэ цаг үе дээр хадлан тэжээл бэлтгэхтэй холбогдолтой асуудлуудаа эхлүүлсэн. Дутуу байгаа санхүүжилт юмнуудаа нэмээд авчихъя.

Энэ өвлийн нөхцөл байдлыг давах тухай асуудал ярьж байгаа учраас заавал үүнийг тодотгол дээр оруулж ирж.../минут дуусав/

Б.Бейсен: Сангийн сайд нэмж хариулах уу? Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Би зөндөө л тайлбарлалаа. Хөдөө аж ахуйн яамныхан бас ямар бодолтой байгаа юм. Энэ дээрээ хэлээрэй. Хаанаас ямар тоо авсан юм бол доо.

Одоо энэ 8 сарын 12-ны байдлаар Монголбанкнаас авсан мэдээ шүү. Одоо энэ банкуудын гаргасан зээлийн үлдэгдлийг Монголбанкнаас өөр үнэн зөв гаргах газар байхгүй. Үүнийг цээжээрээ ярьдаг тоо бүр биш шүү.

Одоо энэ 12-ны өдрийн байдлаар 442.0 тэрбум төгрөгийн 12 мянга 885 ширхэг малчин хамрагдсан 3467 хоршоо зээл авчээ.

Одоо банкууд дээр 66.0 тэрбум төгрөгийн. Банкууд юу байх вэ дээ,

хоёрхон л банк байгаа. Төрийн банк, ХААН банк хоёр.

66.0 тэрбум төгрөгийн зээл судлагдаж байгаа юм байна. Үүнд хамрагдах малчин нь 911, хоршооны тоо нь 252 гээд. Ингээд бүр аймаг аймгаараа ч байж байна.

Ийм байдалтай байна. Тэгэхээр тооцоо судалгаа муутай хэт туйлширч хамаагүй том дүн тавиад хайран төсвийн орон зай авч тавиад өөр чухал санхүүжилтүүд урд хойноо ороод явчих вий.

Тийм учраас үүнийгээ их бодитой судалгаа хийж байж ингэж явах хэрэгтэй.

Бид төсвийн бодлогын хүрээнд салбарынхаа энэ чухал үндэсний хэмжээний хөтөлбөрийг бүрэн дэмжээд явж байгаа.

Тийм учраас аль болох зогсолтгүйгээр явах нь их чухал шүү. Тийм.

Тийм учраас одоо байгаа судалгаа, Хөдөө аж ахуйн яамнаас ирсэн тооны хувьд би энэ тоонд нь итгэж байна. Тийм. Тэгээд зогсохгүй явах байх гэж бодож байна. Тийм.

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Тийм. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хувьд дэмжихэж байгаа юм.

Ингээд явах ёстой гэж.

Саяын М.Ганхүлэг гишүүний яриад байгаа “Шинэ хоршоо”, түүнтэй холбоотой зээлийн хүүгийн дотацийг би Хөдөө аж ахуйн сайд төсвийн ерөнхийлөн захирагчийнхаа хүрээнд асуудлаа шийдээд явчхаж болно л гэж бодоод байгаа шүү дээ. Тэгж ойлгогдож байна уу, үгүй юу? Ж.Энхбаяр дарга аа.

Тэр 126 тэрбум төгрөгөөс “Цагаан алт” руугаа ямар хэмжээний юм гараад явчих юм, “Шинэ хоршоо” руугаа хэдий хэмжээний юм гарах юм тэрийгээ та дотроо зохицуулалтаа хийх боломж чинь байгаа шүү дээ. Эрх зүйн хувьд. Би тэгж л ойлгоод байгаа шүү дээ.

Тийм учраас 126 тэрбумаар нь явчихад би болох юм байна.

Тийм учраас нэг их яриа гарахгүй юм байна гэж.

Харин хамгийн гол зүйл гурилын үнийн хөөрөгдлийг бууруулах зорилгоор гурилын импортын татварыг чөлөөлчихсөн.

Үүнийг дагуулаад Улсын Их Хурлаас тов тодорхой шийдвэр гарсан юм. Газар тариалангийн үйлдвэрлэлээ өөрийг нь эрсдэлээс хамгаалах үүднээс намрын ургац хураалт дээрээс 100 мянган тонн хүнсний улаан буудай стратегийн нөөцдөө худалдаж авна.

Үүгээрээ бид цаашид **“үндэсний сөрөн гэсвэрлэх чадавх”**-ыг ч нэмэгдүүлнэ, хүнсний хангамж, аюулгүй байдлаа ч бий болгоно гэж тооцсон.

Намрын ургац хураалт хаяанд ирсэн байна. 100 мянган тонн улаан буудайг худалдан авах мөнгөний чинь асуудал 2024 оны төсөвт суугаагүй.

Одоо энэ асуудал харин энэ төсвийн тодотголоор яг орох учиртай. Үүнийг Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам ямар бодлого чиглэлтэй, яаж зохицуулна гэж бодоод байна вэ? Энэ дээр би нэг тов тодорхой тайлбар хариу авмаар байна.

Ер нь энэ шийдвэр гарсантай холбогдоод газар тариалангийн салбарт нэлээн том эрсдэл дагуулсан. Энэ жил хаврын тариалалт, улаан буудайн тариалалтад 20 гаруй хувиар буурчихсан.

Одоо бид намрын ургац дээрээс тэр аюулгүй нөөцөө бүрдүүлж тодорхой хэмжээний будаа худалдаж авахгүй бол ирэх оны тариалалт үүнээс ч их хэмжээгээр буурчих ийм эрсдэл үүснэ шүү.

Дэлхий ертөнц өөрөө нэлээн өөрчлөгдөөд байх шиг байна. Геополитикийн чинь нөхцөл байдал тийм амаргүй байна.

Бидний оруулж ирээд байдаг тэр будаа, гурил чинь нийлүүлэгдэхээ байчихвал энэ үндэстэн юугаа хэрэглэх юм.

Тийм учраас нэгэнт бий болгочихсон жаран хэдэн жил тусгайлсан аян зохион байгуулаад өнөөдрийн зэрэгт авчирсан энэ газар тариалангийн үйлдвэрлэлийг өөрийг нь зах зээлийнх нь жаягт нэгдүгээрт шилжүүлэх ёстой.

Хоёрдугаарт, аюулгүй байдлаа хангах үүднээс.../минут дуусав/

Б.Бейсен: Хариулъя. Хөдөө аж ахуйн сайд, Сангийн сайд хоёр хариулах юм байна. 4 номерын микрофон өгье.

Ж.Энхбаяр: Ж.Батжаргал гишүүний асуултад хариулья.

Энэ удаагийн тодотголд тусаж байгаа 126.7 тэрбум төгрөг 3 бүлэгт хуваагдаж байгаа.

Улсын хэмжээний 2023, 2024 оны өвөлжилт хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор малчдын зээл хойшлуулсан. Энэ нь өөрөө 77.3 тэрбум. Үндсэндээ энэ мөнгө гарчихсан гэсэн үг.

Хоршооны гишүүдэд олгосон саяын 500 тэрбумын зээлийн хүүгийн дотацид 25.9. Үндсэндээ гүйцэтгэлээрээ гараад дуусна. Хооронд нь зохицуулах бололцоо байхгүй.

“Цагаан алт” хөтөлбөрийг одоо эхлүүлэхээр бэлдэж байна.

“Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд нийт 300 тэрбум төгрөгийн эх үүсвэр шийдэгдсэн. Энэ нь Улсын Их Хурлын 63 дугаар тогтоолтой. Энд 23.5 тэрбум төгрөгийн хүүгийн дотаци байгаа.

Тэгэхээр хооронд нь гүйлгэх ямар нэгэн бололцоо байхгүй.

Эхний хоёр малчдын зээл хойшлуулсан мөнгө. Хоршооны зээл хоёр гараад үндсэндээ гарчаж байгаа гэсэн үг.

Гуравдугаарт, стратегийн нөөц бүрдүүлэхтэй холбоотойгоор 2025 оны төсөв дээр бид 120 тэрбум төгрөг буюу 100 мянган тонн үр тариа нөөц бүрдүүлэх гэсэн санал Сангийн яаманд хүргүүлсэн байгаа.

Таны хэлсэнтэй санал нэг. Өнгөрсөн хаврын шийдвэртэй холбоотойгоор тарилт 20 хувь багассан.

Нийт 56 мянган гагаар үр тарианы тариалалт багасаад.

Тариаланчид хэрвээ энэ маяг цаашдаа үргэлжилбэл ирэх онд үр тариа, улаан буудайн тариалалт үндсэндээ боломжгүй гэдгээ илэрхийлж байгаа.

Тэгэхээр бид Сангийн яамтайгаа ч үндсэндээ зөвшилцөөд ойлгосон. Хууль зүйн яаманд зөвшилцөөд ойлгож байгаа.

Хугацаагүй тавьчихсан байгаа хуулийн үйлчлэлийг хугацаа тавьж. Үндсэндээ өвөлжилтийн хүнд үе, үнэ өсөлтийг тэр зохицуулах бодлогын арга хэмжээ амжилттай хэрэгжлээ гэж үзээд 10 сарын 01 гэхэд татварын хязгаарлалтгүйгээр, тэр боомтын хязгаарлалтгүй квотгүйгээр орж ирж байгаа гурилын импортыг зогсоох хуулийн төслийг санал аваад тойроод явж байгаа. Улсын Их Хуралд удахгүй өргөн барих байх.

Манай яаман дээр ер нь гүйцэтгэлээрээ намартаа будаагаа аваад 1 дүгээр улиралдаа мөнгийг нь өгч ирсэн.

Манай дээр 2023 онд батлагдсан 30 орчим тэрбум төгрөг байсан. 2024 оны 1 дүгээр улиралд аж ахуйн нэгжүүддээ үндсэндээ авсан будаандаа өгөөд дууссан.

Одоо санал 120 тэрбумаар байгаа. Хэрхэн батлагдах нь одоо өргөн барих төсөлтэй холбоотойгоор шийдэгдэх байх.

Б.Бейсен: Б.Жавхлан сайд хариулья.

Б.Жавхлан: Тийм. Ж.Энхбаяр сайд маань бараг хэлчихлээ дээ.

Зүгээр яах вэ би төсөв талаасаа санаа зовдог зүйлээ нэг хэлчихье. Энд мэргэжлийн хүмүүс байдаг Байнгын хороо учраас.

Бид энэ худалдан авах ажиллагааг болж өгвөл яг өрийн нөөцийн бодлого дээрээ л халимааргүй байгаа юм. Халимааргүй байгаа юм.

Татвар болон бусад зүйл дээрээс шалтгаалсан сөрөг нөлөөллийг зөөлрүүлэх гэдэг юм уу, багасгах гэдэг юм уу бас л ингээд нэг зүйлээс болоод нөгөө тийшээгээ халамжийн чиглэл рүүгээ гүйж ороод, зүгээр ингээд үрийн биш үрийн нөөцөөсөө давсан хэмжээний. Зарим талаар гурилын үйлдвэрүүд худалдаж авдаггүй, шаардлага хангадаггүй будаануудыг аваачиж төрд шахдаг процесс дахиад давтагддаг.../минут дуусав/

Б.Бейсен: Б.Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм болгоомжлол байгаа шүү. Энэ дээр манай Хөдөө аж ахуйн яам болон Байнгын хорооноос их сайн хяналт тавимаар байгаа юм.

Үнэ уначихсан гэдэг зорилгоор энэ чинь зөрүү дотаци өгөх гээд байна уу, эсвэл бүр худалдан авалт хийх гээд байна уу. Эд нарыгаа их сайн судалж байж, их сайн төлөвлөж байж оновчтой юм хийхгүй бол бас дахиад л дараагийнхаа зовлонг бий болгочих вий.

120 тэрбум гэдэг бол урьд өмнө худалдаж авч байгаагүй том дүн.

Тийм учраас энэ дээр их л сайн судлаарай л гэж хэлэх гэсэн юм.

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Хөдөө аж ахуйн яам асуудлаа нэлээн судална биз дээ.

Гурилын үйлдвэрүүдийн чинь элеваторт байж байгаа бүтээгдэхүүн хийчихээр бүтээгдэхүүнийх нь өөрийн стандарт хэрэглээндээ нийцэж өгөхгүй баахан будаа байгаад байна.

Жорлогч хэрэгтэй байгаад байгаа. Үндсэндээ чанар сайжруулагч будаа гэсэн үг байхгүй юу.

Түүнийг нь бид оруулж ирэх шийдвэр 80 хэдэн мянган тонныг оны эхэн дээр гаргасан. ашиглаад дууссан гэж үйлдвэрийнхэн надтай 6 сард уулзахдаа ярьж байсан шиг санадаг юм.

Тэгээд одоо үлдэгдэл хэдий хэмжээний байгаа юм. Намрын ургац дээрээс наад гурилын үйлдвэрүүд чинь хэдий хэмжээний юм худалдаж авах бололцоо боломж байгаа юм гэдэг тооцооллоо нэг хармаар байгаа. Нэг.

Хоёрдугаарт, ер нь энэ газар тариалангийн салбар чинь нэлээн хүндрэл дундуур, нэлээн өртөгжилт дундуур яваад байна шүү.

Бүтээгдэхүүнийг нь та нар авчхаад 3, 4 сарын дараа үнийг нь өгдөг. Тэр хооронд энэ тариаланчид баахан банкны зээлийн хүү төлөөд сууж байдаг ийм зах зээлийн нийгэм байж таарахгүй шүү.

Дараа оны төсөв дээр мөнгийг нь суулгачхаад, урд онд нь бүтээгдэхүүнийг нь авчхаад, төсвийн хууль үйлчлээд эхлэхээр мөнгийг нь өгдөг. Үүнээс чинь болж наад баялаг бүтээгчид чинь хүндрээд байгаа зүйл байгаа шүү дээ.

Б.Жавхлан: Төсвөөс холдуулж л хийхгүй бол. Бүр авахаа болиод.

Ж.Батжаргал: Үгүй. Болохгүй. Үндэсний аюулгүй байдалд тогтоогоод орчихсон зүйл шүү дээ.

Б.Бейсен: Ж.Энхбаяр сайд 4 номерын микрофон.

Ж.Энхбаяр: Нэмэлт мэдээлэл өгье.

Өнөөдрийн байдлаар “Хөдөө аж ахуйг дэмжих корпорац” болон аж ахуйн нэгжүүдийн элеваторт нийт 100 орчим мянган тонн үр тариа, 20 мянган тонн бэлэн гурил байна.

Үндсэндээ нийт хэрэгцээний гуравны нэг нь энэ нөөцөөр хангагдахаар байгаа. Одоо нэмээд ургац залгаж байна.

Тэгэхээр яаралтай татваргүй, хязгаарлалтгүй орж ирж байгаа гурилын импортыг зогсоохгүй бол гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд нь ч хэцүү. Гурилын борлуулалт унаад. Тариалалт хийсэн үр тарианы компаниуд нь ч борлуулалтгүй бас нэг ийм байдал үүсээд.

Хэрвээ газар тариалангийн салбар унах юм бол тэрийг дагаж байгаа таримал тэжээлийн салбар уначихна. Тэжээл уначих юм бол энэ овоо өсөж байгаа гахай, тахиа, өндөг, энэ сүүний аж ахуйнууд чинь дагаад уначихна.

Ерөөсөө хөдөө аж ахуй өөрөө системийн хувьд цогц, туйлын эмзэг, их болгоомжтой л хандах ёстой байгаа юм.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд гүйцээж хариулья.

Ж.Энхбаяр: Үр тарианы тухайд жил болгон 100 мянган тонн үр тариа гэдэг маань нийт Монгол Улсын хэрэглэх үр тарианы гуравны нэг хувийг л улсын стратегийн нөөц хэмжээнд нөөцлөөд яваад байвал энэ тогтвортой байдлаа хангах юм.

Ганц үр тариа биш шатахуун байгаа юм. 3 сарын шатахуун.

Гуравны нэгийн хэрэглээний үр тариа хоёрыг л стратегийн нөөц болгоод.

Нэмэх нь эм, эмнэлгийн хэрэгсэл, эм бэлдмэл байгаа.

Сая чуулганы нээлт дээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллээр яаралтай стратегийн нөөцийг бүрдүүлэхэд Засгийн газар онцгой анхаарахгүй бол гадаад аюулгүй байдлын орчин ноцтой хүндэрч байгаа гэдгийг бүр онцгойлон сануулсан.

Тэгэхээр энэ дээр яам бодлогоо өгчихсөн. 100 мянган тонныг авъя гээд. Хадгалах сав нь бэлэн байгаа. Дотооддоо үлдэх юм шүү дээ. Энэ чинь мөнгөөрөө. Монгол төгрөгөөр худалдан авалт хийгээд дотооддоо бид.../минут дуусав/

Б.Бейсен: Ж.Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Үгүй үгүй ийм л юм байгаад байна л даа. Одоо хэдүүлээ энэ нэг жаал юм хийж байгаа, дам дамаа энэ үйлдвэрлэлд чинь орж байгаа орцууд нь өөрөө дандаа импортынх, дандаа үнэ өсөлттэй ийм аж ахуй эрхэлж байгаа юмнуудаа нэг жоохон дэмжихгүй бол наадах чинь явахгүй ээ.

Бүтээгдэхүүнийг нь урд оны 10 сард худалдаж авчхаад дараа оны 3 сард төлбөрийг нь хийдэг ийм зах зээлийн нийгэм байна уу? Аан?

Тэгээд наадхыг чинь хооронд 6 сар шахуу энэ улсууд зээлийн хүү төлөөд явж байгаа шүү дээ. Энэ хэдэн тариаланчид чинь.

Тэгэхээр одоо энэ төсвийн тодотголдоо ядаж 50 хувийнх нь мөнгийг тусгаж оруулж, тэгээд энэ улсуудынхаа тушаасан будааны 50 хувийнх нь мөнгийг өгөөд, 50 хувийг нь оны ард өгдөг хэлбэр лүүгээ орохгүй бол наадах чинь үнэхээрийн хүнд байна.

Тийм учраас би одоо зарчмын зөрүүтэй санал гаргаад хураалгаж болохгүй байна. Орлого, зарлага хоёр нь хоорондоо тэнцэл авдаг юман дээрээс альнаас нь.../минут дуусав/

Б.Бейсен: Цагаанхүүгийн Идэртбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Энэ төсөвтэй холбоотой ерөнхий агуулгаар нь дэмжиж байгаа.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр хэлэлцэх эсэх дээр саналаа хэлчихсэн.

Би хөдөө аж ахуйн салбартаа холбоотой юм руугаа л анхааръя гэж бодож байна. Хоёр юм байгаа.

Нэгдүгээрт, 122.7 дотроос өмнө нь олгогдчихсон “Шинэ хоршоо”-ны зээлийн санхүүжилтийн хүүгийн дотаци л явчихна. Одоо хүлээгдэж байгаа хүүгийн дотаци байхгүй юм байна гэж. Эндээс гарах боломжгүй юм байна гэж би сая таны тайлбараас ойлголоо.

Тэгэхээр ер нь яах вэ, салбарын хувьд энэ он гартал байдаг юм уу, энэ 2024 оноо дуустал байдаг юм уу, энэ “Шинэ хоршоо” хөтөлбөрөө зогцоох юм уу, түр цогцоох юм уу, он гаргаад үргэлжлүүлнэ гэх юм уу. Үүнийгээ бид тодорхой хэлэхгүй бол бидний асууж байгаа, хариулж байгаа энэ болгоныг хоршоо хийчих юмсан гээд олон хүн хараад сууж байгаа.

Тэгээд юм тодорхой байх нь хэн хэндээ амар гэж би нэгдүгээрт хэлэх гээд байгаа юм.

Хоёрдугаарт, хөдөө орон нутгаар явж байхад, ялангуяа Дорнодоор явж байхад **“Халх голын бүтээн байгуулалтын бүс”** гээд нэг зүйл яриад байгаа юм. Аль Р.Бурмаа сайдын үеэс л газрыг нь өгсөн.

Сүүлд 500 мянган га гээд л. Яг орон нутгийн иргэд дээр нь очихоор ямар ч мэдээлэлгүй, маш их үл ойлголцолтой нэг зүйл байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ төсвийн тодотгол дээр орж ирж байгаа төсөв нь хөдөлж байгаа хэдхэн зүйл, заалт дотор энэ **“Халх голын бүтээн байгуулалтын бүс”**-ийн нэг жоохон хөдөлгөөн байна л даа. 2.8 гээд. Зөрүү нь.

Энэ ер нь яг тэнд юу хийгдээд, ямар юм явж байгаа юм бэ?

Энэ **“Халх голын бүтээн байгуулалтын бүс”** гээд энд яригдаж байгаа. 2024 онд 689.5 тавигдаад л л явсан л юм байна.

Энэ дээр ер нь яг ямар бүтээн байгуулалтууд хийгдэж байгаа вэ? Одоо ямар үндэслэлээр. Энэ багахан л юм байна. Гэхдээ тэнд нэг юм хөдлөөд байгаа учраас тавигдаад байна л даа.

Тийм учраас би тодруулж асууж байгаа юм.

Б.Бейсен: Хариулъя. Сайд хариулъя. Хөдөө аж ахуйн яам.

Ж.Энхбаяр: Хоршоон дээр Хөдөө аж ахуйн яам энэ зээлээ нэгэнт эх үүсвэр дуусаж байгаа тул нэмэлт олгоод хүүний жоохон мөнгө нэмчихье гээд сая М.Ганхүлэг гишүүний гаргадаг 10 тэрбум гэдэг нь тэр.

Сангийн яам бол үүнийг шаардлагагүй ээ. Зээлийнхээ материалыг үргэлжлүүлэн хүлээж аваад, судалгаа явсаар байгаад он гарангуут зээл олголтоо хийе. Тэр болтол эх үүсвэр нэмэгдэхгүй.

Нэгэнт хууль болоод жил болгон 500 тэрбум гээд батлагдчихсан тул үүнийг өөрчлөх боломжгүй гэсэн байр суурьтай байгаа.

Тэгэхээр одоо бид орон нутагт ажиллахдаа зээлийнхээ материалыг өгөөрэй. Судалгаанд орно. Энэ жилийн эх үүсвэр дууссан. Ирэх онд 500 тэрбум төгрөг олгож эхэлнэ. Зээл оны нэг сараас олгоно гэж хэлж болох уу? Сангийн яамныхан. 2025 оноос. Тийм. 2025 оноос олгоно.

Одоо бүгдээрээ он дуустал судалгаагаа авъя гэдгээр л явахаас аргагүй. Одоо шинэ эх үүсвэр байхгүй гэсэн үг.

Халх гол дээр ямар нэгэн олигтой төсөв, зардал юу ч байхгүй. “Халх голын бүтээн байгуулалтын бүс” гээд нэг бүс нэр томьёо зарлагдсан. Түүн дээр 600 орчим сая төгрөгийн төсөвт өртөгтэй

захиргааны нэгж байгуулагдсан. Халх голд. Дорнодод байгаа.

Үндсэндээ ямар нэгэн үйл ажиллагаа явуулагдаагүй. Хэрхэх асуудлыг би тун удахгүй Байнгын хороонд оруулж ирнэ.

Ер нь Халх голын бүс нутгийг хөдөө аж ахуйн эргэлтэд оруулахын тулд бид туйлын болгоомжтой, туйлын шинжлэх ухаанч, их олон талаас нь ярьж байж шийдэх ёстой.

Тэгээд бид байр сууриа танилцуулна. Тэр үед Байнгын хорооны гишүүдэд сайхан дэлгэрэнгүй мэдээлэл өгье.

Төсөв дээр, тодотгол дээр ямар нэгэн хөдөлгөөн байхгүй. Хөрөнгө оруулалт ч байхгүй, идэвхжүүлэлтийн ямар нэг арга хэмжээ байхгүй байгаа.

Б.Бейсен: Ц.Идэртбат гишүүн тодруулъя.

Ц.Идэртбат: Хоёр дахь энэ хөдөө аж ахуйтай холбоотой асуудал миний хувьд энэ [“Отрын бүс нутгийн захиргаа”](#) гэж байгаа.

799.3 байж байгаад 141.4-өөр нэмэгдэж байна л даа. Энэ зөрүү нь 2024 онд.

Тэгэхээр энэ дээр ер нь отрын бүс нутаг өнгөрсөн Их Хурлын энэ Байнгын хороогоор отрын бүс нутгийнхаа асуудлыг нэг эргэж хараач гээд бүр ажлын хэсэг гаргаад, гишүүд явж танилцаад, энэ алслагдсан отрын бүс нутгуудтай бүр цахим хурлууд хийгээд олон юмыг нэлээн тодорхой болгосон.

Тэгээд тэндээс хойш ямар ч алхам хийгдэхгүй байгаад байгаа юм. Өвөл болоход отор нь нөгөө л нэг хэвээрээ бужигнаад л өвчин тараадгаараа явах юм уу, явахгүй юм уу. “Отрын бүс нутгийн захиргаа” гэж тэр Булган руу шилжүүлчихсэн хэдэн нөхөр тэнд байж байх юм уу, байхгүй юм уу? Ийм байгууллага байвал байлгахын дайтай байлгаад, байлгүй бол.../минут дуусав/

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулья.

Ж.Энхбаяр: Энэ отрын бүс нутаг гээд хуучин уламжилж ирсэн бүс нутгийг хамгаалалтад аваад, цаг уурын бэрхшээлийг даван туулахад зориулалтын дагуу ашиглаж байсан хэдий ч сүүлийн үед баруун аймгаас ирсэн нүүдэл, дээрээс нь мал өссөнтэй холбоотойгоор нэлээн олон бүс нутаг нь аль хэдийн эргэлтэд ороод байнгын айлын өвөлжөө, хаваржаа, зарим газар зуслангийн газар хувирчихсан байгаа.

Тэгэхээр энэ дээр дахин нэг мониторинг хийгээд шинээр бүс нутгаа отрынхоо нутгийг ер нь зүүн тийшээгээ л, саяын энэ Халх гол, Дорнод тал руугаа хадлан тэжээл бэлтгэх отрынхоо гол цөм болгож аваад, аймгуудын дунд орчихсон энэ завсрын отрын бүс нутгуудаа нэг эргэж харах шаардлага үүсчихсэн.

Тэгээд хасахыг нь хасаад, нэмэхийг нь нэмээд, үлдсэнийг нь хамгаалсан шиг хамгаалдаг нэг хатуу жоохон сахилга баттай байхгүй бол нэлээн л замбараагүйдүү явчихсан.

Тэгээд цаг хүндрэхээр шийдвэр гаргаад л тэгээд л оруулчихдаг.

Тэгээд дагаад л нөгөө.../минут дуусав/

Б.Бейсен: М.Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Би нэг тодруулга авах гэсэн юм. Түрүүн зөрүүтэй мэдээллүүд яваад байгаа учраас.

Бид нарт өчигдөр 8 сарын 19-нд өгсөн төсвийн тодотголын төслийн танилцуулгыг хараад сууж байгаа байхгүй юу.

Тэгээд энэ дээр уг нь тэр 126 тэрбум төгрөгийг тодорхойлж биччихсэн байна л даа. “Шинэ хоршоо” хөдөлгөөний зээлийн хүүгийн дотацид 46.7 тэрбум төгрөгийг шинээр тусгасан гээд оруулчихсан байгаа.

Тэгэхээр энэ зөрүүтэй мэдээлэл юм уу? Үүнээс хойш сая өөрчлөгдсөн мэдээллийг сайд маань ярьчих уу? Энэ дээр хариулт авах гэсэн юм.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулья. Дараа нь Сангийн яамныхан хариулах юм уу, үгүй юу.

Ж.Энхбаяр: Таны хэлсэн саяын тоо энэ хоршооны гишүүн малчинд олгох хөрөнгө оруулалтын зээлийн хүүгийн дотацийг “Цагаан алт” хөтөлбөрийн 23.5 хоёрыг хооронд нь нийлүүлээд тавьчихсан юм байна лээ.

Одоо би танд яриад байгаа нь тодотгол дээр 3 гол зардал байгаа.

Малчдын зээлийн хойшлуулалт 77.3, хоршооны гишүүн малчинд олгосон зээлийн хүүгийн дотаци 25.9, “Цагаан алт” хөтөлбөр хүүгийн дотаци 23.5 гэсэн 3 нийлээд 126.7.

Б.Бейсен: Болсон уу?

Ж.Энхбаяр: Одоо манайд хэрэгжих нь “Цагаан алт” хөтөлбөрийн 23.5 тэрбумын дотаци бүхий 300 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын болон эргэлтийн зээл, арьс шир, ноос ноолуурын салбарт олгогдоно. Энэ ондоо.

Хоршоо гээд үндсэндээ гараад дуусчаж байна. Малчны зээлийн хойшлох асуудал үндсэндээ ингээд зохицуулаад дуусчаж байгаа. Энэ хоёр нь.

Б.Бейсен: Хоёр асуулт асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, Сангийн яамныхнаас. Өнгөрсөн жилийн зуд. Жилийн жилд зуддаа үргүй зардал гаргаж байгаа шүү дээ. Үүний нийт төсөв хэд гарсан бол. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотой энэ жилийн төсөвт малчдын жижиг орон сууц гээд түрүүн ярьж байна лээ. Тэгээд өвөлжилтийн өвс, гэжээлийн бэлэн байдлыг хангах, малчдын битүү хашааны асуудал байж байгаа. Тэр говийн аймгууд дээр, Сүхбаатар аймагт амьдарч байгаа малчдын тэр сараалж хашаанд хүн байтугай мал нь хоригдож байна шүү дээ.

Энэ асуудал дээр ер нь цаашдаа битүү хашааны асуудлыг орон сууцын асуудалтай нь хамтдаа төсөвт тусгах юм уу? Энэ зээлдээ багтаах юм уу? Тийм асуудал хийхгүй хэчнээн зээл өгөөд ч мал нь хорогдоно шүү дээ.

Энэ дээр ер нь баримталж байгаа бодлого юу байна? Энэ төсөвт тусгах юм байна уу?

Хоёрдугаарт, Ерөнхийлөгчийн “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд энэ жилийн тэр жижиг, дунд үйлдвэр, газар тариалангийн чиглэлээр тавьсан төсвийг нэмэгдүүлэх боломж бий юу? Яагаад гэвэл дотоодын эх орныг хөрсөнд ургасан эрүүл хүнсээр хангахгүй бол хавдар маш ихсэж байна. 80 хувь нь хүнстэй холбоотой байна. Гений өөрчлөлттэй хүнстэй холбоотой хавдар залуужиж байна, ихсэж байна.

Тийм учраас “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд дотооддоо эх орныг хөрсөнд ургасан эрүүл хүнсээр хангах боломж ирэх жилийн төсөвт тэрийг нэмэгдүүлэх боломж байна уу?

Сангийн яам. 1 номер.
М.Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж.

Б.Бейсен даргын асуултад хариулъя.

Мал тооллогын дүн 6 сарын сүүлээр эцэслэж гарсан байгаа. Төсвийн хувьд яг энэ зудтай холбоотойгоор 2023 оны эцсээр гарсан зардал, мөн 2024 оны эцсээр гарсан зардлыг одоогоор хагас жилийн гүйцэтгэл дээр эхний байдлаар орж ирж байна.

Гэхдээ эцсийн байдлаар жилийн эцсийн дүнгээр гарч ирэхээр харагдаж байна.

Сангийн яамнаас тусгайлан зарцуулсан хөрөнгө гэх юм бол Засгийн газрын нөөц сан энэ жил 78.5 тэрбум төгрөг батлагдсан. Энэ зардал маань

үндсэндээ бараг бүхэлдээ цас, зудын гамшигт явсан байгаа.

Үүн дээр нэмээд ямар зардлууд орж ирэх вэ гэхээр Батлан хамгаалах яам, Хилийн цэрэг, Онцгой байдал, дээрээс нь Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас дайчилсан зардлууд маш их байгаа.

Эдгээр зардлууд нийлээд жилийн эцсийн тайлангаар, өөрөөр хэлбэл 2025 онд 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан хэлэлцэх үеэр албан ёсоор тоо нь орж ирнэ гэсэн тийм байдлаар явж байгаа.

Дараагийн асуудлын хувьд малчдад хашаа барьж өгөх талаар Сангийн яамнаас арай өөр байр суурьтай байгаа. Сангийн яамнаас илүү юу гэдэг юм энэ төсвийн нэг төгрөг болгоныг илүү үржүүлгийн хүрд байдлаар яаж арвижуулж олгож болох вэ гэдэг агуулгаар бид харж байгаа.

Өөрөөр хэлбэл арилжааны банкны өндөр арилжааны хүү болох 20 орчим хувийн хүүг яаж 6 хувь дээр ч юм уу, 8 хувь дээр аваачиж болох вэ. Энэ зөрүүг улсын төсвөөс яаж компенсац хийж олгох вэ.

Дээрээс нь малчид зээл авъя гэхээр барьцаа хөрөнгөгүй, авч болохгүй байгаа энэ асуудлыг яаж шийдвэрлэж чадах вэ гэдэг дээр бид илүү их ажиллах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Мөн Засгийн газраас “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг 4 сарын 24-ний өдөр энэ онд баталсан.

Мөн холбогдох хуулийг Улсын Их Хурлаас баталсан байгаа.

Энэ дагуу яг энэ юу гэдэг юм эрчимжсэн мал аж ахуйг байгуулах. Энэ хүрээндээ хашаа хороогоо янзлах, дээр нь худаг ус гаргах гээд энэ бүх бодлогын асуудлууд илүү бизнесийн чиглэлтэйгээр орж ирж, энэ хүрээндээ малчид аж ахуйгаа сайжруулах нь зүйтэй гэж Сангийн яамны хувьд үзэж байгаа.

Энэ жилийн хувьд одоо орж ирж байгаа бидний Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль буюу төсвийн тодотгол маань зөвхөн цөөхөн асуудлын хүрээнд орж ирж байгаа.

Энэ нь нэгдүгээрт хамгийн том үндэслэл маань юу вэ гэхээр шинэ Улсын Их Хурал 126 гишүүнтэй парламент байгуулагдсан. Ингээд хамтарсан Засгийн газар байгуулагдсан. Мөрийн хөтөлбөр батлагдсантай холбоотойгоор бид мөрийн хөтөлбөрийн 7 сарын 10-наас хойшоо энэ парламентын хийж хэрэгжүүлэх ажлын эхлэлийг төсвийн тодотголоор оруулж ирж байгаа.

2025 оны төсвийн тухай хуулийг бид 9 сарын 01-нээс өмнө, ажлын сүүлийн өдөр 8 сарын 30-нд таарч байгаа. 30-нд өргөн барина.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Санал хураалт явуулъя.

Монгол Улсын 2024 онд Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

М.Ганхүлэг гишүүнээс нэг санал ирсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад нэмэлтээр тусгасан малчин хоршооны зээл, “Цагаан алт” хөтөлбөрийн зээлийн хүүгийн дэмжлэгийг 10 тэрбумаар нэмэгдүүлэх гэсэн байна.

Үүнтэй холбоотой хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн зардлыг 10 тэрбумаар бууруулах гээд орж ирсэн байна.

Гишүүн тайлбарла даа.
М.Ганхүлэг гишүүн тайлбарла.

М.Ганхүлэг: Байнгын хорооны дарга аа, тайлбарлахаас гадна юу яагаад байна л даа. Ирц хүрэхгүй байгаад байна л даа.

18 гишүүнээс 6 гишүүн байхаар чинь санал орууллаа гээд үр дүн тодорхой болчихоод байна л даа.

Тэгэхээр одоо харин ямар зохицуулалт хийх ёстой вэ? Гишүүдээ

оруулж ирэх. Эсвэл дараагийн удаадаа санал хураалгадаг юм уу.

Б.Бейсен: Гишүүдээ дуудаж байна уу?

Гишүүд санал хураалт явагдаж байна. Байнгын хорооны гишүүд хуралдаандаа орж ирнэ үү.

М.Ганхүлэг гишүүний зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

38.9 хувиар дэмжигдсэнгүй.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Дараагийн хэлэлцэх асуудалд орёё.

Гурав. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

/Засгийн газар 2024.08.12-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулъя.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцуулъя.

Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн сайд, Э.Баттулга Байгаль орчин, уур амьсгал

өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, З.Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн газрын хэрэг эрхлэх агентлаг Усны газрын дарга, Н.Мандуул Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил дэд бүтэц асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Д.Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Б.Ганзориг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн газрын хэрэг эрхлэх агентлаг Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга, Д.Дэнчин Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцье.

Гишүүд Та бүхэн тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асуух болон зарчмын зөрүүтэй санал гаргаж болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүн байхгүй байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Монгол Улсын 2024 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хууль нэмэлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Төсвийн Байнгын хороонд. Ж.Батжаргал дарга байж болно, Г.Ганбаатар гишүүн байж болно. Эсвэл Т.Аубакир гишүүн байж болно. Одоо байгаа Г.Ганбаатар гишүүн Төсвийн байнгын хороонд танилцуулья.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүд баярлалаа.

Хуралдаан 3 цаг 56 минут үргэлжилж, 15 цаг 14 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

ЦАЛТАН-ОД